



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
2023 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 16-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

# ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах  
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

**НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
**2023 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр, Пүрэв гараг**

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	<i>1</i>
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	<i>2-9</i>
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	<i>10-75</i>
<hr/>	
<i>1. Хянан шалгах түр хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай /Төрийн болон орон нутгийн өмчит оролцоотой зарим компаниудын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх, хяналт шалгалтын тайланг Улсын Их Хуралд танилцуулах</i>	<i>14-18</i>
<hr/>	
<i>2. Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.10.13-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/</i>	<i>18-25</i>
<hr/>	
<i>3. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүдийг томилох, чөлөөлөх тухай асуудал</i>	<i>25-42</i>
<hr/>	
<i>4. “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2024 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Монголбанк 2023.09.24-ны өдөр ирүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i>	<i>42-74</i>
<hr/>	
<i>5. Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр нарын 3 гишүүн 2022.09.26-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i>	<i>74-75</i>

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы  
11 дүгээр сарын 16-ны өдөр /Пүрэв гараг/-ийн  
нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 72 гишүүнээс 37 гишүүн хүрэлцэн ирж, 51.4 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 11 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

*Томилоттой: Ш.Адьяа, Ц.Анандбазар, Х.Булгантуяа, С.Ганбаатар, Б.Жавхлан, Б.Жаргалмаа, Ц.Мөнхцэцэг, Н.Учрал, Л.Энх-Амгалан;*

*Чөлөөтэй: Ё.Баатарбилэг, Б.Баярсайхан, Л.Оюун-Эрдэнэ,;*

*Эмнэлгийн чөлөөтэй: Ж.Сүхбаатар;*

*Тасалсан: Т.Аубакир, Ж.Батсуурь, Д.Өнөрболор, Б.Саранчимэг, Ц.Сэргэлэн;*

*Хоцорсон: С.Амарсайхан-2 цаг 06 минут, С.Батболд-1 цаг 19 минут, Д.Батлут-03 минут, Э.Батиугар-1 цаг 30 минут, Д.Ганбат-14 минут, Н.Ганибал-35 минут, Ц.Даваасүрэн-22 минут, Г.Мөнхцэцэг-1 цаг 05 минут, М.Оюунчимэг-06 минут, Ш.Раднаасэд-39 минут, Д.Сарангэрэл-02 минут, Г.Тэмүүлэн-1 цаг 42 минут, Ч.Ундрам-15 минут, О.Цогтгэрэл-15 минут, Б.Энхбаяр-11 минут, Ж.Эрдэнэбат-18 минут.*

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, Н.Алтанхуяг нараас ирүүлсэн албан бичгийг танилцуулж, Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, Н.Алтанхуяг нар үг хэлэв.

***Нэг.Хянан шалгах түр хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай /Төрийн болон орон нутгийн өмчит оролцоотой зарим компаниудын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх, хяналт шалгалтын тайланг Улсын Их Хуралд танилцуулах/***

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх М.Отгон, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан Ахлах зөвлөх Мягмарцэрэн, референт Г.Баярмаа нар байлцав.

Тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Т.Доржханд танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням, Б.Бат-Эрдэнэ нарын тавьсан асуултад Эдийн засгийн байнгын хорооны дарга Ц.Цэрэнпунцаг хариулж, тайлбар хийв.

**Г.Занданшатар:** “Хянан шалгах түр хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 30

Татгалзсан: 16

Бүгд: 46

65.2 хувийн саналаар Тогтоол батлагдлаа.

*Уг асуудлыг 10 цаг 43 минутад хэлэлцэж дуусав.*

***Хоёр.Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.10.13-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр, Улсын ерөнхий прокурорын орлогч, Төрийн хууль цаазын шадар зөвлөх М.Чинбат, Цагдаагийн ерөнхий газрын Захиргаа удирдлагын газрын дарга Л.Нямдаваа, Тээврийн цагдаагийн албаны Зөрчил шалган шийдвэрлэх хэлтсийн дарга Ц.Чинзориг, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Хууль, тогтоомжийн хэлтсийн дарга Э.Бадамсамбуу, Хууль зүй, дотоод хэргийн сайдын зөвлөх Д.Мөнх-Эрдэнэ, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын ахлах шинжээч Ш.Цолмон, мөн газрын шинжээч Т.Нарантунгалаг, мэргэжилтэн Ц.Лхагвацэнд, Эрүүгийн хууль тогтоомжийн уялдаа холбоог хангах, боловсронгуй болгох чиг үүрэг бүхий Байнгын ажлын хэсгийн гишүүн Б.Гантуяа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ч.Батбямба, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Г.Золжаргал, референт П.Хулан нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Хууль зүйн байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Туваан, Ц.Даваасүрэн нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Ц.Сандаг-Очир, Тээврийн цагдаагийн албаны Зөрчил шалган шийдвэрлэх хэлтсийн дарга Ц.Чинзориг, Хууль зүй, дотоод хэргийн сайдын зөвлөх Д.Мөнх-Эрдэнэ нар хариулж, тайлбар хийв.

**Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

**Г.Занданшатар:** 1.Байнгын хорооны саналаар, Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 8 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“8.Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээд Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний акт зөрчсөнтэй холбогдуулан эрх бүхий этгээдээс оногдуулсан торгох шийтгэлийг хуульд заасан хугацаанд биелүүлээгүй бол тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн үнэмлэх авах, сунгах, ангилал нэмэх, өөрчлөх, нөхөн авах, тээврийн хэрэгслийн эзэмшлийн шилжилт хөдөлгөөн хийх эрхийг хязгаарлана. Хүн, хуулийн этгээд, эрх бүхий этгээдээс оногдуулсан торгох шийтгэлийг энэ хуулийн 3.5 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан хугацаанд биелүүлээгүй бол цагдаагийн албан хаагч тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг торгох шийтгэлийг биелүүлж дуусах хүртэл хугацаанд хязгаарлана. Энэ тохиолдолд тээврийн хэрэгслийн хуульд заасан журмын дагуу тусгай талбайд хүргэх, эсхүл бусад аргаар хөдөлгөөнийг нь хязгаарлана.” гэсэн саналыг редакцийн засвартайгаар дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн үг хэлэв.

Зөвшөөрсөн: 30  
Татгалзсан: 18  
Бүгд: 48  
62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

**Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

**Г.Занданшатар:** 1.Байнгын хорооны саналаар, Төслийн 2 дахь заалтын 21.9 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “Мөрдөн шалгах” гэсний өмнө “Шүүгч, прокурор, хууль сахиулагч, өмгөөлөгч,” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 31  
Татгалзсан: 17  
Бүгд: 48  
64.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

*Уг асуудлыг 11 цаг 12 минутад хэлэлцэж дуусав.*

***Гурав.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүдийг томилох, чөлөөлөх тухай асуудал***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Я.Содбаатар, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Хууль зүйн бодлогын зөвлөх А.Бямбажаргал, Улсын дээд шүүхийн Иргэний хэргийн танхимын тэргүүн Г.Алтанчимэг, Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга, нэр дэвшигч Л.Өлзийсайхан, Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэнгийн захирал, нэр дэвшигч О.Мөнхсайхан, Хууль зүй, дотоод хэргийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, нэр дэвшигч Э.Энхтуяа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх А.Золжаргал, референт П.Хулан нар байлцав.

Анх нэр дэвшүүлсэн Улсын Их Хурлын саналыг Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар, Ерөнхийлөгчийн саналыг Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Я.Содбаатар, Улсын дээд шүүхийн саналыг Улсын дээд шүүхийн Иргэний хэргийн танхимын тэргүүн Г.Алтанчимэг, Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт нар танилцуулав.

Нэр дэвшигчдээс болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатар, Д.Сарангэрэл, Б.Баттөмөр, Б.Бат-Эрдэнэ, Ц.Даваасүрэн, С.Одонтуяа, Ш.Раднаасэд, С.Бямбацогт, Ж.Батжаргал нарын тавьсан

асуултад нэр дэвшигч Л.Өлзийсайхан, Э.Энхтуяа, О.Мөнхсайхан нар хариулж, тайлбар хийв.

**Г.Занданшатар:** 1.Лувсандоржийн Өлзийсайханыг Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилохыг дэмжье гэсэн нууц санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 31  
Татгалзсан: 13  
Бүгд: 44  
70.5 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Одонхүүгийн Мөнхсайханыг Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилохыг дэмжье гэсэн нууц санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 29  
Татгалзсан: 15  
Бүгд: 44  
65.9 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Эрдэнээгийн Энхтуяаг Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилохыг дэмжье гэсэн нууц санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 31  
Татгалзсан: 13  
Бүгд: 44  
70.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар “Үндсэн хуулийн цэцийн гишүүдийг томилох, чөлөөлөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Эцсийн найруулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд эцсийн найруулгатай танилцлаа./12:24/

*Уг асуудлыг 12 цаг 25 минутад хэлэлцэж дуусав.*

***Дөрөв. “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2024 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Монголбанк 2023.09.24-ны өдөр ирүүлсэн, анхны хэлэлцүүлэг/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн, тус банкны дэд ерөнхийлөгч Г.Энхтайван, Ерөнхий эдийн засагч Д.Ган-Очир, Мөнгөний бодлогын газрын газрын захирал Б.Баярдаваа, Нөөцийн удирдлага, санхүүгийн зах зээлийн газрын захирал А.Энхжин, Банкны бүтцийн өөрчлөлт, бодлогын газрын Эрсдэлийн үнэлгээний хэлтсийн захирал Г.Борхүү, хэвлэлийн төлөөлөгч Д.Ариунаа, Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Мажигсүрэн, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Эдийн засгийн байнгын

хороо хариуцсан Ахлах зөвлөх Мягмарцэрэн, референт Г.Баярмаа, Хонгорзул нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрам, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл нар танилцуулав.

*Үдээс өмнөх хуралдаан 2 цаг 47 минут үргэлжилж, 12 цаг 58 минутад завсарлав.*

*Үдээс хойших хуралдаан 14 цаг 05 минутад эхэлж, Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар хуралдааныг даргалав.*

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Туваан, Э.Батшугар, Б.Баттөмөр, М.Оюунчимэг, Ц.Сандаг-Очир, Д.Ганбат, Ц.Идэрбат, Б.Бат-Эрдэнэ, Б.Пүрэвдорж нарын тавьсан асуултад Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн, Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Ч.Ундрам хариулж, тайлбар хийв.

*Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар 15 цаг 03 минутаас 15 цаг 39 минутад хуралдааны даргалав.*

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

**Г.Занданшатар:** 1.Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрам, Г.Амартүвшин, Б.Баттөмөр, Х.Ганхуяг, Т.Доржханд, С.Чинзориг /Цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Тогтоолын төсөлд 2 дугаар заалт нэмэх:

“2.Доор дурдсан арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/, Монголбанк /Б.Лхагвасүрэн/, Санхүүгийн зохицуулах хороо /Д.Баярсайхан/-нд тус тус даалгасугай:

1/Засгийн газраас эрх зүйн орчныг бүрдүүлж, орон сууцны ипотекийн хөтөлбөрийг шилжүүлэн авах хүртэлх хугацаанд хөтөлбөрийн тасралтгүй байдлыг хангаж, зээлийн эргэн төлөлтөөс санхүүжүүлэх;

2/Орон сууцны ипотекийн хөтөлбөрийн хүрээнд олгох зээлийн нийт эх үүсвэрийг нийслэл, орон нутагт тэнцүү хуваарилах,” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, С.Чинзориг нар үг хэлэв.

Хуралдаан даргалагчаас дээрх саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгч, санал хураалт явуулаагүй болно.

2.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар заалтад доор дурдсан агуулгатай 3 дугаар дэд заалт нэмэх:

“3/Агаар, орчны бохирдлыг бууруулах, төвлөрлийг сааруулах бодлоготой уялдуулан эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууц, гэр хорооллын барилгажуулалтад

олгох ипотекийн зээлийн хэмжээг хөтөлбөрийн нийт эх үүсвэрийн 20 хүртэл хувьд хүргэх арга хэмжээ авах.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт үг хэлэв.

Зөвшөөрсөн: 22  
Татгалзсан: 22  
Бүгд: 44  
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

3.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн хавсралтын 1 дүгээр заалтад доор дурдсан агуулгатай 1.3 дахь заалт нэмэх:

“1.3.Эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангаж, ажлын байрыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор бизнесийн зээлийг нэмэгдүүлэх, хэрэглээний зээлийн хэт өсөлтөөс сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж үг хэлэв.

Зөвшөөрсөн: 26  
Татгалзсан: 19  
Бүгд: 45  
57.8 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн хавсралтын 2 дугаар заалтад доор дурдсан агуулгатай 2.4 дэх заалт нэмэх:

“2.4.Банкнаас жижиг, дунд бизнест олгосон зээлийг ангилах, ангилал дээшлүүлэх, түүний бүтцийг өөрчилж, дахин санхүүжүүлэх зохицуулалтыг эрсдэлд суурилсан хяналт шалгалтын зарчимд тулгуурлан уян хатан болгох ажлыг судлан шийдвэрлэх;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 25  
Татгалзсан: 20  
Бүгд: 45  
55.6 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн хавсралтын 3 дугаар заалтад доор дурдсан агуулгатай 3.3 дахь заалт нэмэх:

“3.3.Тогтвортой хөгжлийн зорилтын таксономид органик хүнсний тариалалт, үйлдвэрлэлийн үйл ажиллагааг тодорхой тусгаж, төрийн дэмжлэгтэй хэрэгжиж буй зээл, санхүүжилтийн хөтөлбөрүүдийн багцын тодорхой хэсгийг тухайн таксономитой уялдуулан ногоон, тогтвортой зээл гаргадаг болох чиглэлээр санхүүгийн байгууллагуудтай хамтран ажиллах;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 26  
Татгалзсан: 18



Бүгд: 44  
59.1 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн бүтэц, нэр томьёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаар, эшлэлийг нийцүүлж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 26  
Татгалзсан: 18  
Бүгд: 44  
59.1 хувийн саналаар дэмжигдлээ.

“Төрөөс мөнгөний бодлогын талаар 2024 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

*Уг асуудлыг 15 цаг 36 минутад хэлэлцэж дуусав.*

***Тав.Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр нарын 3 гишүүн 2022.09.26-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтсийн дарга И.Батчулуун, Мал эмнэлгийн ерөнхий газрын Мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах газрын дарга Б.Болдбаатар, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Орчны бохирдол, хог хаягдлын удирдлагын хэлтсийн дарга Б.Мөнх-Эрдэнэ, мэргэжилтэн Б.Мөнхжаргал, Нийслэлийн Мал эмнэлгийн газрын Мал, амьтны эрүүл мэндийн хэлтсийн дарга Ц.Гантөмөр, Азтай савар Төрийн бус байгууллагын тэргүүн Ц.Зориглон, мөн байгууллагын Удирдах зөвлөлийн гишүүн Ц.Болормаа, эрх зүйч Э.Анударь нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Д.Нарантуяа, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо Ахлах зөвлөх Мягмарцэрэн, референт Г.Баярмаа нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн санал хураалтыг Баасан гарагийн 10.00 цагт явуулахаар тогтов.

*Уг асуудлыг 15 цаг 44 минутад хэлэлцэж дуусав.*

**Бусад.** Улсын Их Хурлын гишүүн Б.Дэлгэрсайхан, Т.Энхтүвшин нарын урилгаар Дорноговь аймгийн Сайншандын төмөр замын ангийн хамт олон, Улсын Их Хурлын гишүүн Г.Ганболд, Д.Тогтохсүрэн, С.Чинзориг нарын урилгаар Өвөрхайнгай аймгийн Насан туршийн суралцахуйн төвийн багш, ажилчид Төрийн ордон, Улсын Их Хурлын чуулганы үйл ажиллагаатай танилцав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 5 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

Хуралдаан 4 цаг 26 минут үргэлжилж, 72 гишүүнээс 54 гишүүн хүрэлцэн ирж, 75.0 хувийн ирцтэйгээр 15 цаг 44 минутад өндөрлөв.

**Тэмдэглэлтэй танилцсан:**  
ЕРӨНХИЙ НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГА

Л.ӨЛЗИЙСАЙХАН

**Тэмдэглэл хөтөлсөн:**  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН

2023 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр,  
Пүрэв гараг  
Төрийн ордон “Их хуралдай” танхим  
10 цаг 11 минут

### НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

**Г.Занданшатар:** Улсын Их Хурлын гишүүдийн өдрийн амгаланг айлтгая. Гишүүдийн ирц бүрдсэн тул Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 11 дүгээр сарын 16-ны өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

1 дүгээрт.Хянан шалгах түр хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай асуудал

2 дугаарт Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлэг зарчмын зөрүүтэй 2 саналтай.

3-д Монгол Улсын Үндсэн хуулийн үеийн гишүүдийг томилох, чөлөөлөх тухай асуудал

4-д “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2024 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл, анхны хэлэлцүүлэг, б зарчмын зөрүүтэй саналтай

5 дугаарт Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэнэ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13.4-д заасны дагуу Улсын Их Хурлын даргад нэгдсэн хуралдаан

эхлэхээс өмнөх өдрийн 17 цагаас өмнө үндэслэл бүхий саналаа бичгээр ирүүлсэн Улсын Их Хурлын гишүүн Бөхчулууны Пүрэвдорж, Норовын Алтанхуяг нар үг хэлэхээр мэдүүлсэн байна. Бөхчулууны Пүрэвдорж гишүүн үг хэлнэ.

**Б.Пүрэвдорж:** Монгол Улсад Хүний эрхийн асуудал бол нэлээн хүнд түвшин рүүгээ орж эхэлж байна. Ер нь хаа сайгүй хүний эрхийн зөрчил гарч байна. Ялангуяа эрх баригчдыг шүүмжилсэн шүүмжлэлтэй холбоотойгоор тэр хүмүүсийн амыг хаах, авлигадах, дээрээс нь янз бүрийн байдлаар цагдаа, тагнуул, бусад байгууллагуудаар дарамтлуулах ийм зүйлүүд маш их гарч байна. Тэрний нэг илрэл нь бол цэргийн дэглэлт, цэргийн олон хүүхдүүд нас барсантай холбоотой асуудлууд байгаа. Тэгээд тэр саяхан нас барсан тэр хүүхдийн асуудал өнөөдөр эргэлзээтэй хэвээрээ байна. Яагаад эцэг эхэд нь хэлэлгүйгээр задлан шинжилгээ хийдэг юм. Тийм ээ, энэ чинь бол ноцтой асуудал шүү дээ. Энэ чинь бол 1 дүгээрт, Хүний эрхийн хамгийн дээд зэргийн дээрлэлт энд явагдаж байна гэсэн үг байхгүй юу даа. Эцэг эхэд нь асуудлыг танилцуулахгүйгээр энэ асуудлыг ингээд явж байна гэдэг бол. Тэгээд тэр орой тэр хүүхдийн эмээ над руу залгасан. Шөнө болсон хойно. Энэ асуудлуудыг хэлж өгөөч, тэр Сайханбаяр гэдэг хүнд ярьж өгөөч эд нар гээд. Тэгээд энэ асуудлыг дамжуулах гэхээр утас нь болохгүй иймэрхүү л байдалтай байна. Тэгээд өнөөдөр ийм ганцхан хүүхдийн асуудлыг, тэр үхлийнх нь шинжилгээний асуудлыг маш хурдан гаргаад, хурдан хурдан шийдвэр гаргах боломж байгаа шүү дээ. Гэтэл энэ дээр албан тушаалтнууд саад болоод байгаа юм байлгүй. Янз янзын байдал үүсээд байгаа. Тэр цэргийнхээ тэнд казарм болон бусад нийгмийн асуудлыг тэр хааж байгаа тэр байгууллагынх нь орчин тойрны асуудлыг шийдвэрлэхийн оронд өөрсдөө энэ зунжингаа Их Хуралд дэвшинэ гээд бүх цэргийн ангийг тэр чигээр нь хэдэн 100 хүнтэй, хэдэн 100 хүнтэй тэнд

Архангайд ажиллаад явж байлаа шүү дээ. Би Архангайд очиж ажилласан. 2, 3 сум дээр зун явахад сум дээр ирээд бүх хоол ундыг нь бүгдийг нь хийлгээд бүх хүмүүсийг ажиллуулаад л тэр 3, 400 цэргийн албан хаагч нар нь бушуухан шиг гэртээ харих юм сан гэсэн яриатай ийм байдалтай зунжингаа цэргийн төсвийн мөнгөөр сонгуулийн ажил хийсэн шүү дээ. Тэр мөнгөөрөө тэр хүүхдүүдийн казармын орчин тойрныг засахгүй яасан юм. Ийм байдлаар төрийн мөнгийг хувьдаа, сонгуульдаа ашигладаг ийм зүйл хэрээс хэтэрчхээд байна. Аймгийн дарга нар хэдэн хэдэн тэрбумаар нь хөрөнгө мөнгө тавьчхаад, энд тэнд хөдөө орон нутагт ажилладаг, сайд нар нь баахан хөрөнгө мөнгө тавьчхаад хөдөө орон нутгаасаа тэндхийн өөрийнхөө тойргийн хүмүүсийг ЖДҮ-чин, ЖДҮ-н болон малчин, эмч гээд бүх хөрөнгөөр нь төрийн мөнгөөр авчирч энд семинар уулзалт хийдэг. Тэрүүгээрээ буцаагаад чамайг би хотод авчирч үнэгүй хот үзүүлсэн, буудалд байлгасан, сайхан хоол идүүлсэн, тор дүүрэн бэлэг өгсөн. Чи намайг заавал очоод амьтан ах дүү нартаа хэлээд намайг сонгуулна шүү гэдэг ийм байдал чинь хэрээс хэтрээд байна шүү дээ. Үүний оронд өөрсдийнхөө тэр ажиллаж байгаа салбарынхаа нийгмийн асуудлыг шийдвэрлэх талаар ерөөсөө сэтгэл гаргаж ажиллахгүй байна шүү дээ.

Тэгээд одоо 7 хоногоор сургалт семинар хийдэг ийм зүйл одоо хэрээс хэтэрчхээд байна. Төрийн мөнгө уйлдаггүй гэдгийг өнөөдрийн та нарын үйлдэл бүгдээрээ л харуулж байна шүү дээ. Төрийн мөнгө уйлдаггүй. Ард түмэн уйлаад байна. Гэтэл төрийн мөнгө уйлдаггүй гээд л бүх хөрөнгө мөнгийг өөрсдийнхөө сонгуульд зарцуулдаг ийм зүйл чинь хэрээс хэтэрч байна. Одоо би цаашдаа энэ сайд дарга нарын хийж байгаа төсвийн зардлыг бүгдийг нь яг тэр хувьдаа зарцуулж байгаа хувийнхаа эрх ашгийн төлөө сонгуулийнхаа төлөө зарцуулж байгаа тэр бүх зүйлийг гаргаж тавина. Манай намын дарга нар

чимээгүй байж бай гээд байгаа юм. Чимээгүй байж байтал ард түмэн сонгох юм гэнэ ээ. Ард түмэн дургүйцлийн эцэс дээр хүрчихсэн байж байхад ард түмэнтэйгээ нэг талд байхгүй энэ нам чинь яаж хүмүүсийн итгэлийг авах юм. Бүх түвшинд бүгдээрээ энэ Ардын намынхны.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн 17 минут 31 секунд хоцорлоо. Цагтаа ирж бай. Өглөө босож бай. Одоо Норовын Алтанхуяг гишүүн.

**Н.Алтанхуяг:** Би Пүрэвдорж гишүүнтэй бас санал нэг байгаа юм. Жаахан ажил хийхгүй юм уу та нар. Энэ сонгуульд бэлдээд л ерөөсөө газар сайгүй төсвийн мөнгөөр л ерөөсөө сонгуульд бэлдээд байх юм. Тэр Батлан хамгаалахын сайд нь тэр цэрэг ямар байсныг би мэднэ гэж. Сайдын мэддэг 1 ширхэг цэрэг байхгүй шүү дээ. Тэгээд танай бүлэг, засаг 60 хэдэн хүнтэй та нар арга хэмжээ авахгүй юм уу. Тэр сайд даа. Тайван цагт маш олон ардын хүүхдүүд үхэж үрэгдэж байна шүү дээ. Хүүхдээ цэрэгт явуулсан болохоос биш оршуулгын газар явуулаагүй юм байгаа биз дээ. Та нар арга хэмжээ аваарай.

Одоо 1 дүгээр асуудал би ярья. Төсөв баталчхаад та нар их баяр баясгалантай суугаад байна. Тийм юм байхгүй. Цаана чинь ард түмний амьжиргаа ахуй улам дордсон. Энэ төсөв батлагдсанаар ард түмний ахуй амьжиргаа ширхэг ч дэм болохгүй. Харин нэрмээс болно. Төсвийг та нар нохойн амаар нийлүүлээд л тэгээд л нэг юм хаялаа даа. Нохой амаараа нийлүүлсэн хана ер нь яадаг билээ. Монгол төрийн бодлогын хана ер нь их нохой амаараа нийлээд яваад байна. Буруу байна. Зас та нар энийгээ. Одоо ингээд нэг хууль баталчхаад л гавьяа байгуулчихсан юм шиг суух юм. Төсвийн хууль Монголыг дампууруулах хууль баталсан. Төрийн өмчийн өчнөөн байшин сав барина гэсэн энэ чинь дахиад л зардал өсгөж байгаа

юм. Дахиад л гадаадаас баахан юм л худалдаж авна. Ард иргэдийн ахуй амьжиргаа, үнийн өсөлт, хазаарлах мазаарлах ширхэг ч юм ороогүй. Монгол банкны чинь мөнгөний бодлого чинь төсвийн бодлоготой чинь уялдаагүй. Төсөв нь тэлээд баахан мөнгө гаргаад явж байдаг. Монгол банк нь инфляцаа багасгана гээд сууж байдаг. Ямар гээч хүмүүс энд суугаад байгаа юм би ойлгохгүй байна.

Тогтворжуулалтын санг би хэлсэн. Хүрэлбаатар гэж нэг худал хэлдэг нөхөр байгаа шүү дээ. Дандаа худлаа ярина. Тогтворжуулалтын санг алаад идчихсэн. Ирээдүйн өв санг алаад идчихсэн. Ирээдүй өв санд хүүхдийн мөнгө рүү баахан юм аваад хэрэглэхээд, тэрний үлдэгдлийг өсгөхгүй байгаа юм. Зөвхөн ханишны уналтаас 700 тэрбум төгрөгийн алдагдал хүлээж байгаа. Үгүй ээ, та нар ер нь юу хийж суудаг юм бэ. Одоо энэ Жавхлан, Хүрэлбаатар 2-ын үгийг бурхны үг гэж ойлгоод байгаа юм уу. Энэ 2 чинь бол улсыг чинь дампууруулж байна шүү дээ. Танай бүлэг авч хэлэлцээч ээ.

Тийм учраас энэ асуудлаа хэдүүлээ хаахгүй шүү. Би байнга ярина шүү. Би худлаа хэлэхгүй шүү. Би бүх юмыг чинь цаасан дээр байгаагаар нь харуулаад хэлнэ.

2 дугаарт нь энэ хотын дарга болсон Нямбаатар нөгөө шударга ёс тогтоож өгнө гэсэн нөхөр маань түгжрэл янзлах гээд явж байх шиг байх юм. Би одоо Хууль зүйн байнгын хорооны гишүүн бас овоо юм хийх юм байх гэсэн, хаячхаад алга боллоо. Тэгснээ захиргааны аргаар юм шийдэх гээд байна. Танай бүлэг энэ дээр хуралдаач ээ. Одоо нөгөө 100 мянган хүний санал яасан бэ Занданшатар дарга аа. Би ерөөсөө ойлгохоо байлаа. Монголын төрийн бодлогыг. 100 мянган хүн хуйлраад л НӨАТ-ын санал өгөөд л ингэсэн байхгүй. Дахиад одоо цаана чинь тэр Оюунгэрэл манай гишүүн сайд байсан хүн асуугаад

явж байна. Энэ түгжрэлийг шийдэх гэж байгаа арга, гэр хорооллыг орон сууцжуулах гэж байгаа арга зам зөв үү, буруу юу. Би энийг бол асуудлыг шийдэх гэж байгааг нь бол зөв гэж байгаа юм. Асуудлыг шийдэж байгаа арга зам чинь буруу байна. Торгоно, цавчина, хорино, гянданд хийнэ, ална, оршуулна. Одоо болиоч дээ та нар. Гэр хорооллыг орон сууцжуулна гэдэг чинь зах зээлийн эдийн засагт нийцсэн байдлаар шийдэх ёстой. Эдийн засгийн арга механизмаар шийдэх ёстой. Энэ түгжрэлийг чинь бас тэгж шийдэх ёстой. Үгүй ээ, яаж тэгээд хотын төв рүү орж ирээд эмнэлэг, сургууль нь бүгдээрээ үгүй ээ, хажуу талын энд нэг эмнэлэг байгаа шүү дээ. Энэ рүү хүртэл орж ирдэг юм байгаа биз дээ. Үгүй ээ, яагаад ярьдаггүй юм бэ та нар. Ядаж та нар хоорондоо ярь л даа. Би Ардын намын бүлгээс гуйж байна. Ард иргэдээ сонс л доо. Хүмүүсийн ахуй амьжиргааг хар л даа. Ерөөсөө сонгууль гээд хуйлраад байх юм. Тойрог дээр очоод л ажиллаад л байх юм. Бүр нэгнийхээ тойрог дээр очоод л, нөгөөдхөө муулаад л ажиллаад байх юм. Боль л доо та нар. Тэгээд төгсгөлд нь би 14 хонож байна Занданшатар дарга аа. Энэ жилийн утаа, энэ жилийн түли. Ямар түли хэрэглэх юм бэ, яах юм бэ. Ард иргэдээ мэдээлэлжүүлээд өгөөч ээ. Үр хүүхдүүдээ хамгаалъя гээд цаад чинь хэлээд байна. Та нарыг шийдэл хийж чадахгүй бол ядаж сургууль соёлынхоо Энх-Амгалан сайд алга байна. Сургууль соёлынхоо амрах хуваарийг нь уртхан болгоод өг л дөө. Хүүхдүүдээ аваад жаахан ийшээ тийшээ явъя гэж байна шүү дээ. Үгүй ээ, яагаад энийгээ хийдэггүй юм. Бүр 14 хоног гээд тэгж ярьсан юм уу. Тийм солиотой юм байдаг юм уу?. Танай бүлэг нэг жаахан ажлаа хийгээд өг л дөө. Ард түмнээ нэг бодоод өг л дөө. Юу яасан.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Гишүүд үг хэлж дууслаа. Өнгөрсөн даргын дэргэдэх зөвлөл дээр Улсын Их Хурлын гишүүн, Ардчлсан намын бүлгийн дарга Цогтгэрэл гишүүн өөрийнх нь тавьсан

тэр утаа түлштэй холбоотой асуулгын хариу сонсъё гэж санал тавьсан л даа. Тэгээд энэ 7 хоногт бол Ерөнхий сайдын мэдээллийн цагтай учраас ирэх 7 хоногт хэлэлцэж болох юм гээд бид нар бас ярьсан байгаа. Тэгээд маргааш даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар ирэх 7 хоногийн асуулгын хариу ямар асуулгын хариу сонсохыг шийднэ. Тэр дээр хэлэлцье.

Хүний эрхтэй холбоотой асуудлаар та бүхэнд өнөөдөр ийм материал тараагдсан байгаа. Парламент ба хүний эрх, парламентын жендерийн мэдрэмжтэй байдлын үнэлгээ гээд. Энэ ер нь хүний эрхтэй холбоотой асуудлаар манай Хүний эрхийн дэд хороо, Хууль зүйн байнгын хороо олон удаа хуралдаж, Хүний эрхийн Комисстэнэ бүхий л орчинд үнэлгээ хийж, шаардлагатай арга хэмжээ авах үүрэг даалгаврууд өгөгдсөн. Хүний эрхийн Комисс ажлаа хийхгүй байна. Хууль зүйн байнгын хорооны дарга хаачив. Хүний эрхийн дэд хорооны дарга хаачив. Одоо энийгээ хуралдуулж, шаардлагатай бол арга хэмжээ ав. Хүний эрхийн Комиссын дарга, удирдлагууд нь ажлаа хийхгүй байгаа бол. Олон Улсын Парламентын холбоо Хүний эрх, жендерийн эрх тэгш байдлын зарчим, хэм хэмжээ, механизмыг улс орнуудын парламент хэрхэн хэрэгжүүлж байгааг үнэлэхэд зориулан парламентын үнэлгээний аргачлалыг НҮБ-ын Хүний эрхийн дээд комиссарын газрын болон бусад байгууллагууд хамтран боловсруулаад, үе шаттайгаар хэрэглээнд нэвтрүүлж байгаа. Монгол Улсын Их Хуралд бол энэ төлөвлөгөө, чиг үүрэг ирсэн. Хүний эрх, жендерийн асуудал бол Монгол Улсын Их Хурлын стратеги төлөвлөгөөнд Улсын Их Хурал төлөөллийн чиг үүргээ үр дүнтэй хэрэгжүүлж, үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах, парламентад итгэх иргэдийн итгэлийг бичүүлэх гэсэн бодлогын 3 дугаар зорилгод Хүний эрх, жендерийн асуудал хамаарч байгаа. Ийм учраас 2022 оны 8 дугаар сард ОУПХ болон Монгол Улсын

Их Хурал харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурсан юм байна. Манай Хүний эрхийн дэд хорооны дарга, манай Олон Улсын Парламентын хорооны гишүүд дарга нар Учрал сайд, гишүүн, Саранчимэг гишүүн гээд олон гишүүд яваад гарын үсэг зураад ирсэн. Тэгээд хамтын ажиллагаа нь бол Хүний эрх, жендерийн мэдрэмжтэй парламентыг бүрдүүлэх замаар парламентын шийдвэр үйл ажиллагааны үр нөлөөг сайжруулахад чиглэж байгаа. Энэ хүрээнд ОУПХ-ны боловсруулсан аргачлалаар парламентын хүний эрхийн болон жендерийн мэдрэмжийн асуудлаар 2 төрлийн үнэлгээг ирэх 7 хоногт хийнэ. 11 дүгээр сарын 22, 23-ны өдрүүдэд буюу Лхагва, Пүрэв гаргуудад манай Их Хурлын “Их эзэн Чингис Хаан” танхим “Жанжсин Д.Сүхбаатар”-ын танхимуудад ОУПХ хамтран зохион байгуулах гэж байна. Ирэх 7 хоногт ОУПХ-ноос олон улсын зөвлөхүүд ирж, Хүний эрхийн болон жендерийн мэдрэмжийн үнэлгээг зохион байгуулахад туслалцаа үзүүлнэ. Хүний эрхийн үнэлгээний хувьд олон улсын хэмжээнд бол анх удаа Монголд хийх гэж байна. Харин жендерийн асуудлаарх үнэлгээг өмнө нь Швед, Турк, Бангладеш, Руанда, Чили, Уганда, Кени, Танзани, Гүрж, Их Британи, Колумби, Серби улсуудын парламентад хийж байсан юм байна. ОУПХ-ноос. Энэ удаа бол ОУПХ-ноос Монгол Улсад хүний эрхийн талаар ярьж ажиллана.

Манай Улсын Их Хурал, түүний Тамгын газарт хийх өөрийн үнэлгээ нь Монгол Улсын Их Хурлыг Хүний эрх, жендерийн мэдрэмжийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр илүү үр дүнтэй ажиллахад дэмжлэг үзүүлэх үндсэн зорилготой гэж ойлгож болно. Үнэлгээний зөвлөмжөөс холбогдох асуудлыг Улсын Их Хурал бас дараагийн 2025-2028 онд баримтлах стратеги төлөвлөгөөндөө тусгана. Одоогийн бидний төлөвлөгөө бол 2020-2024 онд баримтлах үндсэн төлөвлөгөөнд энэ асуудал тусаад явж байгаа. Хууль,

тогтоомжид шаардлагатай өөрчлөлт, шинэчлэл хийх зөвлөмжүүд бас ирнэ. Ийм учраас Улсын Их Хурлын гишүүд энэ үнэлгээний хөтөлбөр, холбогдох гарын авлага, парламентын судалгааны хүрээлэнгээс үнэлгээний асуултын хүрээнд боловсруулсан тойм судалгаа бүхий эмхэтгэлийг та бүхэнд хүргүүлсэн байгаа. Ширээ ширээнд хүргүүлсэн. Тэгээд энэ үнэлгээнд та бүхнийг идэвхтэй оролцохыг хүсье. Ялангуяа манай Улсын Их Хурлын даргын захирамжаар байгуулагдсан Хүний эрхийн дэд хорооны дарга Мөнхцэцэгээр ахлуулсан энэ үнэлгээг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх ажлын хэсэг болон үнэлгээнд холбогдох илтгэл танилцуулгыг хийж оролцох Улсын Их Хурал дахь олонх, цөөнхийн төлөөллийг төлөөлж буй гишүүд маань энэ 2 өдөр ирцээ хангаж идэвхтэй оролцохыг хүсье. Холбогдох мэдээллээ хийж идэвхтэй оролцохыг хүсье.

Үүний өмнө Хүний эрхийн дэд хороо Хүний эрхийн асуудлаар хуралдаж, өмнө өгсөн үүрэг даалгаврынхаа хэрэгжилтийг шалгана. Олон үүрэг даалгавар өгсөн билээ. Цэрэгтэй холбоотой асуудал, хүүхдийн эрхийн асуудал, Улсын Их Хурлын тогтоол хүртэл батлагдсан. Хүний эрхийн Комиссын энийг хэрэгжүүлэх үндсэн үүргийг хянан шалгалт хийх үүргүүдийг авсан. Хэрэгжилт хангалтгүй байна гэж үнэлж байгаа.

Хэлэлцэх асуудалдаа оръё.

**Одоо “Хянан шалгах түр хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” асуудлыг хэлэлцэнэ.**

Төслийн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Тогмидын Доржханд танилцуулна. Индэрт урьж байна.

**Т.Доржханд:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурал 2023 оны 7 дугаар сарын 6-ны өдөр Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Их Хурлын тухай болон Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн хүрээнд төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой зарим компаниудын нүүрс олборлолт, борлуулалт, тээвэрлэлт, экспортын үйл ажиллагаа болон бусад бараа, ажил, үйлчилгээ, худалдан авалтын үйл ажиллагаанд хянан шалгалт хийх, нотлох баримтыг шинжлэн судлах нээлттэй сонсгол зохион байгуулах, иргэд олон нийтийг мэдээллээр хангах, хяналт шалгалтын тайланг Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы хугацаанд багтаан танилцуулах үүрэг бүхий Хянан шалгах түр хороо байгуулах тухай Улсын Их Хурлын тогтоол баталсан билээ.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ 2023 оны 11 дүгээр сарын 8-ны өдөр тус хянан шалгах түр хорооны бүрэлдэхүүнд орох хүсэлтээ ирүүлсэн бөгөөд Эдийн засгийн байнгын хороо Монгол Улсын Их Хурлын хянан шалгалтын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.4 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 93 дугаар зүйлийн 93.1 дэх хэсэгт заасныг баримтлан Хянан шалгах түр хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг 2023 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн хуралдаанаар хэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийн хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн Т.Доржханд, Хянан шалгах түр хорооны бүрэлдэхүүнд Улсын Их Хурлын нэр бүхий гишүүдийг нэмж оруулах боломжийн талаар асуулт асууж, хариулт авсан бөгөөд Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх “Хянан шалгах түр хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их

Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Хянан шалгах түр хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж, тогтоолын төслийг баталж өгөхийг та бүхнээс хүсье ээ. Анхаарал тавьсанд баярлалаа.

**Г.Занданшатар:** Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асууж, үг хэлэх гишүүн байна уу. Дамдинням гишүүнээр тасаллаа. Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн асуулт асууна.

**Б.Бат-Эрдэнэ:** Баярлалаа. Та бүхнийхээ өглөөний амгаланг айлтгая. Нүүрсний түр хорооны бүрэлдэхүүнд ямар учир шалтгаанаар өөрчлөлт оруулаад байна. Анх Гочоогийн Ганболд гишүүн ахалсан түр хороо байгуулагдаад ингээд явж байгаад тэгээд сүүлд нь Нямбаатар ахлаад, одоо Б.Энхбаяр гишүүн ахлаад ямар ч байсан ахлагч дарга нар нь хэд хэдэн удаа л солигдчихлоо. Тэгээд өнөөдөр энэ байдлыг харах юм бол нүүрстэй холбоотой асуудлыг шүүх хэчнээн сараар хойшлогдоод байх юм.

Их Хурал дээр шинэ батлагдсан хууль, эрх зүйн хүрээндээ нээлттэй сонсголыг нэг үр дүнтэй зохион байгуулаад хийгээд өгмөөр байна. Тэгээд ямар учир шалтгаанаар ийм өөрчлөлтүүд ороод байна гэж. Тэгээд энэ нүүрсний худалдан авалттай холбоотой юм чинь бол одоо ч яригдаж байгаа эд биш шүү дээ. 2012-2016 онд нүүрсний асуудал яригдаад хэд хэдэн хүмүүс ял аваад, ингээд явж байсан. Дахиад одоо яригдаж байна. Ялангуяа төрийн өмчит ЭГТ-той холбоотой. Ер нь анх байгуулагдсан цагаас л үе үеийн

захирлууд нь хэрэг асуудалд холбогдсон. Зарим нь одоо гадаадад зугтаагаад гарчихсан. Энэбиш гэж хүн байсан санагдаж байна. Их Хурлын Тамгын газрын дарга байсан хүн шүү дээ. Тэгээд одоо гараад явчихсан. Тэр хүнийг нөгөө шувуу ажиллагааны хүрээнд олж ирсэн үү, олж ирээгүй юу. Тэгээд иймэрхүү байдалтай л байх юм. Тэгээд энд бол энэ ээлжилж засаг барьж байсан, хамтарч барьж байсан Ардчилсан нам, Ардын нам 2 одоо аль алин руугаа бие бие рүүгээ чихээд байх юм энд байхгүй ээ. Одоо бидний үе үеийн парламентад бас 4, 5 удаа сууж ажиллаж байгаа хүмүүсийн хувьд бол энийг чинь сайн мэднэ шүү дээ. Яах вэ, энэ 2020 оноос байгуулагдаж ажиллаж байгаа Их Хурал, Засгийн газрын үед бол авлига, хулгайтай холбоотой асуудлыг илрүүлэх, энд хариуцлага тооцох, энэ 2024 оны сонгуулиас эхлээд ямар ч байлаа гэсэн төрийн эрх барих дээд байгууллагад ажиллаж байгаа энэ хүмүүсээс эхлээд ашиг сонирхол, авлига, хулгайн аливаа юманд оролцохооргүй байх тэр хууль, эрх зүйн шинэ зохицуулалтуудыг хийчихсэн ийм орчинд одоо бид нар ажиллаж байгаа шүү дээ. Тэгээд тийм учраас нүүрсний асуудал дагасан энэ асуудлыг нэг талд нь бүрэн шийдэх хэрэгтэй.

Эртээд хэвлэл мэдээллээс харах юм бол түр хорооны ахлагч Б.Энхбаяр хурлаа хийж чадахгүй, гишүүд нь одоо түр хорооныхоо хуралд ирж суухгүй ийм нөхцөл байдалтай байна лээ шүү дээ. Ингэж болохгүй шүү дээ. Бид нар одоо ОТ, Хөгжлийн банк, улс орны амин чухал эрх ашигт тулгамдсан ийм асуудлуудаар түр хороо байгуулаад, ажлын хэсэг байгуулаад ингээд бид нар ажиллаж л байсан. Энд чинь орж ажиллаж байгаа хүмүүс идэвхтэй санаачилгатай аливаа асуудалд шударга ийм байр сууриас хандаад ажиллаж болдог шүү дээ. Яагаад энэ түр хорооны гишүүд хуралдаа ирдэггүй юм. Түр хорооны даргын мэдээлснээр нүүрсний тээвэртэй холбогдсон Их Хурлын гишүүд, түр хорооны гишүүд бойкот зарлаад,



эсэргүүцэл зарлаад ирэхгүй байна гэсэн ийм бодитой асуудал байна уу, үгүй юу. Тэгээд аливаа нэг юмыг ерөөсөө бүр тодорхой болгоод, нэртэй устай нь нэг тал руу нь гаргах хэрэгтэй байна шүү дээ. Цаг нь дууслаа.

**Г.Занданшатар:** Эдийн засгийн байнгын хорооны дарга Цэдэндамбын Цэрэнпунцаг гишүүн хариулна.

**Ц.Цэрэнпунцаг:** Бат-Эрдэнэ гишүүний асуусан асуултад хариулъя.

Эхний тэр Ганболд гишүүний ахалж байсан Хянан шалгах түр хороо бол хилийн боомт дээр ачаа нэвтрүүлэхтэй холбоотой хүндрэлүүд гарч байсан. Үүний шалтгааныг тогтоох гол зорилготой ийм Хянан шалгах түр хороо ажиллаж байгаад, тэгээд яаж Хянан шалгах түр хороо ажлынхаа тайланг тавиад, Хянан шалгах түр хороо хаагдсан.

Дараа нь Энхбаяр сайдын ахалж байгаа Хянан шалгах түр хороо бол нүүрс олборлож байгаа төрийн өмчтэй компаниудтай холбоотой асуудлуудыг шалгах ийм үндсэн зорилготой ийм хянан шалгах түр хороо байгаа. Хоёулаа бол тус тусдаа тавьсан зорилготой ийм хянан шалгах түр хороонууд байгаа юм. Ер нь бол зүгээр яах вэ бүгд нүүрстэй холбоотой байгаад байгаа учраас нүүрс гэдэг нэг ийм ерөнхий дээвэртэй л байгаа болохоос биш дотроо бол нэг нь боомт, боомтын хэтрүүлэх ажил яагаад саатдаг юм. Тэр янз бүрийн наана цаана гарсан зарим машин нүүрсгүй, сул машинууд гарсан, орсон гээд ийм асуудлууд байсныг шалтгааныг нь тогтоох ажил бол Ганболд гишүүний ахалж байсан Хянан шалгах түр хороо хийж байсан юм байгаа юм. Саяын Ж.Бат-Эрдэнэ гишүүнийг Хянан шалгах түр хороонд оруулж байгаа асуудал бол Нямбаатар сайд маань Хотын дарга болж явсантай холбоотойгоор Хянан шалгах түр хороонд ажиллаж байсан гишүүдийн орон тоо суларсан учраас

дээр Ж.Бат-Эрдэнэ гишүүн орж ажиллахаар болж байгаа юм.

**Г.Занданшатар:** Нэг зүйлийг бас онцгой анхааруулж хэлье. Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүний хэлж байгаа маш зөв. Түр хорооны бүрэлдэхүүнд орсон хүмүүс хуралдаа оролцжээ. Ашиг сонирхлын зөрчилтэй ард түмэн хүсэн хүлээгээд байгаа асуудлыг хэлэлцэхээс хойш суугаад байгаа юм шиг. Парламентын нэр хүндийг унагааж байж болохгүй. Тийм хүмүүсийг солих хэрэгтэй. Өнөөдөрл ингээд солигдож байгаа шиг энд оруулж ирээд, түр хорооны дарга Баттөмөрийн Энхбаяр гишүүн тэр хуралдаа ирдэггүй, саад учруулаад байгаа хүмүүсийг солих хэрэгтэй. Тэгээд энийгээ шуурхайлах хэрэгтэй. Энэ ажил дээр онцгой анхаарч ажиллая. Бат-Эрдэнэ гишүүний хэлж байгаа шүүмжлэл туйлын зөв шүү. Хатуу сануулж хэлье. Тэр оролцохгүй байгаа хүмүүст.

Зочид танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Төмөртоогоогийн Энхтүвшин, Борхүүгийн Дэлгэрсайхан нарын урилгаар Дорноговь аймгийн Сайншианд сумын Төмөр замын татах хэсгийн ашиглалтын хэлтсийн ажилтнууд Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Эрхэм хүндэт төмөр замчиддаа ажлын өндөр амжилт, сайн сайхныг Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс хүсэн ерөөе.

Одоо Гонгорын Дамдинням гишүүн.

**Г.Дамдинням:** Нүрсний хулгай гээд өвлийн хүйтэнд ард иргэд Сүхбаатарын талбай дээр бараг сар жагсаж эсэргүүцлээ илэрхийлж, төр засагтаа шударга ёсыг авчраач гэж шахаж шаардсан. Монгол Улсын Засгийн газар, Монгол Улсын Их Хурал энэ дээр идэвх санаачилга гаргаж ажиллана гэж ард иргэддээ амласан. Тэгээд загасны ой санамжтай байгаад байгаа юм шиг л

харагдаад байх юм даа бид нар. Хянан шалгах түр хорооны ажил ямархуу түвшиндээ яаж явж байгаа юм бол гэдэг дээр бол асуух ёстой л болчхоод байгаа юм.

**Өчигдөр** Үйлдвэржилтийн бодлогын байнгын хороон дээр Таван толгой-Гацуун сухайт, Тавантолгой-Баян Зүүнбаянгийн чиглэлийн 2 төмөр замын ажлын аудитын дүгнэлт орж ирсэн. Аудит харин энэ дээр маш сайн ажилласан байна лээ. Аймшигтай тоонууд харагдаж байна лээ шүү дээ. 950,7 тэрбум төгрөгөөр хийнэ гэж төсөвт өртөг батлуулчихаад 3 их наяд 653 тэрбум төгрөгөөр хийсэн байгаа юм. 3,8 дахин их үнээр. Энэ гарын ариутгагч 1000 төгрөгөөр авна гэж хэлчхээд, 5 мянган төгрөгөөр авчихсан байвал хэн ч шоронд орно шүү дээ. Тэгээд хэн ч шоронд ордоггүй. Аудитын дүгнэлт нь энийг нь бодитой гаргаад ирчихсэн. Зэвсэгт хүчний жанжин штабыг оруулах хууль, эрх зүйн орчин тодорхойгүй байхад ерөнхий гүйцэтгэгчээр оруулаад, баахан шууд худалдан авалт хийчихсэн улсын нууцад оруулж байгаад. Саяхан одоо сар болоогүй байна. Ногоон автобусны дуулиан улс орон даяар өрнөж байна. Ногоон автобусны 400 тэрбум бол энэ Тавантолгойд байгаа төмөр замын хулгайн дэргэд талхны үйрмэг шүү. Талхны үйрмэг шүү. Тэгэхэд энэ Хянан шалгах хорооны орж ирж байгаа танилцуулга дээр төмөр замтай холбоотой нэг ширхэг үг үсэг алга байна шүү дээ. Тэгээд юуг нь хянах гээд байгаа юм. Тэгээд хулгай үнэхээр шалгах гээд байгаа юмтөмөр замаа шалгамаар байна шүү дээ. Аудитын дүгнэлтээр төрийн аудит нь хянаад гаргаад ирчихсэн байна шүү дээ. Бүх юм нь хууль зөрчсөн. Тэгээд бид нар ганц компанийн жижигхэн худалдан авалтууд шалгасан болоод л дуусах гээд байгаа юм уу.

Монголын бүх ард түмний хувьцаа эзэмшиж байгаа ЭТТ-н 1072 хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг зөрчөөд, ноогдол ашгийг нь хүчээр Тавантолгойн

хөрөнгө оруулалт руу хийчихсэн. Хийгээд үнийг нь 4 нугалаад хулгай хийгээд идчихсэн. Аудит тогтоочихсон. Тэгээд Хянан шалгах түр хорооны танилцуулга дээр энэ нь байхгүй. Төмөр замын нүүрсний хулгайтай холбоотой энэ нүүрснээс орж ирсэн мөнгийг төмөр замын том төсөл гэдэг юм уу хийгээд, улсын нууцад оруулж байгаад хулгай хийчихсэн энэ хулгайг бид нар яагаад ярихгүй байгаа юм. Хянан шалгах хороо дээрээ бид нар яримаар байна шүү дээ. Ярих юм уу, үгүй юм уу Энхбаяр сайд аа. Эдийн засгийн байнгын хорооны дарга аа. Тэгээд энэ аудитын дүгнэлтийг Их Хурлын дарга аа, Их хурлаараа хэлэлцмээр байна. Байнгын хороо дээр сонсоод өнгөрмөөргүй байна. Аудитын дүгнэлтийг бид нар Их Хурал дээрээ яримаар байна. Бүх ард түмний хувьцаа эзэмшиж байгаа энэ компаниас бүх мөнгийг нь оруулж байгаад хулгай хийгээд, идэж, уугаад алга болчихсон л байгаа байхгүй юу. Занданишатар дарга аа, энийг бүгдээрээ чуулган дээр ярья. Та 3 энэ дээр нэг хариулаад өгөөч. Энхбаяр сайдаас нэг асуулаа. Эдийн засгийн байнгын хорооны даргаас асуулаа. Их Хурлын даргаас асуулаа. Та 3 хариулаач.

**Г.Зандагшиатар:** Хяналт хишгалтын түр хорооны асуудал яригдаж байна. Тэр дээр ороод ажилла. Тэр хуралдаа идэвхтэй оролцоод ажиллацгаа. Тэгээд энд асуулт хариулт явуулаад, надаас асуулт хариулт явуулах дэг байхгүй. Явдаг дэгээрээ л явна. Хяналт хишгалт түр хороо Энхбаяр даргаас, Эдийн засгийн байнгын хорооноос асуулаа. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Асуулт үг хамт яваад дуусчхаж байгаа. Одоо Байнгын хорооны саналаар “Хяналт хишгалтын түр хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна.

Нямбаатар сайд чөлөөлөгдчихсөн, гишүүн чөлөөлөгдсөн. Оронд нь л хүн

оруулж байгаа юм байна шүү дээ. Тэгээд саяын хэлж байгаа, анхаарч байгаа юмнуудаа хяналт шалгалтын түр хороо дээрээ яриад эндээ ажилла.

Тэр төмөр зам бүх юмыг тэнд явж байгаа биз дээ. Шалгаж байгаа биз дээ. Санал хураалт явуулъя. Санал хураалт. Горимын санал гэж байхгүй. 65,2 хувиар дэмжиж, тогтоолын төсөл батлагдлаа.

10.43 цаг.

Дараагийн асуудалд орно.

**Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.**

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Хууль зүйн байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Сандаг-Очир танилцуулна. Сандаг-Очир гишүүнийг индэрт урьж байна.

**Ц.Сандаг-Очир:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 10 дугаар сарын 13-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурал 2023 оны 11 дүгээр сарын 9-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлсэн.

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед хуралдаан даргалагчаас өгсөн гүйцээн боловсруулах чиглэлийн дагуу Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42

дугаар зүйлийн 42.2.1-д заасныг баримтлан 1 санал хураалт явуулж хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн бөгөөд Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүд хуулийн төслийн зарим заалтаар дахин санал хураалгах шаардлагатай гэж үзсэн тул Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-д заасныг баримтлан 1 санал хураалт явуулж, хуралдаанд оролцсон гишүүдийн 3-ны 2-оос доошгүй нь дэмжсэн болно.

Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналуудыг төсөлд нэмж тусган төслийн агуулга, бодлого, зарчмыг алдагдуулахгүйгээр үг хэллэг, дэс дараалал, бүтцийн шинжтэй засварыг хийж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл болон Байнгын хорооны танилцуулгыг та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Хууль зүйн байнгын хорооны танилцуулгыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

**Г.Занданшатар:** Байнгын хорооны эцсийн хэлэлцүүлэг явуулсан талаарх танилцуулгатай холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу. Цэвэгдоржийн Туваан, Цэрэнпилийн Даваасүрэн гишүүнээр тасаллаа. Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн 33 минут хоцорсон байна. Болдын Жавхлан сайд тас, Чимэдийн Хүрэлбаатар сайд нар ирээгүй тасалсан байна. Дууд энэ сайд нарыг.

Одоо ажлын хэсгийг танилцуулна. Хууль зүй, дотоод хэргийн сайдын зөвлөх Дэмбэрэлцэрэнгийн Мөнх-Эрдэнэ, Улсын Ерөнхий прокурорын туслах прокурор, Шүүхэд төрийг төлөөлөх хэлтсийн дарга Отгонбаярын Мөнхбаатар, Эрүүгийн

хууль, тогтоомжийн уялдаа холбоог хангах боловсронгуй болгох чиг үүрэг бүхий байнгын ажлын хэсгийн гишүүн Базаргүрийн Гантуяа, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын шинжээч Төмөрчөдөрийн Нарантунгалаг, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын мэргэжилтэн Цэрэнсүрэнгийн Лхагвацэнд. Одоо Цэвэгдоржийн Туваан гишүүн асуулт асууна.

**Ц.Туваан:** Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудал орж ирж байна. Тодорхой асуух 2 асуулт байна. Ер нь бол энэ нэг тийм торгодог аливаа ямар нэгэн эрхийг нь нэг өөр зүйл заалтаар, хуулийн өөр санкцаар шийтгэл авсан байдлыг нь нөгөөдөхөд нь хамааруулж тэр эрхийг нь хязгаарлах энэ асуудлууд нэлээн орж ирчихсэн явж байгаа харагдаж байгаа. Жишээлэх юм бол ямар нэгэн зөрчил үйлдээд хүн бол тэр чинь зөрчил үйлдэнэ шүү дээ. Санаатай, санаагүй янз бүрийн байдлаар хурд хэтрүүлдэг ч юм уу, ямар нэгэн байдлаар замын хөдөлгөөний дүрэм зөрчөөд тэрэнд нь тохирсон хариуцлага юмнууд бол байгаа. Тэр юугаа бол хүн хүлээж байгаа. Тэгэнгүүт тэрэнтэй холбоотойгоор тийм шийтгэлтэй байгаа учраас гээд тухайн хүний бусад эрхүүдийг нь хязгаарлачхаж байгаа юм. Жишээлбэл, тийм эрх хязгаарласан хүн нэг нэгэндээ тээврийн хэрэгслээ зараад, нэрийг нь шилжүүлээд өгье гэхээр та ийм шийтгэлтэй байна гээд.

Тэгээд бусад тэр жолооны эрхийн үнэмлэх авах ч байдаг юм уу, ангиллаа солиулах ч байдаг юм уу ингээд нэг юманд нь авсан, хүлээлгэсэн хариуцлагаараа нөгөө асуудлуудыг давхар шийтгэдэг энэ концепц чинь ер нь зөв юм уу. Орон нутгаас маш олон хүн ярьж байна. Замын хөдөлгөөний үндсэн дүрэм журам, хуультай холбоотой асуудлууд дээр чинь амьдралд нийцэхгүй юм зөндөө байна шүү дээ. Дээр үед мэдэхгүй ЗИЛ-130, 53, 69 А, Б-69 гээд ийм машинуудын хурдаар бол 60км цаг 80км цаг чинь бол

болох байх. Одоо мэдэхгүй орон нутгийн зам дээр ер нь 100-аас доош километр цагийн хурдтай явж байгаа машин байгаа юм уу. Албаныхан ч тэр, цагдаагийнхан ч тэр, аминыхан ч тэр бүгд л ийм биш. Тэгээд энэ хурдны дээд хязгаараар маш олон хүн торгуулж байгаа юм. Одоо бүр 4, 500 мянгаар торгуулийн үлдэгдэлтэй гээд хүмүүс зөндөө байна. Тэгэхээр энэ хуульд өөрчлөлт орохгүй юм уу. Энэ ер нь яагаад ингээд энэ хэвээрээ байгаад байгаа юм. Энийг бол маш олон хүн асууж байна.

Дээрээс нь энэ цагдаагийн байгууллага, замын цагдаагийнхан хуулиа л биелүүлж байгаа байх. Ер нь бол заримдаа төсөв бүрдүүлж байгаа юм шиг харагдаад байгаа юм. Бүр нэг газар, тойруу, хонхор хотгор газрууд дээр, машин дотроосоо, машины араас гээд. Иргэдэд хуулийг сануулж, ойлгуулж, анхааруулах гэдэг нэг юм байдаг. Тэгэхэд ерөөсөө шууд л маш өндөр хуулийн санкцтай эрхийг нь хасна, маш өндөр торгуультай иймэрхүү зүйлүүд яваад байна. Тэгэхээр энэ дээр замын хөдөлгөөний дүрэмтэй холбоотой, ялангуяа хурдтай холбоотой зүйл дээр маш олон иргэд хөдөөгөөс асууж байна. Тэгэхээр энийг давхар асууя.

Дээрээс нь энэ дотор орж байгаа юу үгүй юу. Тэр хөдөө орон нутгийн иргэд тэр согтууруулах ундаатай холбоотой. Хуучин чинь бол 0,2 буюу одоо үлээлгээд үзэхэд 2-оос доош одоо согтолтын зэрэгтэй гарсан хүмүүс дээр бол ямар нэгэн эрх хасах биш, өөр торгууль ч билүү нэг удаа сануулдаг ч билүү арга хэмжээ авсан энэ байдал чинь энэ хууль дотор чинь орж ирж байгаа юу гэсэн ийм асуултуудад хариулт авъя.

**Г.Занданшатар:** Хэн хариулах вэ. Цэндийн Сандаг-Очир ажлын хэсгийн дарга, Улсын Их Хурлын гишүүн хариулъя.

Хууль зүйн байнгын хорооны дарга хаачсан бэ. Дуудаарай Дамдины Цогтбаатар.

**Ц.Сандаг-Очир:** Туваан гишүүний асуултад хариулъя. Туваан гишүүн ээ, Тээврийн хэрэгсэлтэй холбоотой гаргасан зөрчил бол Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан захиргааны хэмжээний акт зөрчсөнтэй холбогдуулж эрх бүхий этгээдээс оногдуулсан торгох шийтгэлийг л хуульд заасан хугацаанд биелүүлээгүй бол тодорхой албадагын арга хэмжээ авахаар хуульд оруулж ирсэн. Гэхдээ хуульд өргөн баригдсанаараа бол нэлээд албадагын арга хэмжээнүүдийг тухайлбал, зөвшөөрөл хүсэх, гадаад виз мэдүүлэх, мөн төрийн албанд шалгалт өгөх эд нар гээд гэх мэт зүйл дээр байсныг харин ажлын хэсэг дээр ярьж байгаад зөвхөн тээврийн хэрэгслийн зөрчилтэй холбогдуулан гаргасан зөрчилтэй холбоотой хязгаарлалтын албадуудыг нь үлдээе гэдэг ийм байдлаар хуулийн төсөл эцэслэн явж байгаа шүү.

Нөгөө талаар бас ер нь бол гаргасан тээврийн хэрэгслийн зөрчил, торгууль ер нь төлөгдөхгүй байгаа юм. Торгууль яагаад төлөгдөхгүй байна вэ гэхээр ерөөсөө хөшүүрэг байхгүй байна. Эрхээ хасуулдаг. Эрхээ хасуулсан хэр нь машинаа бариад яваад байдаг. Торгуулсан хэрн нь торгуулиа төлөхгүй байдаг. Тийм учраас бид нар бас ажлын хэсэг дээр яриад гүйцээн боловсруулалт чиглэл авсан I заалт бол зөрчил гаргасан тохиолдолд тээврийн хэрэгслийг нь хөдөлгөөнд оролцуулахгүй байх ийм арга хэмжээ авахаар энэ заалт орж ирж байгаа. Энэ заалт бол үнэхээр тэр торгуулийг төлүүлэх, та торгуулиа төлчихсөн бол бусад ямар нэг албадагын арга хэмжээ авахгүй ээ л гэсэн үг. Тийм учраас аль аль талаасаа зөрчил болоод өргөн баригдсанаасаа бас жоохон сулруулсан шүү.

Шууд эрүүгийн хариуцлага оногдуулахаар байсныг бас орон нутгийн онцлог юмнуудыг гишүүдээс гарсан саналуудыг, ард иргэдээс гарсан саналуудыг бас харгалзаж үзэж байгаад эхний ээлжид торгох буюу аль эсвэл 7-30 хоног баривчилъя. Дараагийн удаа бол эрүүгийн хуулиар хариуцлага оногдуулдаг, шийтгэдэг байя гэдэг ийм хуулийн төсөл маань байгаа гэдгийг бас танд хэлье.

Тэр дараагийн асуултад нь манай тээврийн цагдаагаас хариулах уу. Хэн хариулах вэ. Замын хөдөлгөөний дүрэмтэй холбоотой нэмэлт тайлбар.

**Г.Занданшатар:** 84.

**Ц.Чинзориг:** Тээврийн цагдаагийн албаны Зөрчил шалган шийдвэрлэх хэлтсийн дарга, дэд хурандаа Чинзориг байна. Туваан гишүүний асуултад хариулъя. 2018 оны 8 сарын 8-нд Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор замын хөдөлгөөний дүрмийг хамгийн сүүлд шинэчлэн баталсан. Энэ дүрмээр хот дотор 60, хотоос гадна тээврийн хэрэгсэл 80км цагийн хурдтайгаар зорчихоор ийм байж байгаа юм. Энэ дүрэм журамд нийцэж байгаа юм уу гэдэг дээр бид нар ер нь замын хөдөлгөөний дүрэмд бас өөрчлөлт оруулах хэрэгцээ шаардлагууд бас амьдралд тулгарсан байна гэдгийг нь судлаад Хууль зүй, дотоод хэргийн яам руугаа бас санал саналуудыг хүргүүлсэн. Хууль зүй, дотоод хэргийн яамнаас ажлын хэсэг гараад, цаашидаа Засгийн газрын тогтоолоор энэ дүрмийг шинэчлэх, өөрчлөх ажлыг зохион байгуулахаар төлөвлөж байгаа.

**Г.Занданшатар:** Цэвэгдоржийн Туваан гишүүн тодруулж асууна. I минут.

**Ц.Туваан:** Торгууль төлөх мөнгө байхгүй байгаа ихэнх хүмүүст. Тэгээд мөнгөгүйгээсээ болоод торгуулиа төлөхгүй явж байгаа хүмүүс зөндөө байгаа. Бараг 80, 90% нь байгаа. Дээрээс

нь торгуулиа төлөх, халтуур хийгээд, таксид яваад торгуулийнхаа мөнгө олох гэж байгаа тээврийн хэрэгслийг нь авчихдаг нь зөв үү, буруу юу. Тэр чинь хүний хувийн өмч шүү дээ. Өөр хүүхэд нь юм уу, гэр бүлийнх нь хүн буюу арга хэмжээгүй хүн нь бариад бас орлогоо олоод явж болно шүү дээ. Тэгэхээр энэ заалт чинь ер нь бас зөв юм уу. Тэр 60, 80км цаг чинь бол Хууль зүйн сайдын юу гэххэв, журмаар гэххэв үү. Тогтоолоор гэххэв үү. Тэгвэл Хууль зүйн сайд энийг бас үзээд ойрын хугацаанд амьдралд нийцүүлэхгүй бол орон нутгийн зам дээр яг энэ өндөр хүчин чадалтай машинууд чинь жоохон хаазлаад энэ хязгаарыг чинь даваад бөөн торгууль болчихоод байгаа шүү гэдгийг хэлье.

**Г.Занданшатар:** Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн асуулт асууна.

**Ц.Даваасүрэн:** Би 2 зүйлийг хэлэх гэсэн юм. Сая зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг оруулж ирэхэд 1 ийм заалт оруулчихсан байгаа байхгүй юу. Тээврийн хэрэгслийн хуульд заасан журмын дагуу тусгаарлана гээд, тэгсэн мөртөө эс үгүй бол бусад аргаар хөдөлгөөнийг хязгаарлана гэж бусад аргаар гэж болохгүй байхгүй юу. Хууль дээр хэзээ ч тодорхойгүй зүйл заалт байж болдоггүй. Тодорхойгүй. Бусад аргаар гэдэг чинь маш өргөн ойлголт шүү дээ. Саатуулж болно. Хэдэн цаг саатуулах юм тэгвэл. Тэгэхээр нь бусад аргаар гэдэг юмыг байлгаж болохгүй. Яг ингэж орох юм бол наадах чинь хүнийг ёстой хэлмэгдүүлсэн юм болно шүү. Үгүй ээ, энэ чинь одоо огт тодорхойгүй, бусад аргаар л гэж байгаа байхгүй юу. Ямар ч арга байж болно шүү дээ. Тэгэхээр энийгээ засахгүй бол болохгүй шүү гэдгийг хэлье. Хууль дээр ийм заалт бол орж болохгүй.

2-т, 1 ийм асуудал шийдэгдэхгүй үлдээд байна. Нөгөө манайхан чинь нэг ийм сонин хүмүүс юм аа. Их хувиа хичээсэн. Бусдыг зам талбай дээр машинаа тавьчихаар дургүйцээд байх юм. Одоо өөр хүний машиныг зам дээр

тавивал дургүйцээд байх юм. Өөрөө бол машинаа тавьчихаад яваад өгөх юм. Үгүй ээ, чи наанаа машинаа тавьж болохгүй гэхээр юун сүртэй юм гэххээд л яваад өгөх юм. Манайхан бүр хавтгайдаа тийм юм байгаа юм. Тэгэхээр энийг яаж шийдэх вэ. Тэгэхгүй бол зам бариад хэрэг алга. Зам барьж байна. Холбоос замууд зөндөө хийгдэж байна. Бүгдээрээ машины зогсоол болчихоод байна шүү дээ. Бүгдээрээ машин тавьж байна. Өөрөө бол тавьж болно. Бусдыг бол тавьж болохгүй гээд л сошиалаар, нийгмийн сүлжээгээр хачин сайхан амьтан л бичээд л байгаа юм л даа. Өөрөө бол юу ч хийж болно. Өөрөө бол хулгай хийж болно. Өөрөө бол хууль зөрчиж болно. Бусад нь бол болохгүй. Тэгэхээр энэ нэг Монгол сэтгэхүйг өөрчилсөн заалтыг дараагийн авто тээврийн, зам тээврийн зохицуулалт дээр оруулж ирэхгүй бол энэ машин түгжрэлийн асуудлыг шийдэх гэж зам бариад ямар ч хэрэг алга. Дандаа зогсоол.

Тийм учраас гадаадад яаж шийдээд байна вэ гэвэл ерөөсөө 1, 2 удаа торгууль өгөөд л дараагийнхыг нь шүүх дээр дуудчихаж байгаа шүү дээ. Шүүх дээр ял өгчхөж байгаа байхгүй юу. Тийм учраас айгаад тэр торгуулиа төлөхгүй байна гэдэг ч юм уу эсвэл одоо хууль зөрчинө гэдэг ойлголтгүй болчихож байгаа юм. Тэр чинь зүгээр л та бүхэн сая сошиалаар харсан байх. 92-той өвгөнийг шууд шүүх дээр дуудаж байна шүү дээ. Сургуулийн талбайд хурд хэтрүүлсэн гээд. Тэгэхээр шүүхээр шийдчихдэг учраас ийм зөрчлүүд гардаггүй. Манайд яах вэ дээ, нөгөө цагдаа торгуулиа хөөцөлдөж байгаа ч юм уу, үгүй ч юм уу хөөрхий хэцүү шүү дээ тэр чинь. Тэгээд л таг болно. Нөгөөдөх нь хуримтлагдана, төлөхгүй яваад л байна. Тэгээд энэ асуудлыг цэгцэлж хэдүүлээ нэг шийдвэр гаргахгүй бол их төвөгтэй зүйл энэ түгжрэлд садаа учруулж байгаа машинаа эмх замбараагүй байрлуулж байгаа асуудал юм шүү гэдгийг бас хэлье. Эцэст нь энийг бас зохицуулаарай.

**Г.Занданшатар:** Цэндийн Сандаг-Очир гишүүн. Ажлын хэсгийн дарга хариулъя.

**Ц.Сандаг-Очир:** Зөрчил гаргасан хүн, хуулийн этгээд торгуулиа төлөөгүй тохиолдолд тээврийн хэрэгслийн журамлах арга хэмжээг хуульчилж байгаа. Ерөөсөө тээврийн хэрэгслийг хөдөлгөөнд оруулахгүй байх л арга хэлбэрүүдийг авна. Тухайн орон нутгийн гэдэг юм уу, тухайн нөхцөл байдлын онцлогоос хамаарч. Тэгэхээр бусад аргаар гэхээр бүх аргуудыг нэг бүрчлэн зааж хуульчлах бололцоо боломж хомс. Тийм учраас ерөнхийдөө тээврийн хэрэгслийг л хөдөлгөөнд оруулахгүй байх арга хэлбэрүүдээ л хэлж байгаа юм. Нэмж тайлбарлаад өгчих тээврийн тээврийн цагдаагаас.

**Г.Занданшатар:** Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн тодруулъя бусад аргаар гэдэг нь.

**Ц.Даваасүрэн:** Бусад аргаар гээд тодорхойгүй байж огт болохгүй. Хууль ийм байж ерөөсөө болохгүй. Битгий өөрийгөө өмөөрөөд бай. Наадхаа өөрчил, тодорхой болго. Бусад дарга гэдэг дотор чинь өчнөөн юм орно. Машиныг хурааж авах орж байна шүү дээ. Шууд улсын болгох орж л байна шүү дээ. Бусад арга гэдэг дотор чинь. Тэгэхээр ингээж болохгүй байхгүй юу. Энэ Эрүүгийн хууль гэдэг чинь хүний хувь заяа байгаа юм. Тийм учраас энэ дээр бол тодорхойгүй заалт ерөөсөө байж болохгүй. Тэр тусмаа та нар өмч хөрөнгийн асуудлыг яриад байгаа шүү. Машин гэдэг чинь. Өөр хүний нэр дээр байвал яах вэ. Эсвэл компанийнхаа нэр дээр байлгаад байвал яах вэ. Одоо тэр машиныг нь тэгээд журамлачхаж болох уу гээд төвөгтэй асуудлууд бол үүснэ. Тийм учраас бусад аргаар гэдэг юмаа дарга чиглэл өгч байж тодорхой болгохгүй бол энэ чинь юу ч байж болно шүү дээ.

**Г.Занданшатар:** Цэндийн Сандаг-Очир гишүүн, ажлын хэсгийн дарга.

**Ц.Сандаг-Очир:** Даваасүрэн гишүүн ээ, энд хурааж авах юм биш. Та сайн уншаарай. Энэ тохиолдолд тээврийн хэрэгслийг хуульд заасан журмын дагуу тусгай талбайд хүргэх, эсхүл бусад аргаар хөдөлгөөнийг нь хязгаарлана л гэж байгаа юм. Хязгаарлана. Хөдөлгөөнд оролцуулахгүй л гэсэн үг. Тэр зөрчил гаргасан тээврийн хэрэгслийг. Журамлана л гэсэн үг шуудхан хэлэхэд. Тийм учраас бусдын эд хөрөнгийг, өмчийг хурааж авна гэдэг ойлголт бол биш шүү. Мөнх--Эрдэнэ зөвлөх нэмээд тодруулчих.

**Г.Занданшатар:** Мөнх-Эрдэнэ 81.

**Д.Мөнх-Эрдэнэ:** Даваасүрэн гишүүний асуултад хариулъя. 1 дүгээрт тэр тээврийн хэрэгслийг хураах асуудал яригдаж байна. Би энэ дээр жишээ хэлчихье. Энэ бол манай төсөл дээр хамаагүй асуудал. Энэ өөрөө Эрүүгийн хууль болон Зөрчлийн хууль дээр албадагын арга хэмжээ гэж хуульчлагдсан байгаа. Тэр тусмаа Зөрчлийн хууль дээр Зөрчлийн хуулийн тусгай ангид заасан тохиолдолд гэмт хэрэг үйлдэхэд зөрчил үйлдэхэд ашигласан тээврийн хэрэгсэл, бусад эд зүйлсийг албадан хурааж болохоор ингээж.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн.

**Ц.Даваасүрэн:** Үгүй ээ, би зүгээр бусад арга гэдэг чинь 9 шидийн байж болно гэдгээр жишээ аваад байгаа юм. Үгүй ээ, жишээлбэл одоо тэр гишүүд хэлээд байна шүү дээ. Би жишээлбэл дугуйг нь авъя гэж байна тийм үү. Оюунчимэг аккумуляторыг нь авчихъя гэж байна. Бат-Эрдэнэ гишүүн түлхүүрийг нь аваад явчих юм гэж байна. Үгүй ээ, ийм олон арга хэрэгслээр хөдөлгөөнийг нь хязгаарлах юм уу. Энэ чинь байж болохгүй шүү дээ. Тийм

учраас бусад аргаар гэж тийм утгагүй, тодорхой бус юм ерөөсөө байж болохгүй. Яах юм, журамлах юм уу, тэрийгээ хэл. Үгүй ээ, тэгээд яах юм аккумуляторыг нь аваад явж байх юм уу. Тийм бүдүүлэг байх юм уу. Дугуйг нь салгаад явж байх юм уу.

**Г.Занданшатар:** Мөнх-Эрдэнэ тодорхой хариулъя. Бусад аргаар гэж ийм том уут нээж болохгүй гэдэг үндсэн санаа бол хуульд тэгж ерөнхий заадаггүй шүү дээ. Нэг бол Зөрчлийн тухай хуулийн тэдийн тэдийг эшлэх юм уу, сийлэх гэх юм уу энэ тэр гээд. Наадах чинь тэгэхгүй журмын талбайд хүргэх чинь заасан журмын дагуу тусгай талбайд хүргэх гээд биччихсэн байна. Байж байгаа. Тэгээд эс үгүй бол бусад аргаар гэхээр өөр ямар нэгэн арга хэрэглэж, ер нь төр бол зөвхөн зөвшөөрснийг хийнэ. Иргэн бол хориглоогүйг хийнэ гэсэн ийм үндсэн зарчмаар л явна шүү дээ. Мөнхэрдэнэ 81.

**Д.Мөнх-Эрдэнэ:** Яг одоо энэ томъёололд хэрэглэж байгаа заалт бол өөрөө Цагдаагийн албаны тухай хуулийн 33.2 дээр байгаа. Түр саатуулах тээврийн хэрэгжилтийг хуульд заасан журмын дагуу тусгай талбайд хүргэх эс үгүй бол бусад аргаар хөдөлгөөнийг хязгаарлана гээд. Тэгээд манай тээврийн цагдаагийнхны практик дээр хэрэглэж байгаа аргууд бол яг энэ торгуулиа төлөөгүй нөхцөлд мөн зөрчил гаргаад зайлшгүй тээврийн хэрэгслийг хөдөлгөөнд оролцохыг нь хязгаарлах энэ тохиолдолд дугуй түгжигч ашиглах болон бусад аргыг хэрэглэдэг. Тэгээд энэ дээр одоо яг манай тээврийн цагдаагийн мөрдөн шалгах хэлтсээс тодорхой жишээнүүдийг хэлье. Баярлалаа.

**Г.Занданшатар:** 84.

**Ц.Чинзориг:** Тээврийн цагдаагийн алба дэд хурандаа Чинзориг. Энэ дээр гол ойлголт нь ингээд байгаа юм. Шууд журамлана гээд хатуу заагаад өгчихөөр албан хаагч илрүүлсэн тохиолдолд шууд

журамлахаас өөр аргагүй байдал үүсэж байгаа юм. Бид нар бол бусад аргаар гэдэг дээр нь тээврийн хэрэгслийг зогсоож шалгаагаад, зогсоож шалгасан бол цагдаагийн албан хаагч шалгах төхөөрөмжөөрөө шүүж үзээд торгуультай байгаа бол тэрийг нь сошиал, интернэт, банк бусад хэлбэрүүдээр цахимаар төлүүлээд тэрийг нь хөдөлгөөнийг нь цааш нь үргэлжлүүлээд явуулах боломж нь бас энэ дээр ингэж харагдаж байгаа юм аа.

2-т гэх юм бол ер нь бид нар нэг хэсэг нийслэл хотын хэмжээнд дугуй түгжигчдийг нэг хэсэг туршсан. Тиймэрхүү байдлаар бас ирээдүйд технологийн чиглэлээр мөн одоо дугуй түгжих чиглэлээр бас хөдөлгөөнийг хязгаарлах ийм боломжууд бас үүсэж магадгүй учраас яг энэ хуулийн төсөл дээр бас ингэж бусад аргаар гэж оруулж өгсөн юм.

**Г.Занданшатар:** Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Одоо зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт явуулна. Гишүүд Мөнх-Оргил гишүүн, Дэлгэрсайхан гишүүн суудалдаа сууцгаая.

Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна. Зарчмын зөрөөтэй 2 санал байгаа.

Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1 дэх заалтын дагуу хураалгах санал. Энэ бол гүйцээн боловсруулах чиглэл өгсний дагуу боловсруулсан байна.



Нэг.Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 8 дахь хэсгийг доор дурдсанаар урьдчилан найруулах:

“8.Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээд Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний акт зөрчсөнтэй холбогдуулан эрх бүхий этгээдээс оногдуулсан торгох шийтгэлийг хуульд заасан хугацаанд биелүүлээгүй бол тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн үнэмлэх авах, сунгах, ангилал нэмэх, өөрчлөх, нөхөн авах, тээврийн хэрэгслийн эзэмшлийн шилжилт хөдөлгөөн хийх эрхийг хязгаарлана. Хүн, хуулийн этгээд, эрх бүхий этгээдээс оногдуулсан торгох шийтгэлийг энэ хуулийн 3.5 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан хугацаанд биелүүлээгүй бол цагдаагийн албан хаагч тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг торгох шийтгэлийг биелүүлж дуусах хүртэл хугацаанд хязгаарлана. Энэ тохиолдолд тээврийн хэрэгслийн хуульд заасан журмын дагуу тусгай талбайд хүргэх, эсхүл бусад аргаар хөдөлгөөнийг нь хязгаарлана.” Санал гаргасан Хууль зүйн байнгын хороо.

Цэрэнпилин Даваасүрэн гишүүн үг хэлнэ.

**Ц.Даваасүрэн:** Тэгвэл бусад аргаар гэдгээ хуулиар зөвшөөрсөн аргаар гэдэг хэлбэр лүү болго. Тэгэхгүй бол ийм 9 шидийн арга хэрэглэж болно шүү дээ. Хөдөлгөөнийг нь хязгаарлаж байвал гарыг нь хуга мушгиж болох нь байна шүү дээ бараг. Тийм учраас чиглэл өгсөн юм уу. Тэгэхээр хуулиар заасан бусад аргаар гэдэг юм уу, аргыг нь ямар нэг хэмжээгээр журамлахаар зохицуулж өгөх хэрэгтэй. Цагдаагийн даргын байдаг юм уу аль эсвэл Хууль зүйн сайдын байдаг юм уу баталсан журам.

**Г.Занданшатар:** Дэмжсэн, дэмжээгүй л үг хэлнэ л дээ. Тэр хууль зөвшөөрөгдсөн бусад аргаар гэдэг юм уу тийм агуулга байхгүй бол бусад аргаар

гэдэг нь бол хууль зүйн техникийн хувьд буруу байж магадгүй. Дэгээр өөрчлөлт оруулах бололцоогүй л дээ. Эцсийн хэлэлцүүлгийн явсан. Санал хураалт явуулна. Ажлын хэсгийн дарга Сандаг-Очир гишүүн төгсгөлийн өгүүлбэр дээр хуульд нийцүүлж редакцын засвар хийхээр энийг яах вэ редакцияар авч болох болов уу. Редакцын засвар засвар хийхээр, эцсийн хэлэлцүүлэг дээр редакцын засвар хийж болно. Тийм учраас редакцын засвараас өөр агуулгын засвар хийж болохгүй. Тэгээд редакцын засвараар, найруулгын засвараар бичилт дээр яах зөвшөөрлийг Тамгын газарт өгөөд ийм байдлаар санал хураалт явуулъя. Санал хураалт явуулъя. Санал гаргасан Хууль зүйн байнгын хороо. Санал хураалт 62,5 хувийн саналаар санал дэмжигдлээ. Энийг редакцын засвартай гэж протоколд тэмдэглэе.

2.Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3 дахь заалтын дагуу санал хураалгана.

1.Төслийн 2 дахь заалтын 21.9 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “Мөрдөн шалгах” гэсний өмнө “Шүүгч, прокурор, хууль сахиулагч, өмгөөлөгч” гэж нэмэх. Санал гаргасан Хууль зүйн байнгын хороо. Санал хураалт. 64,6 хувийн саналаар санал дэмжигдлээ. Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дууслаа.

Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Хууль зүйн байнгын хороонд шилжүүлж байна.

*Хууль зүй байнгын хороо редакцын засварыг сайн хийж, бүх хүнээр гарын үсэг зуруулж, хяналт тавиарай. Протоколд тэмдэглэе. Дараагийн асуудалд орно. Ажлын хэсэгт баярлалаа.*

11.12 цаг.

**Дараагийн асуудалд орно. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнийг томилох, чөлөөлөх тухай асуудлыг хэлэлцэнэ.**

Монгол Улсын Үндсэн хуулийн 65 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт Үндсэн хуулийн цэц 9 гишүүнээс бүрдэнэ. Тэдгээрийн 3-ыг Улсын Их Хурлаас, 3-ыг Монгол Улсын Ерөнхийлөгч, 3-ыг Улсын дээд шүүхийн санал болгосноор Улсын Их Хурал 6 жилийн хугацаагаар томилно гэж заасан. Мөн Монгол Улсын цэцийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт цэцийн гишүүний 3-ыг Монгол Улсын Их Хурлаас, 3-ыг Монгол Улсын Ерөнхийлөгч, 3-ыг Улсын дээд шүүхийн санал болгосноор Улсын Их Хурал 6 жилийн хугацаагаар томилно гэж тус тус заасан.

Энэ зохицуулалтын дагуу Улсын Их Хурлаас Доржийн Одбаярыг Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр нэр дэвшүүлэн Улсын Их Хурлын 2016 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 55 дугаар тогтоолоор Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр 6 жилийн хугацаагаар томилсон бөгөөд энэ хугацаа дуусгавар болсон. Хуульд заасан хугацаа дуусгавар болсонтой холбогдуулаад Монгол Улсын Үндсэн хуулийн 65 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 3 дахь зүйлийн 2 дахь хэсгийн удирдлага болгон манай Төрийн байгуулалтын байнгын хороогоор хэлэлцээд, Хууль зүйн байнгын хороонд нэр дэвшүүлээд онол практикийн болон хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн мэдлэг, ур чадвар, дадлага туршлагыг үндэслэн Үндсэн хууль судлаач, доктор Лувсандоржийн Өлзийсайханыг Үндсэн хуулийн цэцийн

гишүүнд нэр дэвшүүлэхээр Улсын Их Хурлаас санал болгосныг танилцуулж байна.

Ийнхүү нэр дэвшүүлэхдээ 1 дүгээрт Үндсэн хууль судлаач Лувсандоржийн Өлзийсайханы онол судалгааны Үндсэн хууль судлаачийн мэдлэг, туршлагыг харгалзан үзлээ.

Өлзийсайхан нь Хууль зүйн эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тасралтгүй 18 жил гүйцэтгэж, тэр дотроо МУИС-ийн Хууль зүйн сургуульд 15 жил багшилж, Эрх зүйн онол, Үндсэн хуулийн эрх зүй, Парламент судлалын чиглэлээр 10 гаруй 1 сэдэвт бүтээл, ном, гарын авлага туурвиж, 20 гаруй эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэл, судалгааны ажил бичиж, эрдэмтэн, судлаачид болон олон нийтийн хүртээл болгосон.

Шүүх эрх мэдлийн болон хууль тогтоох үйл ажиллагааны практикийг судлах чиглэлээр АНУ, ХБНГУ, Япон, Франц, БНСУ, Швейцарын холбооны улсад мэргэжил дээшлүүлсэн. Хууль зүйн ухааны докторын зэргийг “Парламентын хуралдааны дэг, эрх зүйн харьцуулсан шинжилгээ” сэдэвт бүтээлээр зэрэг хамгаалсан. Дэд профессор цолтой.

МУИС-ийн Хууль зүйн сургуулийг Эрх зүйч мэргэжлээр 1998 онд, 2002 онд тус сургуулийг Хууль зүйн магистрын зэрэгтэй төгссөн. 2020 онд докторын зэрэг хамгаалсан.

2 дугаарт, Лувсандоржийн Өлзийсайхан нь хууль тогтоох салбарт, гүйцэтгэх эрх мэдлийн салбарт, шүүх эрх эрх мэдлийн салбарт 25 жил ажиллаж, мэдлэг, ур чадвар, дадлага туршлагыг хуримтлуулсныг үндэслэн дэвшүүлж байгаа.

2007 оноос Улсын Их Хурлын Тамгын газарт ажиллаж одоог хүртэл мерит зарчмаар дэвшин ажиллаж,

Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргаар одоо ажиллаж байна. Мөн 2013-2015 онд Шүүхийн ерөнхий зөвлөлийн Шүүхийн хүний нөөцийн газрын дарга, 2015-2017 онд Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгч хийж байсан. Шүүхийн салбарт ажилласан туршлагыг бас харгалзан үзлээ.

3 дугаарт, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Стратеги, удирдлага зохицуулалтын газарт гүйцэтгэх эрх мэдлийн салбарт ажиллаж байсан ийм туршлагатай.

Улсын Их Хуралд болон Засгийн газар төрийн албанд 25 жил ажилласан туршлагыг үндэслээд Лувсандоржийн Өлзийсайханыг Үндсэн хуулийн цэцийн гишүүнд дэвшүүлж байна.

Мөн Өлзийсайхан 2019 онд Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн төслийг боловсруулах эхний шатнаас хэлэлцэн батлах хүртэл бүхий л үйл явцад Улсын Их Хурлын Тамгын газрын удирдлагын хувиар манлайлан ажиллаж, Монгол Улсын Үндсэн хуулийн эрх зүйн шинэтгэлийг эхлүүлж хэрэгжүүлэхэд бодитой хувь нэмэр оруулсан. Тодруулбал, Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн дагуу Улсын Их Хурлын үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн парламентын эрх зүйн орчны болон бусад шинэтгэлийг гүнзгийрүүлж Монголд парламентын ардчиллыг бэхжүүлэх, ард түмний засаглах эрхийг хангах чиглэлээр үр дүнтэй ажиллаж байна.

Мөн Улсын Их Хурлаас 2023 оны 5 дугаар сарын 31-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийн төслийг ард түмнээр хэлэлцүүлж, санал авах, улс орны нийгэм, эдийн засгийн тулгамдсан асуудлаар үндэсний хэмжээнд зөвлөлдөх санал асуулга явуулах зэрэг төрийн томоохон түүхэн үйл хэргийг зохион байгуулахад бодлого, хэрэгжилтийн түвшинд

мэргэжлийн өндөр ур чадвар гаргаж хариуцлагатай ажилласан.

Иймд Үндсэн хуулийн гишүүнд тавигдах хууль зүй, улс төрийн өндөр мэргэжилтэй гэсэн үндсэн шаардлагыг хангаж байгаа. Хууль зүйн эрдэм шинжилгээ, судалгаанаас эхлэн хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн салбарт 25 жил хууль, эрх зүйн мэргэжлийн ажил эрхэлж буй Лувсандоржийн Өлзийсайханыг Үндсэн хуулийн цэцийн гишүүнд нэр дэвшүүлэх саналыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсэж байна. Анхаарал тавьсанд баярлалаа.

Одоо Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилох тухай Монгол Улсын Ерөнхийлөгчийн саналыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Янугийн Содбаатар танилцуулна. Индэрт урьж байна.

**Я.Содбаатар:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын үндсэн хуулийн 65 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Ерөнхийлөгч 2023 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 16 дугаар захирамжаар Эрдэнээгийн Энхтуяаг Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилуулахаар Улсын Их Хуралд санал болгон Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 102 дугаар зүйлийн 102.1-д заасны дагуу нэр дэвшигч Эрдэнээгийн Энхтуяаг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулж байна.

Нэр дэвшигч Хойд овогтой Эрдэнээгийн Энхтуяа 1977 онд Улаанбаатар хотод төрсөн, 46 настай. Нөхөр хүүхдийн хамт амьдардаг. Нэр дэвшигч Энхтуяа нь 1995 онд Ховд

аймгийн 10 жилийн 1 дүгээр дунд сургуулийг бүрэн дунд, 1999 онд МУИС-ийн Хууль зүйн сургуулийг Хууль зүйн ухааны бакалавр, 2005 онд Япон улсын Кюшүгийн Их сургуулийг Хууль зүйн ухааны магистрын зэрэгтэй төгссөн. Англи, Орос хэлтэй.

Нэр дэвшигч Энхтуяа нь 1999-2000 онд Ховд аймгийн Прокурорын газрын нарийн бичиг, 2000-2001 онд Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн төрийн захиргаа удирдлагын газарт бичиг хэргийн эрхлэгч, 2001-2002 онд Хууль зүй, дотоод хэргийн дэд сайдын туслах, 2002-2012 онд Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын мэргэжилтэн, ахлах мэргэжилтэн, 2012-2016 онд Хууль зүйн яамны Эрх зүйн шинэчлэлийн бодлогын газрын ахлах мэргэжилтэн, 2016 оноос Хууль зүй, дотоод хэргийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргаар тус тус ажиллаж ирсэн туршлагатай.

Үүнээс хуульч мэргэжлээр 24 жил ажиллаж байна. Нэр дэвшигч нь Монгол Улсын Үндсэн хуулийн 65 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан болзлыг бүрэн хангасан, эрх зүйч мэргэжилтэй, хуульч мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй, хууль зүй, улс төрийн өндөр мэргэжилтэй байх шаардлагыг бүрэн хангаж байна гэж үзэж байна. Иймд Монгол Улсын Ерөнхийлөгчөөс Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилуулахаар санал болгож байгаа нэр дэвшигч Эрдэнээгийн Энхтуяаг Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилох асуудлыг хууль, тогтоомжийн хүрээнд хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

**Г.Занданшатар:** Одоо Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилох тухай Улсын Дээд шүүхийн саналыг Улсын Дээд шүүхийн Иргэний хэргийн танхимын тэргүүн

Гүррагчаагийн Алтанчимэг танилцуулна. Индэрт урьж байна.

**Г.Алтанчимэг:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын үндсэн хуулийн 65 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8-д заасан заалтыг тус тус үндэслэн Үндсэн хуулийн цэцийн гишүүнд нэр дэвшүүлэх асуудлыг 2023 оны 10 сарын 2-ны өдрийн Улсын дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдаанаар хэлэлцээд, тус хуралдаанаас 36 дугаар тогтоол гарсан. Энэ тогтоолын дагуу Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн олонхын санал авсан Одонхүүгийн Мөнхсайханыг Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилуулахаар Улсын Их Хуралд санал болгохоор шийдвэрлэсэн учраас Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 102 дугаар зүйлийн 102.2-т заасны дагуу нэр дэвшигч Одонхүүгийн Мөнхсайханыг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулж байна.

Нэр дэвшигч Одонхүүгийн Мөнхсайхан 1983 онд Ховд аймгийн Жаргалант сумд төрсөн, 40 настай, ам бүл 4, эхнэр, 2 хүүхдийн хамт амьдардаг. 2005 онд МУИС-ийн Хууль зүйн сургуулийг Эрх зүйч мэргэжлээр төгссөн. Англи хэлтэй. Мөнхсайхан нь Үндсэн хуулийн эрх зүйн чиглэлээр судалгаа хийж, 2008 онд Япон улсын Нагояагийн Их сургуулийн Хуулийн сургуульд Хууль зүйн магистр, 2011 онд Хууль зүйн докторын зэрэг тус тус хамгаалсан. МУИС-ийн эрдмийн зөвлөлийн 2019 оны 2 дугаар тогтоолоор Дэд профессор цол олгосон байна. 2005 оноос эхлээд МУИС-ийн Хууль зүйн сургуульд тэнхимийн туслах ажилтан, багш, дэд профессор, профессороор нийтдээ 18 жил ажиллаж, 2022 оны 1 дүгээр сараас МУИС-ийн Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэнгийн захирлын албан тушаалыг

хавсран гүйцэтгэж байна. Үндсэн хуулийн эрх зүй, Хүний эрх, Шүүх, Хуульчийн ёс зүй, Эрх зүйн болон улс төрийн философийн хичээлийг МУИС-ийн Хууль зүйн сургуульд, мөн эдгээр сэдвээрээ хуульч, шүүгчийн үргэлжилсэн сургалтад сургалт явуулж хичээл заадаг хүн байна.

Сүүлийн 10 жилд мэргэшсэн чиглэлээрээ 30 орчим судалгааны төслийг дангаараа болон багаар хэрэгжүүлж, 9 ном, сурах бичиг, 60 гаруй эрдэм шинжилгээний өгүүллийг Англи болон Монгол хэлээр хэвлүүлж, 60 орчим судалгааны илтгэл хэлэлцүүлсэн байна.

Мөнхсайхан АНУ-д Вашингтоны Их сургууль болон Жорж Вашингтоны Их сургуульд зочин судлаачаар, Япон улсын Нагояа Их сургуульд гадаад судлаачаар тус тус ажиллаж байсан.

Нэр дэвшигч Мөнхсайхан нь Монгол Улсын Үндсэн хуулийн 65 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнд тавигдах болзлыг бүрэн хангасан, хууль зүйн өндөр мэргэшилтэй, Үндсэн хуулийн эрх зүйн дагнасан судлаач, багш, профессор байгаа учраас Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилуулахаар Монгол Улсын Дээд шүүхээс гаргасан саналыг хэлэлцэж шийдвэрлэж өгнө үү гэж хүсэж байна.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Г.Занданшатар:** Нэр дэвшигчийн талаар гаргасан Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Зам, тээврийн хөгжлийн сайд Сандагийн Бямбацогт танилцуулна. Индэрт индэрт урьж байна.

**С.Бямбацогт:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүдийн бүрэн эрхийн хугацаа дууссантай холбогдуулан Монгол Улсын

Үндсэн хуулийн 65 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилуулахаар санал болгосон нэр дэвшигчийн талаарх асуудлыг Хууль зүйн байнгын хороо 2023 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн хуралдаанаар хэлэлцлээ.

Монгол Улсын Үндсэн хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас Лувсандоржийн Өлзийсайханыг, Монгол Улсын Ерөнхийлөгчөөс Эрдэнээгийн Энхтуяаг, Монгол Улсын дээд шүүхээс Одонхүүгийн Мөнхсайханыг Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилуулахаар тус тус санал болгосон.

Байнгын хороо уг асуудлыг хэлэлцэж Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилуулахаар санал болгосон Лувсандоржийн Өлзийсайхан, Эрдэнээгийн Энхтуяа, Одонхүүгийн Мөнхсайхан нарыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Мөн Монгол Улсын Үндсэн хуулийн 65 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийн хугацаа нь дуусгавар болсон тул Одбаяр, Чинбат нарыг Үндсэн хуулийн цэцийн гишүүнээс чөлөөлөх тухай, Өлзийсайхан, Энхтуяа, Мөнхсайхан нарыг Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилох тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж байна.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилуулахаар санал болгосон нэр дэвшигчийн талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье ээ.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Г.Занданшатар:** Чуулганы нэгдсэн хуралдаанд нэр дэвшигч Лувсандоржийн Өлзийсайхан, Эрдэнээгийн Энхтуяа, Одонхүүгийн Мөнхсайхан нар хүрэлцэн ирсэн байна.

Нэр дэвшүүлсэн байгууллага болон нэр дэвшигчдээс асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд байна уу. Бямбацогт, Батжаргал гишүүнээр тасаллаа. Лхагвын Мөнхбаатар гишүүн.

**Л.Мөнхбаатар:** Үндсэн хуулийн цэцийн гишүүнд нэр дэвшиж байгаа 3 нэр дэвшигчийг бол гурвууланг нь дэмжиж байгаа. Хууль зүйн салбарт хүлээн зөвшөөрөгдсөн, салбартаа одоо олон жил ажилласан, онол практикийн туршилагатай хүмүүсийг бол нэр дэвшүүлсэн байна.

Мөнхсайхан докторын хувьд бол ерөөсөө л одоо Үндсэн хуулийн хяналтаар мэргэшсэн Монголын цөөхөн эрдэмтэн, судлаачдын нэг. Сүүлийн үед энэ чиглэлээр хамгийн олон бүтээлүүдийг туурвиж байгаа. Нөгөөтээгүүр Үндсэн хуулийн хүрээлэнгийн захирал хийж байгаа байх гэж бодож байна. Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахад бол хамгийн идэвхтэй, сайтар ажилласан ийм оэрдэмтэн хүн нэр дэвшиж байна. Энэ дагуу Үндсэн хуулийн онолоор мэргэшсэн хүн Үндсэн хуулийн цэцэд очно гэдэг маань бол Үндсэн хуулийн цэцийн гаргаж байгаа шийдвэрүүд, маргааныг хянан шийдвэрлэхдээ онолын үндэслэлтэй гарахад нь их чухал болов уу гэж би бодоод байгаа юм. Онолын үндэслэл гаргахад. Энэ ч агуулгаараа Цэцийн шийдвэр өөрөө хүлээн зөвшөөрөгдөх чанар дээр бол хамгийн чухал гэж бодож байгаа юм. Энэ агуулгаар нь бол би Мөнхсайхан докторыг дэмжиж байна.

Энхтуяа нэр дэвшигчийн хувьд бол хууль зүйн практикийн чиглэлээрээ хамгийн сайн мэргэшсэн ийм хүн. Хууль зүйн бодлогын газар гээд хуулийн төсөл боловсруулдаг газар нь олон жил ажилласан, хуулийн хэрэгжилтийг

зохион байгуулдаг, бодлогын хэрэгжилтийг зохицуулдаг газрынх нь даргаар бас олон жил ажиллаж байгаа. Ер нь хуулийг хэрхэн хэрэгжүүлэх үү, хууль тогтоох болоод гүйцэтгэх эрх мэдэл, шүүх эрх мэдлийн хоорондын хамтын ажиллагаа уялдуулах ажлууд дээр ч гэсэн ажилласан ийм сайн туршилагатай Монголын бас зарчимтай шударга ийм хуульчдын нэг. Энэ агуулгаар нь бол дэмжиж байгаа юм. Ер нь бол Үндсэн хуулийн цэц үндсэн эрхийн маргааныг шийдвэрлэх энэ чиглэл рүү явж байна. Бусад улс орнуудад ч гэсэн үндсэн эрхийн маргааныг Үндсэн хуулийн цэц шийдвэрлэдэг болж байгаа. Үндсэн хуулийн цэцийн тухай хууль, Үндсэн хуулийн цэцийн процессын хуульд бас өөрчлөлт оруулахаар Улсын Их Хурал дээр ажлын хэсэг байгуулагдаад ажиллаж байгаа. Үндсэн эрхийн маргааныг шийдвэрлээд ирэх юм бол Энхтуяа нэр дэвшигчийн дадлага туршилага бол маш их чухал хэрэг болно гэж үзэж би дэмжиж байгаа юм.

Өлзийсайхан нэр дэвшигчийн хувьд бол ер нь бол хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдэл гурвуулд нь ажилласан. Шүүгчээр ажиллаж байсан, Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргаар одоо хүртэл бүх шатад ажиллаад, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт бас Газрын даргаар ажиллаж байсан ийм туршилагатай. Парламентын чиглэлээр өөрөө эрдмийн зэрэг, докторын зэрэг хамгаалсан ийм хүн бол нэр дэвшигч Үндсэн хуулийн цэцэд очиход бол Үндсэн хуулийн цэцийн шийдвэрүүд үндэслэлтэй гарахад ялангуяа төрийн эрх мэдэл хуваарилах зарчмын хэрэгжилтийг хангаж ажиллаж байгаа үүнтэй холбоотой маргааныг хянан шийдвэрлэхэд бол 3 байгууллагынхаа үйл ажиллагааг бас мэдэх ийм хүн очиж байна гэж энэ агуулгаар нь би дэмжиж байна. Монгол Улсын гавьяат хуульч.

Цэцэд нэр дэвшиж байгаа 3 хүнд бол бас захиж хэлэх зүйл байна. Үндсэн хуулийн цэц өөрөө зөвхөн Үндсэн хуулийг

л удирдлага болгон хэрэг маргааныг шийдвэрлэдэг байгаа. Гэтэл сүүлийн үед цэцүүд маргааныг шийдвэрлэхдээ Үндсэн хуулийг бий бусад хуулийг зөрчсөн байна. Тийм хуулийн тийм заалтыг зөрчсөн байна гэсэн ийм үндэслэл бүхий шийдвэрүүд бас олноор гарч байгаа. Энэ бол зохимжгүй гэдгийг бол та бүхэн маань мэдэж байгаа. Зөвхөн Үндсэн хуульд л захирагдаж Үндсэн хуулийн цэцийн гишүүн шийдвэр гарна. Үндсэн хуульд үндэслэж шийдвэрүүдээ гаргана. Үндсэн хууль зөрчсөн эсэхийг л шийдвэрлэнэ. Бусад хуулийг хууль зөрчсөн асуудал бол шүүхийн асуудал шүү гэдгийг би та бүхэндээ хэлье. Бусад хууль бусад хуулиа зөрчсөн байх юм бол энэ шүүхийн асуудлууд болно. Тийм ээ. Тодорхой албан тушаалтны бусад хууль зөрчсөн ч гэсэн ийм зүйл болно гэдгийг бас та бүгдэдээ хэлье гэж бодож байна.

Ингээд Үндсэн хуулийн цэцэд нэр дэвшиж байгаа 3 нэр дэвшигчийг гурвууланг нь дэмжиж байгаагаа хэлье. Та бүхэнд амжилт хүсье.

**Г.Занданшатар:** Мөнхбаатар дарга дэмжиж үг хэллээ. Даваажанцангийн Сарангэрэл гишүүн.

**Д.Сарангэрэл:** Баярлалаа. Мөнхбаатар дарга хуульч хүн учраас бол 3 нэр дэвшигчээ их сайн тодорхойлчихлоо. Тэгэхээр би бас давхцуулахгүй өөрийнхөө зүгээс үгээ хэлье гэж бодож байгаа. Үндсэн хуулийн цэцийн сүүлийн үеийн шийдвэрүүд Улсын Их Хурлаас ч тэр, олон нийтийн зүгээс ч тэр шүүмжлэл нэлээн дагуулж байгаа. Манай 3 нэр дэвшигч Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилогдвол ер нь ямар зарчим барьж, хэрхэн яаж ажиллах ийм бодлого төлөвлөгөөтэй орж ирсэн бэ. Тэрийгээ та 3 маань 1 товчхон тодорхойлж хэлээч ээ гэж.

2 дугаарт, Монгол Улсын Ерөнхийлөгч Үндсэн хуулийн цэцэд Д.Энхтуяа гэж онол практикийн аль аль нь туршлага сайтай ийм эмэгтэйг нэр дэвшүүлж байна. Өнөөдөр Үндсэн

хуулийн цэц 9 гишүүнтэй. Ерөөсөө ганцхан эмэгтэй гишүүнтэй байгаа юм. Тэгээд өнөөдөр Их Хурлаас 1, Ерөнхийлөгчөөс 1, Улсын дээд шүүхээс Мөнхсайханыг нэр дэвшиж оруулж ирж байгаа юм байна. 3 нэр дэвшигчийг гурвууланг нь дэмжиж байгаа. Аль аль нь бол чадварлаг боловсон хүчнүүд. Би илүү ойр ажилласаныхаа хувьд бол Өлзийсайхан даргынхаа талаар бас хэдэн үг хэлье гэж бодож байна.

Манай Үндсэн хуулийн цэцэд бол эмэгтэйчүүд хүч түрэн орж ирж байгаа нь үнэн сайн хэрэг. Тэнд бас бодитой шийдвэрүүд гарахад та бүхний маань нөлөө нэлээн гарах байх гэж ингэж бодож байна. Манай Өлзийсайхан дарга Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргаар ажиллах хугацаандаа бол үнэхээр хийгүй сайн ажилласан даа. Өнөөдөр Улсын Их Хурлын дарга маань нэлээн гар мухардана байх гэж бодож байна. Бас яаралтай манай Өлзийсайханы хэмжээнд хүрэх бас хүнийг олж тавихад бас тийм амар байхгүй болов уу. Тэгээд Өлзийсайхан маань бол ер нь гишүүдтэйгээ их ойр, нягт ажилладаг, хариуцлагатай. Ямар ч асуудлууд тавиад ороход бол зарчмын дагуу шийдэлтэй гарах арга замыг хэлж өгч, ингэж ажилладаг ийм эмэгтэй. Тэгээд би Үндсэн хуульд бол ийм чадварлаг, алуу насандаа маш олон бүтээл туурвисан байна лээ. Би тэр тодорхойлолттой нь танилцлаа. 20 бүтээл туурвисан байна манай Өлзийсайхан. 17 өгүүлэл, нийтлэл бичиж хэвлүүлсэн ийм эрдэмтэн хүн байна. Хууль зүйн ухааны доктор, дэд профессор ийм хүн бол Үндсэн хуулийн эгнээг баяжуулна гэдэг бол үнэхээр их сайн хэрэг. Тэгээд Энхтуяадаа, Мөнхсайхандаа, Өлзийсайхандаа та 3-даа гурвууланд нь амжилт хүсэж байна.

Үндсэн хуулийн цэцэд шинэ уур амьсгал оруулж ирэх, шинэ хандлага бий болгох, одоо энэ шүүмжлэлд өртөөд байгаа энэ зүйлүүдийг засаж залруулахад бол та бүхэн маань бас хувь нэмрээ

оруулсан, шинэ салхи оруулан ингэж ажиллана байх гэж бүрэн итгэж байгаа учраас та гурвыгаа бүрэн дүүрэн дэмжиж байгаагаа илэрхийлж амжилт хүсэж байна. Тэгээд асуултдаа хариулт авъя. Гурвуулангаас нь дунд нь асуулт тавьсан байгаа.

**Г.Занданшатар:**

Даваажсанцангийн Сарангэрэл гишүүний асуултад хариулна. 83-аас эхлээд нэр дэвшигч нар хариулна. 83.

**Л.Өлзийсайхан:** Намайг Лувсандоржийн Өлзийсайхан гэдэг. Сарангэрэл гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр Үндсэн хуулийн зорилго, зориулалт гэдэг бол хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, төрийн аливаа дур зоргыг хязгаарлахад бол оршдог. Тийм учраас Үндсэн хуулийн үзэл санаа, Үндсэн хуулийн заалт бүрд шингэсэн тэр хэм хэмжээ, түүний агуулгыг тайлбарлан хамгаалдаг оюун ухааны онолын шүүх бол Үндсэн хуулийн цэц гэж миний бие үздэг байгаа юм. Тийм учраас нэгд, Үндсэн хуулийн зарчимд миний бие үнэнч ажиллана.

2-т Үндсэн хуульд үнэнч ажиллана, мөн мэргэжилдээ би үнэнч ажиллана гэж танд хариулъя. Монгол Улсын Үндсэн хуулийн 64 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт бол Монгол Улсын Үндсэн хуулийн цэц бол Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх бүрэн эрх бүхий байгууллага гэж тодорхойлсон байгаа. Гол амин сүнс бол Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа мөн гэж хуульчилсан байгаа. Тэгэхээр Үндсэн хуульд Үндсэн хуулийн цэцийн гишүүн бол захирагдаж ажиллана. Аливаа байгууллага, албан тушаалтан, бусад хүнээс бол хараат бус ажиллана.

**Г.Занданшатар:** 84. Энхтуяа нэр дэвшигч.

**Э.Энхтуяа:** Сарангэрэл гишүүний асуултад хариулъя. Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр хэрвээ ажиллавал Үндсэн хуулийг чандлан сахиулах чиг үүргийнхээ хүрээнд хууль дээдлэн ажиллана. Ер нь өнгөрсөн хуулийн салбарт ажилласан 23 жилийн хугацаанд барьж явдаг зарчим хууль дээдлэх зарчим байдаг. Тэгэхээр Үндсэн хууль бол хүний эрх, эрх чөлөөг бататган бэхжүүлсэн, үндэсний тусгаар тогтнол, эрх чөлөө энэ суурь харилцааг зохицуулсан ийм хэм хэмжээ. Улс төрийн ийм чухал баримт бичиг байдаг. Тэгэхээр Үндсэн хуулийн үнэт зүйл болсон хүн төрөлхтний болон Монгол Улсын үнэт зүйл болсон Үндсэн хуулийг чандлан сахиулж, хууль дээдлэн ажиллах болно.

**Г.Занданшатар:** 85. Мөнхсайхан Доктор. Одонхүүгийн Мөнхсайхан.

**О.Мөнхсайхан:** Сарангэрэл гишүүний асуултад хариулъя. Мөнхсайхан байна. 1992 оны Үндсэн хуулийн өмнөх Үндсэн хуулиудаас ялгаатай хамгийн гол нэг шинж нь бол Үндсэн хуулийг зүгээр нэг тунхаг төдий биш, бодит амьдрал дээр хэрэгждэг ийм баталгааг бүрдүүлсэн. Энэ нь бол Үндсэн хуулийн цэц, тэгээд Үндсэн хууль тогтоогчид маань хүний эрхийг болон эрх зүйт төрийн зарчмыг баталгаатай хэрэгжүүлэх механизм байдлаар бүрдүүлсэн. Тэгээд Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр хэрвээ миний бие томилогдох юм бол өнгөрсөн хугацаанд хуримтлуулсан мэдлэг, чадвараа дайчлан ажиллаж, Монгол Улсын Үндсэн хуульд захирагдаж, хараат бус төвийг сахиж ажиллана гэж бодож байгаа. Тухайлах юм бол, Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийн үндэслэлийг сайжруулахад өөрийгөө дайчлан ажиллана. Энэ дээрээ бол өнгөрсөн хугацаанд бас хийж ирсэн судалгааны туршилага маань хэрэг болох юм болов уу гэж найдаж байгаа.

2 дугаарт Үндсэн хууль гэдэг бол Үндсэн хуулийн эрх баригч Чимэд багшийн хэлснээр алганд багтсан Монгол



Улс. Тэгэхээр энийг хамгаалж, бэхжүүлэх Үндсэн хуулийг зарчим, үзэл санааных нь үүднээс оновчтой тайлбарлаж, чандлан сахиулахад хувь нэмэр оруулна гэж бодож байгаа. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Баагаагийн Баттөмөр гишүүн.

**Б.Баттөмөр:** Үндсэн хуулийн цэцийн гишүүнд нэр дэвшиж байгаа нэр дэвшигч нарыг бол дэмжиж байна. Цэцэд орж ирж байгаа цус сэлбэлт бол бас зөв зүйтэй. Хүмүүсийн томилгоо сонголт бол зөв болсон байна гэж ингэж үзэж байгаа. Үндсэн хуулийн цэцийн тухай хууль 1992 онд батлагдсан. 11 удаа өөрчлөлт орсон. Яг одоо Цэцийн үйл ажиллагааг боловсронгуй болгох, тэр хууль дээдлэх, судалгаа гээд энэ юмнууд нь бол хуульд нь байдаг боловч яг Цэцийн хуульдаа бол тэрийг барьж ажиллах эрх зүйн орчныг нь бид нар бүрдүүлж өгч чадахгүй яваад байгаа юм. Тийм учраас өнөөдөр янз бүрийн санал шүүмжлэл маш их гарч байгаа шүү дээ. Тэгээд Цэцийн шийдвэрүүд манай сая зарим гишүүд ярьж байна захиалгатай. Дарга нарын албан тушаалтнуудын үүрэг даалгаврыг биелүүлдэг ийм болчихсон байгаа шүү дээ. Уг нь Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих гэж байгаа шүү дээ. Үндсэн хууль гэдэг чинь Монголын ард түмний эрх ашгийг л хамгаалах ийм л хууль шүү дээ. Тэгтэл энийгээ умартаад явчихсан. Тэгээд энэ 9 гишүүний 3-ыг 3 субъект томилно. Тэгээд 6 жилийн хугацаатай томилно. 1 удаа улируулж томилно гэснийг хязгааргүй болгочихсон байгаа. Тэгэхдээ аливаа юманд ер нь хэмжээ хязгаар байх ёстой л доо. Үүнээс эхлээд л гажуудлуудал үүссэн ийм байгаа юм.

Манай улсад Цэцэд ажилладаг зарим хүмүүс цэцийн дээр хөх тэнгэр байдаг гэж ярьдаг юм шиг байна лээ. Тийм юм бол байхгүй шүү дээ. Монголын ард түмэн байгаа. Энийг та бүгд санаж ажиллах ёстой гэж ингэж хэлэх гэж

байгаа юм. Үндсэн хуульд нийцсэн хуулийг дээдлэх, судалгаанд үндэслэх, төвийг сахих, бие даасан, ил тод байх нь Цэцийн үйл ажиллагааны үндсэн зарчим гэж байгаа юм. Тэгээд судалгаа энэ тэр нь мэдэхгүй яаж хийдэг юм. Би одоо энэ дээр Цэцийн тэр 04 дүгээр дүгнэлтийг хэлэх гэж байгаа юм. Ямар ч судалгаа мэргэжлийн байгууллагуудаас нь судалгаа авалгүйгээр шууд очиж баахан мэддэг, мэддэггүй хүмүүсийг цуглуулж байгаад ийм шийдвэр гаргасан, захиалгатай. Яах вэ Монголд тэр татвар нь о их мөнгөтэй болчихсон юм бол татвар нь ч яах вэ. Хамгийн аюултай нь энд юу вэ гэхээр Монголын ард түмний эрүүл мэндийн эсрэг ийм шийдвэр цэц гаргасан. Дэлхий нийтээрээ бол 1 уур амьсгалаар амьсгалж байгаа. Дэлхийн олон орноос хөөгдсөн хүмүүсийн эрх ашгийг цэц хамгаалсан. Үүгээрээ бол захиалгатай. Магадгүй ашиг сонирхлын зөрчлүүд ч байсан байж магадгүй гэж үздэг ийм юм байгаа юм. Тэгээд та бүгд хуулиа дээдэлж ажиллах ёстой, хуулиа дээдэлж ажиллах ёстой.

Цэц гишүүд бас боломжийн цалинтай. Том том өрөөнд суудаг, том том машин унадаг. Энэ 2024 онд гэхэд л 348 сая төгрөгөөр цалингийн сангаа нэмэгдүүлээд л явсан. Цалин нэмж болно. Тэгэхдээ Монголын ард түмний чинь 28 хувь нь ядуурчихсан, 15 хувь нь ядуурах магадлалтай болчихсон байгаа шүү дээ. 15 мянган хүн орох оронгүй байгаа. Эндээс 1500 нь Улаанбаатар хотод орох оронгүй явж байна шүү дээ. Тэгээд би энэ юманд шударга хандах ёстой. Та нарын ахуй хангамж, цэцийн гишүүдийн ахуй хангамж бол багадаагүй ээ. Би бол энэ нэмэх гэж байгаа цалин энэ тэрээсээ татгалзах хэрэгтэй гэж хэлэх гэж байгаа юм. Асар их олон асуудлууд энд бий.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Үг хэллээ, санал хэллээ Баттөмөр гишүүн. Одоо Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн. Асуулт, үг хамт.

**Б.Бат-Эрдэнэ:** Баярлалаа. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнд нэр дэвшиж байгаа хүмүүстэй бол ярих юм алга. Дэмжиж байгаа. Ер нь нийтлэгээр нь нэг хэлэх юм бол энэ хамаарал бүхий асуудлууд байгаад байдаг. Тэрийгээ та бүхэн маань сайн бас нэг загасны мах заагтай ялгаатай. Улсын нийтийн төрийн эрх ашгийн үүднээс аливаа ажил асуудалд хандаж байх нь зөв байх гэж. Би юу хэлэх гээд байна вэ гэхээр зэрэг. Хүний эрхийн комиссыг бид нар чинь 2 жилийн өмнө билүү Их Хурлаар хэлэлцээд томилж байхад би бас тодорхой санал байр сууриа хэлж байсан. Тэгээд дандаа нэг ангийн төгсөлтийнхөн хоорондоо хамааралтай. Хуулийнхан чинь цус ойртолт гэдэг шиг ийм юм байна шүү дээ. Тэгээд шүүхэд мөн л тэр хүмүүс нь байж байдаг. Прокурор, цагдаад тэгээд өмгөөлөл. Тэгээд өнөөдөр Хүний эрхийн комиссын үйл ажиллагаа бол Их Хурал дээр нэр заагдаад дутагдал бүр тодорхой заагдаж, яригдаж байна шүү дээ. Тэгээд тийм учраас энэ зүйлийг анхаарах хэрэгтэй байх гэж.

Дараагийн нэг хэлэх гээд байгаа юм бол Үндсэн хуулийн цэц бол нэр хүнд өндөр байх ёстой, ихээхэн хариуцлагатай шийдвэр гаргадаг байх ёстой. Яагаад би ийм зүйл хэлэх гээд байна вэ гэхээр сүүлийн үед яригдаж байгаа ганц жишээ хэлэх юм бол хуурамч шатахуунтай холбоотой асуудлыг би хэлэх гээд байна шүү дээ. Яагаад Үндсэн хуулийн цэц эдийн засагтай холбоотой юмыг очиж тийм их сонирхолтойгоор шийдвэрүүд гаргаад байдаг болов. Энэ дээр та нөхдүүд маань онцгой анхаарах хэрэгтэй байх шүү гэж ийм зүйлийг би хэлэх гээд байгаа юм. Энэ чинь Үндсэн хуулийн цэц бол Үндсэн хуулийн манаач гэж ингэж ярьдаг байсан шүү дээ. Тэгээд яагаад энэ үүргээ биелүүлэхгүй ийм эдийн засгийн сонирхолтой ийм Цэцийн дүгнэлт, шийдвэр юмнууд гаргаад байдаг болов гэж нэг ийм зүйл.

Дараагийнх нь юм бол ашиг сонирхлоос ангид байхтай холбоотой. Одоо Улсын Их Хурал дээр байж байгаа хүмүүс чинь Монгол төрийн нэр хүнд яагаад уруудаад байна гэхээр Монгол төр, Их Хурлыг үеийн үед бүрдүүлж ирсэн энэ хүмүүсийн ёс зүй, хариуцлагатай холбоотой асуудлуудаас л ийм байдал бий болж байгаа шүү дээ. Дандаа хувийн эрх ашгийг өмнөө тавина. Өөрийнхөө эхнэр, хүүхэд, хамаарал бүхий хүмүүсээ төрийн ажил албан тушаалаар байнга томилуулна. Хэчнээн жил 10, 20 жил томилуулчихсан хүмүүс байж байгаа шүү дээ. Тэгээд үр хүүхдүүдээ залгуулна.

Дээрээс нь энэ төсөл, тендер, концесс, лиценз оюу байдаг юм холбоотой юмнуудыг бүгдийг нь өөрийнхөө хамаарал бүхий компаниудаар авна. Төр ард түмний нэр барьж авсан зээл, бонд элдэв тухай юмнуудыг өөрийн компаниудаар авна. Яагаад би энэ асуудлыг хэлж байна вэ гэхээр зэрэг ажлын хэсэг байгуулахыг шаардаж ажлын хэсэгт ажиллаж байсан хүний хувьд би ийм зүйл хэлээд байна шүү дээ. Ямар нэгэн хамаарал бүхий боломжоо ашиглаад, тэгээд эндээс эвтэйхэн өөртөө ашигтайгаар сугараад үлддэг. Хууль хяналтын байгууллагынхантай маш нягт ойрын сүлжээ хамаарал бүхий ийм зүйлүүдийг бий болгочихсон энэ хүмүүс чинь.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Санал хэллээ, үг хэллээ. Үг асуулт 2 хамт явж байгаа. Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн.

**Ц.Даваасүрэн:** Би нэр дэвшиж байгаа хүмүүсийн хувьд одоо бол тэгж байна, ингэж байна гэж хэлэхгүй. Зүгээр ер нь та нар цаашидаа яаж ажиллахыг чинь харж байж л дүгнэнэ. Би одоо хаширсан хүн. Олон цэцэд явсан хүмүүсийг дэмжээд л явуулсан. Гэтэл тэр Чинбатыг хар, Монголын төрөөр хэдэн жил тэжээлгэсэн. Оюуны өмчийн даргаар хэдэн жил ажилласан. Гэтэл эцсийн дүндээ Монголын төрийг

самарчхаад явж байна шүү дээ. Үндсэн хуулийг өөрчилчхөөд явж байна шүү дээ. Ардчилсан сонгуулийн арга хэлбэрүүдийг байхгүй болгоод хаячихсан. Үндсэн хуулийн цэц эцсийн шийдвэрээ эргээж харсан тийм бузар үйлдлийг хийсэн байхгүй юу. 2016 онд пропорциональ элемент Үндсэн хуулийн байхгүй байна гэж хэлчхээд, тэгээд сая 2022 онд яасан байна гэж байгаа байхгүй юу. Байна гэж. Тэгээд өөрөөр хэлбэл одоо ингээд намын жагсаалтаар сонгууль хийдэг. Үндсэн хууль зөрчсөн ийм зүйлийг оруулж ирсэн. Ард түмэн бол өөрчлөгддөггүй. Ард түмнээрээ шүүлгэвэл өөрчлөгддөггүй. Нам бол ямар ч хэлбэрийн, ямар чиглэлийн нам цаашидаа энэ хэдэн 10, 100 жилд гарч ирж мэдэх байхгүй юу. 2019 оны гашуун төрхийг бид нар хэзээ ч мартаж болохгүй. Монгол Улсын парламент нь Засгийн газартайгаа шийдвэр гаргаж байсан тохиолдол бий шүү. Тусгаар тогтнолынхоо эсрэг. Гэтэл ийм юмны суурийг тавьж өгсөн. Намын жагсаалтаар ард түмнээр биш шүүлгэдэг ийм бузрын юмыг хийж өгсөн байхгүй юу Үндсэн хуульд. Хэн гуай ч Монголын төрд шургалж болох. Монголын ард түмнээр шүүлгэхгүйгээр. Тийм учраас одоо би Үндсэн хуулийн цэц, жишээлбэл 2019 онд намын жагсаалтыг бид нар энэ чуулганы хуралдаанаар унагасан. Намын жагсаалтаар сонгох уу, үгүй юу гэдэг пропорциональ системийг. Гэтэл Үндсэн хуулийн журмын тухай хуулиар 8 жилийн дотор энийг дахиж хөндөж болдоггүй. Мөнхсайхан чи мэдэж байгаа байх. Чи бас энд сууж л байсан. Гэтэл юун 8 жилийн дотор 1 жилийн дараа энэ асуудлыг хөндөж байхад Үндсэн хуулийн цэц таг л байгаа байхгүй юу. Хөндчихсөн асуудлаа дахиад хөндөж байхад таг л байгаа байхгүй юу. Үндсэн хуулийн цэц манаачаа хийж чадах битгий хэл түрүүний Бат-Эрдэнэ гишүүний хэлдэг шиг сүүлдээ бизнест хутгалдаж эхэлсэн. Хуурамч шатахуун болохгүй гэж байхад гаргасан Их Хурлын шийдвэрийг болно гээд оруулж ирсэн. Тэгээд үндсэндээ төрийг самарч эхэлсэн

Үндсэн хууль. Энэ юу гэвэл Монголын тусгаар тогтнолыг ч 1 өдөр ямар ч шийдвэр гаргаж мэднэ. Энийг Их Хурал өөрчилж чадахгүй юм байна лээ шүү дээ. Их Хурал өөрчилж чадахгүй юм байна лээ. Эцсийн суудлаараа шийдвэр гаргачихвал бид нар яаж ч чадахгүй юм байна лээ. Тэгэхээр маш хариуцлагатай юманд та нар очиж байна. Энэ төр тогтвортой байх уу, цаашидаа ирээдүй нь ямар байх вэ гэдгийг Үндсэн хуулийг нь манаж очиж байгаа юм. Гэтэл Үндсэн хуулийн манаач маань Үндсэн хуулийг агуулгаар нь өөрчилдөг болж хувирсан. Өөрөө өөрчилдөг болж хувирсан. Баярцогтыг сайдаас огцруулах санал бид нар оруулахад Их Хуралд гишүүнд эрх нь байгаад байхад болохгүй гэдэг дүгнэлтийг анх 2015 онд Цэц гаргаж, тэрнээс хойш эн Их Хурлын эрх мэдэл хумигдаж эхэлсэн байхгүй юу. Өөрийн сонгож байгуулсан Цэц нь эргээд Их Хурлаа шулж идсэн байхгүй юу. Их Хурлаа чадваргүй болгосон байхгүй юу.

Тийм учраас Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр очно гэдэг бол тоглоом биш юм билээ. Маш хариуцлагатай ажиллаарай. Залуу хүмүүс очиж байгаа юм байна. Олон жил сууж магадгүй. Тэгэхдээ улс орны хувь заяа байгаа. Үндсэн хууль гэдэг чинь улс орны хувь заяа. Хариуцлагатай ажиллаарай. Одоо тэгээд амьдралаар л та нарын сайн муу нь шүүгдэнэ. Өөр надад одоо хэлэх юм алга.

**Г.Занданшатар:** Салдангийн Одонтуяа гишүүн.

**С.Одонтуяа:** Тэгэхээр цэцийн гишүүн шинээр томилогдож байгаа хүмүүс бол бас цаг хугацаа харуулах байх. Хэн нь яаж ажиллах вэ гэдгийг. Тэгэхээр өнгөрсөн хугацаанд Үндсэн хуулийн цэц бол олон асуудлуудыг хэлэлцэж шийдвэрлэсэн. Энэ шийдвэрүүд дотор хэт их улс төржсөн, захиалгатай, хуйвалдааны чанартай, хууль бус олон шийдвэр гарсан. Сая Даваасүрэн гишүүн нэг бүрчлэн бас хэлчихлээ. Тэгэхээр энэ

шинээр орж байгаа хүмүүст тийм л зүйлийг хүсмээр байна. Ерөөсөө чин шударгаар ажиллах хэрэгтэй. Шударгаар. Өнөөдөр жишээлэхэд нэг даргынхаа юм уу, нэг албан тушаалтан, нэг бүлэглэлийн, нэг найзынхаа хүсэлтийг биелүүлсэн байж болно. Гэхдээ энэ нь бол өөрөө цаашидаа ард түмэнд, улс оронд ямар их хор хохирол учруулдаг гэдгийг л ухамсарлаж ажиллах ёстой. Энийг л одоо гол нь та нарт захиж байна. Ялангуяа би бол эмэгтэй гишүүдэд бол итгэж байна. Яагаад гэхээр эмэгтэйчүүд хаа очсон газраа аль болохоор шударга ажиллахыг эрмэлздэг. Янз бүрийн тэр хуйвалдаанд оролцохгүй байх, ер нь энэ хуйвалдаан бол эмэгтэйчүүдийг тойрч гардаг шүү дээ. Тийм учраас шинэ гэлтгүй очоод шууд энэ асуудлыг таслан зогсоох, цаашид ийм асуудал гаргахгүй байх дээр онцгой анхаарч ажиллах ёстой.

Нөгөөтээгүүр хууль дээдлэх ёсыг төлөвшүүлэхэд бол та нар маш их зүйл хийх ёстой. Үндсэн хуулийн цэцийн хараат бус байдлыг баталгаажуулахад олон ажил хийх ёстой. Үндсэн хуулийн цэцийн маргаан хянан шийдвэрлэх тэр процессын хуулийг Олон улсын түвшинд нийцүүлэн боловсруулах хэрэгцээ шаардлага бол маш их байгаа. Энийг хийх хэрэгтэй. Үндсэн хуулийн шүүхийн эрх хэмжээг боловсронгуй болгоход чиглэсэн олон тулгамдсан асуудал байгаа. Энийг хийх хэрэгтэй. Тийм учраас энэ дээр та нар сайн ажиллах ёстой.

Өлзийсайхан даргын хувьд бол бид бас 3 жил хамт ажиллалаа. Тэгэхээр үнэхээр би бол энэ хүнд сэтгэл хангалуун байгаа. Харамсалтай нь манай Их Хурлаас явж байгаад жоохон сэтгэл гонсгор байна. Уг нь энэ ажилдаа улам мэргэшээд, туршлагажсан бол зүйтэй байсан юм. Тэгээд Өлзийсайхан дарга бол олон чухал ийм эрдэм шинжилгээний, судалгааны ажлуудыг хийсэн. Ялангуяа сүүлийн асуудал бол үнэхээр маш чухал асуудлыг бол хийж оруулж ирж байна. Хүний эрх, жендерийн асуудлаар олон улсын түвшинд бид нар ер нь хаана

байгаа юм бэ. Цаашид юу хийх юм бэ гэдгийг бол энэ парламент гаргаж ирж байгаа нь маш сайн.

Би нэг л зүйлийг хэлдэг шүү дээ. Монголчлох гэж оролдох хэрэггүй ээ. Ерөөсөө бид нар олон улсын хэм хэмжээнд л нийцүүлэх л тийшээ ажиллах ёстой юм. Жишээлэхэд, тэр НҮБ-ын нөгөө шүүхийн шийдвэргүй баривчилгааны асуудал дээр би маш олон дуугарахаар надыг өөдөөс юу гэж ам таглаж байна гэхээр үгүй ээ, энэ хүмүүс чинь буруу үнэлгээгээр үнэлчихсэн юм гээд байгаа байхгүй юу. Тэгэхээр бид олон улсын үнэлгээ, механизмд л ойртуулах чиглэлээр ажиллах ёстой. Монголчлох биш. Тийм учраас энэ бол их чухал бүтээл болсон байна. Өөрөөр хэлбэл улс орнуудын парламент хүний эрхийг дээдлэхийн тулд ямар чиг баримжаатай ажиллах ёстой юм бэ гэдгийг бол маш сайн гаргаж ирсэн байна. Ялангуяа энэ 2 товхимол бол олон улсын парламент, хүний эрхийн дээд комиссараас оруулж ирж байгаа парламент ба хүний эрх, жендерийн мэдрэмжтэй байдлын үнэлгээ гээд. Бид нар жендер гэхээр л хэд хэдэн эмэгтэй дарга болох гээд байгаа юм шиг ойлгоод байдаг байхгүй юу. Үгүй, жендер гэдэг чинь эрэгтэй, эмэгтэй бүх хүнд хамаатай. Монгол Улсад өнөөдөр салбаруудад жендерийн зохистой харьцаа алдагдсанаар л энэ хөгжил чинь зарим нь доголдоод байгаа шүү дээ. Тэгэхээр энэ парламентын ардчилал төлөөллийн ардчилал гэдэг зүйлд бол Өлзийсайхан.../минут дуусав/

### **Г.Занданшатар:**

Шатарбилигийн Раднаасэд гишүүн.

### **Ш.Раднаасэд:**

Надад санал байгаа. Би 3 хүнийг дэмжиж байна. Цэц гэж байгууллагыг Их Хурал орж ирэхэд нь бол сайхан дэмжээд л магтаад л гаргадаг л даа. Тэгээд очсон хойноо гарсан шийдвэр бол харилцан адилгүй гарч байгаа нь бас үнэн. 1970, 1980-аад оны төлөөлөл анх удаа Үндсэн хуулийн

цэц рүү орж ирж байна. Яагаад 40 нас гэж заасан юм. Яагаад ажлын туршилага гэж заасан юм. Өөрөө энэ Цэц гэдэг чинь өөрөө Монгол төрийн дархлаа шүү гэдгийг л батлахын тулд Үндсэн хууль дээр хийж өгсөн ийм байгаа. Тэгээд 3 хүнд амжилт хүсье. Ямар ч байсан эхний ээлжид. Аль нэгэн бүлэглэсэн ийм зүйл хараат бус байдалд алдагдуулахгүй байх, хичээж ажиллах ёстой болов уу. Зүгээр миний нэг бодож явдаг юм байдаг юм. Үндсэн хуулийн урьдчилсан хяналт гэдэг юм ерөөсөө хийгдэж чаддаггүй ээ. Бид өгсөн өргөдөл, гомдол, мэдээллийн мөрөөр л юм явагддаг. Урьдчилж хяналт тавих, заавал өргөдөл гаргасан тохиолдолд биш өөрийн хүсэлтээр Цэц өөрөө авч үздэг энэ алхам, мэтгэлцээн рүү орох ёстой бид нар. Орох ёстой. Тэгээд маргаан хэлэлцэх журам дотор нэг ийм утгагүй өгүүлбэр явдаг. Үгчилж явуулна гэж. Тэгээд үг хөөгөөд явчихдаг. Энэ зарчим өөрөө яг том агуулгын асуудлаа унагаагаад, зарим тохиолдолд бүр жижигхэн юм руу аваачаад оруулчихдаг. Нөгөө бөөсний онигоо шиг юм болгочоод байдаг ийм талтай. Цэцийн хуулийг өөрчилж, энэ зүйл дээр нэлээн урьдчилсан хяналтын юмыг түлхүү оруулж ирэх юм бол цэц өөрөө идэвхтэй, 2 дугаарт нийгмийн зүгээс шахалт ихтэй ажиллах ийм боломж нь бас бүрдэх юм болов уу гэж хардаг юм. Энийг та бүхэн бас анхаарч хууль боловсруулахад нь бас оролцоно биз дээ.

2 дахь юм. Ирэх 2024 оноос эхлээд намын жагсаалтаар гишүүд орж ирнэ. Тэгээд албан тушаалтны хяналт гэдэг зүйл Үндсэн хуулийнцэцэд өнөөдөр байгаа. Эргүүлэн татах, огцруулах. Энэ чинь 2024 оны сонгуулиас хойш маш их идэвхэжнэ. Яагаад гэвэл тэр жагсаалтад байгаа гишүүдийг татахын төлөө, тэр жагсаалт өөрөө ажиллаж эхэлнэ. Хойноосоо хөөж. Энэ угаасаа жишиг нь тийм юм байна лээ. Тэгэхээр энэ чиглэл рүү бид нар яг улс төрд хараат бус байж чадах уу, үгүй юү гэдэг шалгуур та нар 2024 оны сонгуулийн ар дээр л их тавигдана даа та нарт. Тэгээд

энд бэлтгэлтэй, энэ дээр тодорхой зарчим юмнуудаа одоогоос процессынхоо хууль дээр юмнуудаа хийж өгч явахгүй бол яг өнөөдрийн байгаагаа хуулиар тогтоомжийнхоо хүрээнд явах юм бол та нар эс үгүй бол хамгийн адгийн хүмүүс яг л дахиад л Их Хурал дээр дуудагддагаараа дуудагдана.

Бас нэг зүйл энэ цэцийн гишүүдийг цэцийн дүгнэлт гаргасных нь төлөө Их Хурал дотор оруулж ирээд асуулт асуудаг баймаар байгаа юм. Үндсэн хууль зөрчсөн асуудал гээд тэр шийдвэр нэгэнт гарчихсаны дараа ямар юмны зөрчлийн асуудал байх вэ. Тийм биш байдлаас болоод энд зүгээр Их Хурлын гишүүд ярих төдийд цэцээс гарсан шийдвэр энд нэг дэлгэрэнгүй шийдвэр уншигдах төдийд юм болоод яваад байгаа юм. Уг нь үүний мөн чанар юм нь бол асуулт, хариулт дээр ард түмэн дүгнэлт хийж байх ёстой. Их Хурал дүгнэлт хийж байх ёстой. Шийдвэр гаргаж байгаа бүх субъектүүд дүгнэлт хийж байх ёстой юм байгаа юм. Тийм учраас энэ хуулийг өөрчилж, шинэчлэх чиглэл рүү бид нар тэртээ тэргүй явна. Энэ дээр залуу хүмүүсийн хувьд та бүхэн идэвхтэй оролцоорой.

**Г.Занданшатар:** Зочид танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Гочоогийн Ганболд, Дуламдоржийн Тогтохсүрэн, Содномын Чинзориг нарын урилгаар Өвөрхангай аймгийн Насан туршийн суралцахуйн төвийн багш, ажилтнууд Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэнд Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс ажил сурлагын өндөр амжилтыг хүсэн ерөөе. Насан турш суралцахуй бол орчин үеийн чиг хандлага болсон бөлгөө.

Ингээд Сандагийн Бямбацогт гишүүн үг хэлнэ.

**Г.Занданшатар:** Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр нэр дэвшиж орж ирж байгаа 3 нэр

дэвшигчийг дэмжиж байгаа. Тэгээд Монголын төрд бас нэг ийм бэлтгэгдсэн, зөв бодолтой, зөв сэтгэлтэй, бас мэдлэгтэй, чадвартай, боловсролтой ийм хүмүүс хэрэгтэй. Одоо гурвуулантай нь хамтарч ажиллаж байсан. Гурвууланг нь сайн мэднэ. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санал болгосон. Мөнхсайхан багш бол 20-оод жил 10 хэдэн жил МУИС-д багшилж байсан. 2019 онд бид нар Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт дээр ажиллаж байсан энэ цаг үеэс нь сайн мэднэ. 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт бол гарцаа байхгүй сүүлийн 20-иод жил Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт хийе. Монгол төрийн бас тогтолцоогоо засъя. Эрх мэдлийн хуваарилалтыг бас боловсронгуй оновчтой болгоё. Улсын Их Хурлын хязгааргүй эрх мэдлийг хязгаарлая гэдэг хүрээндээ бол нэлээн сайн өөрчлөлт болсон. Энд бас гар бие оролцож ажлын хэсэгт ажиллаж байсан. Энэ үүднээсээ 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг сайн өөрчлөлт болсон гэж үздэг.

Их Хурлаас санал болгож байгаа манай Өлзийсайхан багшийн хувьд ч гэсэн ялгаа байхгүй. Өлзийсайхан дарга. Улсын Их Хурлын Тамгын газрын дарга сүүлийн 3 жил ажиллалаа, 4 жил ажиллалаа. Бас Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр бас ажиллаж байсан. Олон жил бас парламентаар мэргэшсэн, Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр мэргэшсэн ийм хүн байгаа. Тэгээд уг нь Тамгын газартаа байсан бол илүү хэрэгтэй байсан байх. Гэхдээ бас чухал, илүү хариуцлагатай ажилд очиж байх шиг байна. Дэмжиж байгаа.

Энхтуяа даргын хувьд 2016 онд Хууль зүй, дотоод хэргийн сайд болохдоо бас яамныхаа газрын даргаар авч ажиллуулж байсан. 20-иод жил хууль зүй, дотоод хэргийн яаманд ажилласан ийм туршилагатай, бас мэдлэгтэй, чадвартай боловсон хүчин. Ийм л хүмүүс Монголын төрд хэрэгтэй байгаа юм. Бас нэг зөв сэтгэлтэй, зөв бодолтой, бас улс эх орныхоо төлөө зарчимтай, улааныг

харж урваж, шарыг харж шарвахгүй, өөрийн гэсэн итгэл үнэмшилтэй, өөртөө итгэлтэй ийм хүмүүс очиж байгаа болохоор Үндсэн хуулийн цэцэд бас нэлээн том салхи, өөрчлөлт орох байх гэж найдаж байгаа. Үндсэн хуулийн цэцийн гаргаж байгаа шийдвэрүүд асуудалтай байдаг. Асуудалтай байсан. Сая гишүүд бас хэлж байна. Заримдаа болдог, заримдаа болдоггүй. 1 гарсан шийдвэр нөгөөдөр өөр болчихдог. Иймэрхүү зүйлүүд бас цаашидаа бас гарахгүй байх. Үндсэн хуульд бид нар 2019 онд хийсэн өөрчлөлтөөр Монгол төрийн бодлого тодорхой байх, тогтвортой байх, урт, дунд, богино хугацаандаа уялдаатай байх, Монгол төр маань өөрийн гэсэн хөгжлийн бодлоготой, хөгжлийн загвартай байх талаар томоохон өөрчлөлт орсон. Урьд нь ялсан нам болгон, эрх баригч болгон, дарга болгон өөрсдийн бодлогоо хэрэгжүүлдэг байсан бол одоо Монгол төр өөрийн гэсэн бодлоготой, өөрийн гэсэн хөгжлийн загвартай, өөрийн гэсэн хөгжлийн замналаар явах энэ бололцоо боломжийг бас нээж өгсөн. Энийг та бүхэн бас улам төгөлдөржүүлэх, улам сайжруулах энэ тал дээр бас илүү анхаарч Үндсэн хуулийн өөрчлөлт, нэмэлт, өөрчлөлтийг хэрэгжүүлэх тал дээр илүү бас санаачлагатай ажиллаасай гэж хүсэж байна.

Мөн одоо бас Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт бас зайлшгүй хийх асуудлууд бас байгаа. Монгол Улс 21 аймагтай бол 21 аймгийн төвүүд хот болох, хот, тосгоны эрх зүйн байдлын асуудал хэрэгжихгүй байгаа. Эдгээр асуудал дээр бас анхаарал тавьж ажиллаасай гэдгийг та бүгдээс бас хүсье. Тэгээд хамгийн сүүлд нь хэлэхэд бас нэр дэвшигч нар маань чадалтай, мэдлэгтэй, чадвартай хүмүүс учраас нэлээн том бас зоригтой бодлогын өөрчлөлт гаргаж ажиллах байх. Үндсэн хуулийн цэцийн тухай хууль бас өөрчлөгдөнө. Тэгээд энийг улам бас Цэц маань бас боловсронгуй болгох ёстой. Тэгээд шинэ уур амьсгал, шинэ салхийг

Үндсэн хуулийн цэцэд авчрахыг бас хүсье ээ.

**Г.Занданшатар:** Жигжидийн Батжаргал гишүүн.

**Ж.Батжаргал:** Баярлалаа. Тэгэхээр Үндсэн хуулийн цэцийн гишүүнд нэр дэвшиж орж ирж байгаа 3 нэр дэвшигчийг дэмжиж байна. Тэгэхээр Үндсэн хуульд эрх зүйт төрийг л төлөвшүүлж байгаа л улс орон л доо. Тэгэхээр эрх зүйн уг углуурга, үзэл санаа нь Үндсэн хуульдаа л захирагдаж, үүндээ л чиглэгдэж явах ёстой. Тийм учраас Үндсэн хуулийн дээд хяналтыг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй Үндсэн хуулийн цэцийн гишүүд бол гагцхүү хуульд захирагдаж, ер нь нэлээн тийм тулхтай, ноён нуруутай л байх ёстой юм. Аливаад савлаад байдаг биш л байх ёстой. Энэ талаасаа асуудалд нэлээн сайн хандах хэрэгтэй болов уу. Энэ байж байгаа байдлыг хараад байхаар зэрэг гарсан шийдвэрээ үгүйсгэж байгаа. Үгүйсгэл энэ тэр бол ер нь бас л асуудалд жоохон тулахгүй л байгаагийн л илэрхийлэл л дээ. Уг үзэл санаа нь ч ер нь бас насны хязгаар энэ тэр юм зааж байгаа явдал бол уг хүмүүсийг өөрийг нь боловсрох, төлөвших, бас нэг аливаад дэвж саваад байдаг хий хуй нь гарсан тийм тулхадсан байх л үйл явцыг л харж хийсэн шийдэл гэж хараад байдаг шүү дээ. Тэгээд энэ талаас 1 дүгээрт их бодмоор юм болов уу гэж.

2 дахь зүйл. Юмыг бас жоохон задалмаар л юм шиг байгаа юм. Дан ганц эрх зүйн заалт уг хөөцөлддөг биш ахуй амьдрал, энэ үндэстний өөрийнх нь тэр үнэт зүйл, үзэл санаа, аюулгүй байдал юмнуудыг нь нэлээн бодож, эргэцүүлж, задалж харж чаддаг л байх ёстой болов уу л гэж бодоод байдаг би. Яг нарийндаа Үндсэн хууль чинь 1992 онд батлагдсан. Баталж байх үеийн оюун санаа, тэр бүрэлдэхүүн энэ бүх юм чинь нэлээн тийм үндэсний өв соёлоосоо бас нэг их холдчихоогүй байх үеийн үзэл санаа дээр тулгуурлагдаад хийгдчихсэн шүү дээ. Ер

нь хэдийгээр бид дэлхий нийтийн эрх зүйн том үнэт зүйл, соёлыг анзаарсан хэдий ч бас үндэстнийхээ гэх юмнуудыг нэлээн барагцаалж, барьж гаргасан ийм л эрх зүйн орчин. Тэгэхээр зэрэг өдрөөс өдөрт бид ахуй амьдрал гэдэг юм уу, энэ үнэт зүйлүүдээсээ жоохон алсрах гээд байгаа энэ цаг үед бид ямархуу байдлаар асуудалдаа хандах юм бэ гэдэг юм өөрөө их сонин ойлголт шүү. Тийм учраас би Үндсэн хуулийн цэцийг үнэхээрийн Үндсэн хуулиар мэргэшсэн эрх зүйчид байна гэж үзэж байгаа бол Үндсэн хуулийн үзэл санаа, үнэт зүйлийг түмэн олонд түгээх, мэдлэгжүүлэх, мэдээлэлжүүлэх асуудлыг бодох л ёстой л гэж бодоод байдаг шүү дээ. Би бол. Энэ яаж хүүхэд залуучуудыг Үндсэн хуулийнх нь үзэл санаа юмнуудыг тархи толгойд нь шингээж, тэр үндэснийх нь бахархал юмнуудыг бий болгох ёстой юм бэ. Энэ бол бид нэлээн л бодох ёстой зүйл байх гэж л ингэж л хараад байдаг. Тэгээд энэ талаасаа бодмоор зүйл юм байна гэж.

Дараагийн нэг зүйл үнэхээрийн л бид энэ зах зээлийн нийгмийг сонгоод л авчихсан бол эдийн засгийн арга механизмүүдын асуудлууд байгаад байна. Тэгэхээр зэрэг энэ талаар гарч буй эрх зүйн зохицуулалтууд Үндсэн хуулийнхаа үзэл санаатай хэрхэн нийцэж байна вэ гэдэг юмнуудыг их л зөв дүгнэх ёсто.

**Г.Занданшатар:** Үг хэллээ. Цэндийн Мөнх-Оргил гишүүн.

**Ц.Мөнх-Оргил:** Баярлалаа. 3 нэр дэвшигчийг дэмжиж байгаа. Сая олон гишүүд чухал чухал саналууд хэллээ. Бодвол өөрсдийнхөө үйл ажиллагаанд тусгаж ажиллана биз дээ гэж найдаж байна. Манай цэцийн бүрэлдэхүүн одоо нэг тийм яг дэнжээ олсон тэнцвэртэй бүрэлдэхүүн болох гээд байна уу даа гэж би харж байгаа юм.

Нэг хэсэг эсвэл улс төрчид давамгайлаад байдаг, эсвэл төрийн албан хаагчид давамгайлах гээд байдаг. Одоо бол Мөнхсайхан багш очсоноор 3 том

судлаачтай болж байгаа юм байна манай цэц. Одоо 3-аас илүү бол байж хэрэггүй байх. Ер нь бол судлаачдыг 3-аар нь л тогтоомоор байгаа юм. Захиргааны ажил алба хашиж байсан нэлээн туршилагатай хэдэн залуу төрийн түшмэлүүд очиж байна. Манай Өлзийсайхан дарга бол одоо яг энэ ажлыг хийхээр нэг талаас насандаа, нөгөө талаас одоо яг мэдлэг боловсрол нь тэгшрээд очиж байгаа хүн л дээ. Онолын мэдлэгтэй, тэгэхдээ тэрийгээ практикийн мэдлэгээр баяжуулчихсан. Тэгээд яг энэ 2-ыг хослуулах нь их чухал байгаа юм.

Би 3 нэр дэвшигчид хүсэж нэг захих гэх юм уу хэлэх зүйл бол бараг дараагийн 7 хоногт байна уу, тэрний дараагийн 7 хоногт Улсын Их Хурлын 5, 6 гишүүнээс бүрдсэн ажлын хэсэг Үндсэн хуулийн цэцийн тухай хууль, Цэцэд маргаан хянан шийдвэрлэх журмын тухай хууль гээд 2 том хуулийг өргөн барьчихна. Энэ одоо бараг жил хагас, 2 жил шахуу хэлэлцэгдэж байгаа олон багш нар, судлаачид, Цэцийн Тамгын газрынх оролцсон ийм хуулиуд өргөн баригдана. Тэр хуулийн гол санаа нь бол Цэцийг яг жинхэнэ утгаар нь шүүх болгоё гэж байгаа юм. Шүүх болгоё, шүүх рүү шилжүүлэе. Тэгэхээр тэр дотор бол процессууд нарийсна, шүүхэд тавьж байгаа шаардлага өндөрсөнөө гээд олон юм орж ирнэ.

2-т нь энд хэрвээ тэр хууль одоо бид нарын өргөн барьснаар батлагдах юм бол Үндсэн хуульд заасан үндсэн эрхийн маргаан Цэцэд хэлэлцэгдэж эхэлнэ. Энэ бол асар том зарчмын өөрчлөлт гарна. Цэцийн ажиллах ажлын арга барил, хандах хандлага, тэнд та нарттус дэм болох туслахуудын тоо, судалгааны ажил гээд маш том өөрчлөлт гарна. Энийг төлөвшүүлэх гэтэл бид нарт бол ахиад 10-15 жил хэрэгтэй болно. Яг жинхэнэ утгаар нь Германууд өөрсдөө бол тэгдэг юм байна лээ шүү дээ. Бид нар бол 25 жилийн дотор л энэ үндсэн эрхийн маргааныг

хэлэлцэж, хүлээн зөвшөөрч, шүүхтэйгээ ойлголцож сурсан гэж. Тэгэхээр бид нарын хувьд бол тийм урт хугацаа байхгүй. 10-15 жилийн дотор л төлөвшүүлэх чухал ажил байгаа. Тэгэхээр та 3 бол энэ том ажлын эхэн дээр очиж байгаа учраас одоо болтол үзсэн юмнуудаа дахиж сэргээх, жишээ нь Энхтуяа нэр дэвшигч бол Мөнхсайхан багшаас Үндсэн хуулийн мэдээж Энхтуяа бол эрх зүйн мэдлэгтэй, онолтой хүн л дээ. Гэхдээ яг Үндсэн хуультай холбоотой эрх зүйн, онолын юмнуудыг бол Мөнхсайхан багшаас жишээ нь нэлээн судалж асуух хэрэгтэй байх. Мөнхсайхан багш ч гэсэн Өлзийсайхан, Энхтуяа 2-оос ажил практикийн тал дээр яг юу байдаг юм бэ гэдгийг нэлээн асууж чухалчлах хэрэгтэй байх.

Тэгээд сүүлд нь нэг л асуудал байгаа юм. Манай Цэц шийдвэр гаргахдаа онолын болон практикийн үндэслэлүүдээ их сул гаргаад байна. Ерөөсөө үндэслэлгүй бичээд байна. Тийм учраас зөрчсөн, тийм учраас зөрчөөгүй гэдэг онолын үндэслэл байх ёстой байгаа байхгүй юу. Энэ ерөөсөө их сул гараад байна. Тэгээд наадах чинь зовлон нь юу байна вэ гэхлээр дараа нь Их Хурал хууль батлахдаа нөгөө үндэслэлийг чинь харж байж ижил төстэй асуудлууд дээр хандах ёстой болчихоод байгаа байхгүй юу. Тэр онолын үндэслэл нь байхгүй болчихлоор Их Хурал одоо хууль тогтоохдоо яг ингээд хууль зөрчсөн гэж хэлчихсэн юм болов уу, эсвэл энэ үндэслэлээр нь гаргачихсан юм болов уу гэдэг мэдэхгүй болчихоод байгаа байхгүй юу. Энэ дээр одоо та хэд маань сайн анхаарч ажиллаарай. Тэгээд ажлын их амжилт хүсье ээ.

**Г.Занданшатар:** Бөхчулууны Пүрэвдорж гишүүн асуулт асууж, үг хэлнэ. Дараа нь санал хураалттай. Гишүүд чуулганы танхимд ирнэ үү.

**Б.Пүрэвдорж:** Юуны өмнө, Өлзийсайхан даргад бас цэцийн гишүүн болж байгаад нь баяр хүргээд бас яг энэ



ажилдаа үнэнч бас тодорхой хэмжээгээр цэцийн үйл ажиллагааг өндөрт гаргасан нэр төртэйгээр албаа хашина гэж итгэж байгаа.

2 дугаарт нь Мөнхсайхан доктороос 1 асуулт асууя. Та прокурорын бие даасан байдал, тулгамдсан асуудал, шийдэл нэртэй судалгааг “Чимэд” сангийн захиалгаар хийсэн. Тэгээд энд бол Улсын ерөнхий прокурор, түүний орлогчийн томилгоог хэн, хаанаас томилох, прокуроруудад яаж хариуцлага тооцох, төсвийн асуудлыг яаж шийдвэрлэх, тэгээд дээрээс нь таны тэр судалгаа дотор Ерөнхий прокурорыг гүйцэтгэх засаглалаас томилох тухай олон орны судалгаанууд орсон байгаа. Тэгээд энэ судалгаа орсонтой холбоотойгоор АНУ-ын тусгай элч энэ тэр гээд байдаг. Тэрний тайлан дотор бас таны тэр судалгаа орчихсон явж байна. Тэгээд энэ чинь Үндсэн хуулийн зөрчил рүү очих юм биш үү. Өөрөөр хэлбэл Үндсэн хуулиар бол прокурорын томилгоог Ерөнхийлөгч Монгол Улсын үндэсний эв нэгдлийг хангах ёстой Ерөнхийлөгч энэ томилгоог хийх ёстой. Тэгэхээр энэ асуудлыгаа судалгаа хэмжээнд явж байсан. Тэгээд таны энэ бодол чинь тэр чигээрээ хамтдаа Үндсэн хуулийн цэц дээр гишүүн болохоор тэр бодол чинь хамт очно. Тэгээд ийм сонирхлын зөрчилтэй асуудлаар та Үндсэн хуулийн цэц дээр очоод энэ байр суурин дээрээ байх уу. Тэгээд энэ асуудал дээрээ хол байх ёстой шүү та. Би танд тэгж анхааруулж байна. Яагаад гэвэл яг энэ судалгаа хийж байсан байр сууриасаа, байр сууриараа очоод, тэр Үндсэн хуулийн цэц дээр тэр албан тушаалыг хашиж болохгүй шүү гэдгийг би танд сануулгыг 1 дүгээрт хэлмээр байна. Тэгээд энэ дээр бас тодорхой хариулт авъя.

Та 3-ыг гол нь нэг зүйл дээр л шударга байгаасай. Ард түмнийхээ талд л шийдвэрүүдийг гаргаж байгаасай. Яг Үндсэн хуулийн зөрчил рүү тэр асуудлыг шийдсэн тэр шийдлийг л зөв гаргаж,

тайлбарлаж чадах юм бол та 3-ын гол ажил чинь бүтэж байгаа нь тэр. Тэгэхээр сүүлийн үед Үндсэн хуулийн цэц бол ямар ч хамааралгүй асуудлаар шийдвэр гаргадаг болсон. 3 жилийн турш зүтгэж явсан тэр хуурамч шатахууны хуулийг Үндсэн хуулийн цэц дээр 6 сард хүчингүй болгосон. 5 нөхөр хуралдаж байгаад шийдсэн. 4 нь дэмжээд, 1 нь эсэргүүцсэн. Тэгээд эндээс бол янз янзын тэр айхтар муухай үнэр ханхалж байгаа. Тэгээд ер нь бол татварын орчин хүн болгонд өөр байдаг. Аж ахуйн нэгжид өөр байдаг. Жишээ нь, Улаанбаатар хотод амьдарч байгаа иргэд 10 хувийн аж ахуйн нэгжийн орлогын татвар төлчөөд, баруун бүсэд амьдарч байгаа хүмүүс 1 хувийн татвар төлдөг. Тэгэхээр энэ нь бол жишээ нь зөрчил байж болно шүү дээ. Гэтэл энийг шийдэхгүй зөвхөн нэг аж ахуйн нэгжийн хүсэлтээр асуудлыг шийдэж байгаад их харамсаж байгаа.

Тэгээд би энэ дээр эсрэг санал өгсөн. Би Баясгалан цэцийн гишүүнийг би үнэхээр ард түмнийхээ төлөө ажилласан гэж дүгнэж байгаа. Цэцийн дарга болоосой гэж бодож байгаа. Ийм л байна. Тийм учраас ер нь бол та бүхнийг ард түмнийхээ төлөө ажиллаасай л гэж би энд сууж байгаа. Тийм учраас.../минут дуусав/

**Г.Занданшатар:** 85. Мөнхсайхан нэр дэвшигч.

**О.Мөнхсайхан:** Пүрэвдорж гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр миний хувьд бол МУИС-ийн Хууль зүйн сургуулийн профессорынхоо зэрэгцээ МУИС-ийн Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэнгийн захирлаар 2 жил шахам ажиллаж байгаа. Тэгээд Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэн бол Үндсэн хуульд ардчиллаа бэхжүүлж хамгаалахад шаардлагатай урт болон дунд хугацааны ийм судалгааг хийдэг. Өнгөрсөн 2 жилд бол ерөнхийдөө 20-30 судлаачид тус тусдаа баг болж маш олон янзын сэдвүүдээр судалгаа хийж, ном эмхэтгэл болгож гаргасан. Энэ хүрээнд бусад

байгууллагуудтай хамтарч хэрэгжүүлдэг ийм төслүүд байдаг. Тэгээд “Чимэд” сантай өнгөрсөн хагас жилийн хугацаанд судалгааны төсөл эхлүүлж, прокурорын бүтэц, зохион байгуулалт, хараат бус, бие даасан, хариуцлагатай байдлыг яаж сайжруулах вэ гэсэн ийм сэдвээр судалгаа хийгдэж байгаа. Энэ судалгааг манай хүрээлэнгийн залуу судлаачид баг болоод хийж байгаа. Хараахан дуусаагүй байгаа ийм судалгааныхаа урьдчилсан байдлыг хүрээлэнгийн судалгааны семинараар хэлэлцүүлсэн. Одоогоор энэ бол эцэслэгдээгүй байгаа. Тэгэхээр тэр судалгааны баг өөрсдийнхөө дүгнэлтийг хийх байх гэж бодож байна. Яг таны сая хэлсэн шиг асуудал Үндсэн хуульд нийцэх эсэх асуудал хөндөгдөх үү. Тэр судалгаа нь байгаа юу, үгүй юү гэдэг бол миний хувьд бол одоо хэлэх боломж байхгүй. Яагаад гэхээр Үндсэн хуулийн цэцийн тухай хуулиар цэцэд очих маргаантай асуудлаар урьдчилсан байр сууриа илэрхийлэхийг хориглодог. Одоогийн байдлаар нэр дэвшигчийн хувьд бол энэ дээр энэ шалтгаанаар бол байр сууриа илэрхийлэх боломжгүй байна. Тэгээд судалгааны дүгнэлт гарахаар бол тэр олон нийтэд хүрэх байх гэж бодож байна.

Зүгээр таны түрүүн дурдсан прокурорын асуудлыг гүйцэтгэх эрх мэдэлд өгөх гэсэн иймэрхүү асуудал бол одоо тэр судалгааны багийн тэр тайлан дээр хэлэлцүүлгийн үеэр бол яригдаагүй. Тэгэхдээ бол тал талын өөрөөр тэр семинарт сууж байсны хувьд юу вэ гэхээр ер нь прокурор гэдэг чинь өөрөө аль зүг рүү явах ёстой юм. Дэлхий нийтэд ямар загварууд байдаг юм. Манайд өөрөө 1930-аад оноос хойш яаж явж ирсэн юм бэ гэдгийг л судлаад явж байгаа юм байна лээ. Тэгээд иймэрхүү байдалтай байгаа гэдгийг бас танд хэлье ээ. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Бөхчулууны Пүрэвдорж гишүүн тодруулж асууя. 1 минут.

**Б.Пүрэвдорж:** Өөрөөр хэлбэл Үндсэн хуульд томилгоог Ерөнхийлөгч хийнэ л гээд заачихсан байгаа. Тэгэхээр та өөрөө яг тэр прокурорын байгууллага дээр очоод тодорхой прокуроруудыг цуглуулж байгаад энэ судалгааныхаа асуудлаар тодорхой ярилцлага хийсэн. Тэр ярилцлага болон бусад судалгааны материал чинь таныг бол ерөнхийдөө энэ чиглэл рүү явна гэсэн ийм л ойлголттой хүн гэж би дүгнээд байгаа юм л даа. Тэгээд ойлголтынхоо хүрээнд Цэц дээр очоод Цэцийн шийдвэр гаргахад та энэ дээр бол ямарваа нэгэн байдлаар ийм байдлаар асуудалд хандах ёс суртахуун бол байх ёсгүй шүү л гэдгийг би сануулж хэлээд байгаа юм. Энийг бол албан ёсоор Их Хурлын.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Үг хэллээ. Одоо санал хураалт явуулна. Гишүүд асуулт асууж, үг хэлж дууссан. Байнгын хорооны саналаар нууцаар санал хураана. Нууц санал хураалттай. Санал хураалт явуулъя.

Лувсандоржийн Өлзийсайханыг Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилох саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. 70,5 хувийн саналаар санал дэмжигдлээ. Дамдины Цогтбаатар гишүүний санал эсрэг гарсан бол эсрэг гарсан.

Одонхүүгийн Мөнхсайханыг Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилох саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 65,9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Эрдэнээгийн Энхтуяаг Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилох саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 70,5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилох саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул “Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилох, Үндсэн хуулийн цэцийн гишүүнийг

чөлөөлөх тухай” Улсын Их Хурлын тогтоол баталсанд тооцлоо. Тогтоолыг уншиж танилцуулъя.

12.25 цаг.

Дараагийн асуудал.

“Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилох, Үндсэн хуулийн цэцийн гишүүнээс чөлөөлөх тухай” Монгол Улсын Үндсэн хуулийн 65 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 4 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 102 дугаар зүйлийн 102.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь:

1.Монгол Улсын Их Хурлын санал болгосноор Лувсандоржийн Өлзийсайханыг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн санал болгосноор Эрдэнээгийн Энхтуяаг, Улсын дээд шүүхийн санал болгосноор Одонхүүгийн Мөнхсайханыг Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр тус тус томилсугай.

2.Бүрэн эрхийн хугацаа нь дуусгавар болсон тул Доржийн Одбаяр, Намжилын Чинбат нарыг Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнээс чөлөөлсүгэй.

3.Энэ тогтоолыг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр нэр дэвшиж, сонгогдож томилогдсон олонхын саналаар дэмжлэг авсан Үндсэн хуулийн цэцийн гишүүдэд Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс ажлын өндөр амжилт хүсэж, Үндсэн хууль, хууль дээдлэх, ёсыг чанд баримтлан, төвийг сахиж, хараат бусаар ажиллаж, Үндсэн хуулийг чанд мөрдүүлэх баталгаа байхыг хүсэн ерөөе.

**“Төрөөс мөнгөний бодлогын талаар 2024 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна.**

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Чинбатын Ундрам танилцуулна.

**Ч.Ундрам:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол банкнаас Төв банкны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсэгт заасны дагуу 2023 оны 9 дүгээр сарын 25-ны өдөр Улсын Их Хуралд ирүүлсэн “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2024 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурлын 2023 оны 10 дугаар сарын 5-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж, төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлсэн.

Эдийн засгийн байнгын хорооны 2023 оны 17 дугаар тогтоолоор “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2024 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундармаар ахлуулж Улсын Их Хурлын гишүүн Г.Амартүвшин, Б.Баттөмөр, Х.Ганхуяг, Т.Доржханд, С.Чинзориг нарын бүрэлдэхүүнтэйгээр байгуулан ажилласан.

Эдийн засгийн байнгын хороо 2023 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн

хуралдаанаараа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 66 дугаар зүйлд заасныг баримтлан дээрх тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явууллаа.

Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн Т.Доржханд Монгол банк мөнгөний бодлогын үндсэн чиглэлд тусгагдсан байр сууриа хадгалж, ирэх онд мөнгөний нийлүүлэлтийг нэмэгдүүлэхгүй байхад анхаарах талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр Мөнгөний бодлогыг төсвийн бодлоготой уялдуулах, инфляцыг тогтворжуулахад анхаарах талаар, Улсын Их Хурлын гишүүн Ч.Хүрэлбаатар Монголбанк ирэх онд Монгол Улсын эдийн засгийн дотоод болон гадаад орчны нөлөө харьцангуй нааштай байгааг ашиглах талаар, Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг банкнуудад байришиж байгаа Засгийн газрын тусгай сангууд болон төсвийн хөрөнгийн зарцуулалтад хяналт тавих талаар тус тус асуулт асууж, санал хэлсэн болно.

Ажлын хэсгийн зүгээс орон сууцны ипотекийн хөтөлбөрийн тасралтгүй байдлыг хангах, зээлийн эх үүсвэрийг нийслэл орон нутагт тэнцүү хуваарилах, эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууц барих, гэр хорооллыг барилгажуулах зорилгоор олгох зээлийг дэмжих, бизнесийн зээлийг нэмэгдүүлж, хэрэглээний зээлийн хэт өсөлтөөс сэргийлэх, банкнаас жижиг дунд бизнест олгосон зээлийг ангилах, ногоон тогтвортой зээл гаргахад санхүүгийн байгууллагуудтай хамтран ажиллах зэрэг зарчмын зөрүүтэй саналууд гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжлээ.

“Төрөөс мөнгөний бодлогын талаар 2024 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар Байнгын хорооны дэмжсэн зарчмын зөрүүтэй

саналын томъёоллыг та бүхэнд тараасан болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Төрөөс мөнгөний бодлогын талаар 2024 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж, зарчмын зөрүүтэй саналуудаар санал хурааж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Г.Занданшатар:** Одоо Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн санал, дүгнэлтийг Ардчилсан намын бүлгийн дарга, Улсын Их Хурлын гишүүн Одонгийн Цогтгэрэл танилцуулна. Индэрт урьж байна.

**О.Цогтгэрэл:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монголбанкнаас өргөн барьсан Төрийн мөнгөний бодлогын талаар 2024 онд баримтлах үндсэн чиглэлд Ардчилсан намын бүлгийн санал, дүгнэлтийг танилцуулъя.

Төв банкны тухай хуульд Монголбанкны үндсэн зорилт нь үндэсний мөнгөн тэмдэгт, төгрөгийн тогтвортой байдлыг хангахад оршино гэж заасан байдаг. Төгрөг тогтвортой байх гадаад шалтгаан нь валютын ханшаар, валютын тогтвортой ханшаар, дотоод шалтгаан нь инфляцаар илэрхийлэгддэг. Гэтэл 2016 оноос хойш Монгол төгрөг 80 хувь үнэгүйдээд байна. Энэ хугацаанд манай улсын экспортод гаргадаг түүхий эдийн хани асар өндөр байж, валютын орлого түүхэнд байгаагүйгээр нэмэгдсэн. 2015 онд Монгол Улсын экспортын нийт орлого 4,6 тэрбум гадаад худалдааны тэнцэл 879 сая ам.доллар байсан бол

2022 онд экспорт 12,5 тэрбум хүрч 3 дахин, тэнцэл нь 3,8 тэрбум ам.долларт хүрч 4 дахин өссөн.

Зөвхөн 2023 оны 9 сарын байдлаар гадаад худалдааны тэнцэл 4,5 тэрбум долларын ашигтай гарч байгаа. Энэ бүх тоо хийгээд чөлөөт зах зээлд мөрдөгддөг эрэлт нийлүүлэлтийн хуулиар гадаад валютын хани чангарах биш, сулрах ёстой. Гэвч өнөөдрийг хүртэл валютын хани тасралтгүй чангарч, эрх баригчид үүний учир шалтгааныг нь ковид руу заасаар ирсэн.

Үнэндээ бол төсөв мөнгөний бодлогын алдаа үндэсний мөнгөн тэмдэгтийн огцом сулралын шалтгаан болжээ гэж Ардчилсан намын бүлэг дүгнэж байна. Хэрэглээнийхээ ихэнхийг импортоор хангадаг манай улсын хувьд гадаад валютын хани чангарч байгаагаас өргөн хэрэглээний бараа үйлчилгээний үнэ өдөр ирэх тусам өссөөр байна. Цар тахал эхлэхэд 20 их наяд байсан мөнгөний нийлүүлэлт өнөөдөр 32,6 их наяд төгрөгт хүрч нэмэгджээ.

Гэтэл нөгөө талд нь Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүн ийм хэмжээнд өсөөгүй. Дотоодын нийт бүтээгдэхүүн өсөөгүй байхад асар их хэмжээний мөнгө зах зээлд нийлүүлэх нь эдийн засгийг хорлох бас буруу бодлого. Урхаг нь үнийн өсөлт, ханишийн сулрал зэрэгээр илэрч байна. Иймдээ ч инфляц сүүлийн 3 жил 2 оронтой тооноос буусангүй. Инфляцтай тэмцэх зорилгоор Монголбанк бодлогын хүүгээ жилийн дотор 6%-13% хүртэл өсгөсөн. Үүний үрд үр дүнд арилжааны банкны хүү 20 хувийн босго давж, бизнесийн зээлийн олдоц ирц багассан нь улсын төсвийн орлогыг бүрдүүлдэг хувийн хэвшлийнхэнд нэн хүндээр тусаж байна. Тэдэнд үнээ нэмэх эсвэл хаалгаа барих 2 сонголтоос аль нэгийг нь сонгох л зам үлдсэн.

Хани алдахад нөлөөлж буй бодлогын бас нэг алдаа бол хэт тэлсэн төсөв, эрдэс баялгийн дэлхийн зах зээл

дээрх үнэ ханишийн өсөлтийг дагуулан эрх баригчид төсвийн зарлагаа сүүлийн 4 жилд 2 дахин, сүүлийн 2 жилийн дотор гэхэд 65 хувиар төсвийн хэмжээ тэллээ. Ердөө 7 жилийн өмнө Монгол Улсын төсвийн нийт зардал 5-6 их наядад хэлбэлзэж байсан бол өнөөдөр 4-5 дахин нэмэгдчихлээ. Тэлсэн төсвийн ихэнх хэсэг импортын бараа үйлчилгээ болон бараа, үйлчилгээ, валют болон гадагшаа урсаж байна. Энэ урсгалд валютын хани, инфляцыг хөөрөгдөж Монголын эдийн засгийг чөтгөрийн тойрог руу чирч байна.

Ойрын жилүүдэд төрийн албан хаагчдын цалин болон тэтгэврийн хэмжээг ойр ойрхон хэдэн удаа нэмсэн ч үнийн өсөлтийн хурдаа гүйцэхгүй, тэдний амьдралд огт наалдахгүй байгаа нь үүнийг тод томруунаар харуулсаар. Инфляц гэдэг бол дундаж давхаргаа шахаж, тэтгэврийн ахмад ядуу иргэдийнхээ амьдралыг тэсэхийн аргагүй болгодог тийм үл үзэгдэгч татвар.

Тэлсэн төсөв чангарсан мөнгөний бодлого Монголын мянга мянган бизнесийнхний орон зайг улам бүр хавчиж, бизнесүүд өсөлт, ирээдүй, экспортын тухай биш, өр зээл татвар цалингаа хэрхэн тавих вэ, амьд үлдэх сорилтод өдөр бүр орж байна. Өссөн татвар үнэгүйдсэн төгрөгийн ханинд цөхөрсөн иргэд Монголоос дайжихын хүслэн болж хэдэн зуугаараа залуучууд ар гэрээ тэжээх даалгавар өвөртөлөн харь орон руу урссаар байна. Мөнгөний бодлогын 2 дахь гол зорилт нь санхүүгийн зах зээл мөнгөний тогтвортой тогтолцооны байдлыг хангах замаар эдийн засгийн хөгжилд дэмжлэг үзүүлэх явдал.

Монголбанкны үйл ажиллагааны үндсэн чиглэл болох арилжааны банкны үйл ажиллагаанд хяналт тавих функц туйлын хангалтгүй ажиллаж ирснээр өнгөрсөн хугацаанд зарим арилжааны банкнууд дампуурсан. Энэ бүрт төрийн тэр тусмаа Эрүүл мэндийн даатгал,

нийгмийн даатгалын асар их мөнгө алдагдсаныг бас бид мэднэ. Дамтуурсан эсвэл ийм эрсдэлтэй банкнуудад нийгмийн даатгалын сангийн асар их мөнгө байгаа нь манай улсын санхүүгийн салбар төсвийг захиран зарцуулагч нартай нягт холбоо сүлбээтэй байгааг харуулдаг. Монголбанкны хяналт сул төсвийн хөрөнгийг захиран зарцуулагчдын эргэлзээ бүхий орлого банкны салбарт өндөр байгаа нь санхүүгийн салбарын тогтвортой үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж эхэлсэнд цаг алдалгүй арга хэмжээ авах бас шаардлага бий.

Уул уурхайн экспортын голлох бүтээгдэхүүнүүдийн үнэ хани дэлхийн зах зээл дээр хэд дахин нэмэгдсэн. Нүүрс 2012-2016 онуудтай харьцуулахад 10-аас бараг 20 дахин нэмэгджээ. Зэсийн үнэ 5 мянган ам.доллар биш 10 мянган ам.долларт хүрсэн. Экспортын бусад түүхий эдийн хувьд мөн өндөр үнэтэй он жилүүд байлаа. Үүлэн чөлөөний нар мэт ийм ховорхон тохиох боломж зах зээлийн нийгэмд шилжсэн 30 гаруй жилийн түүхэнд бид нарт бас тохиож байгаагүй. Гадаад худалдааны тэнцэл 4 тэрбум ам.доллараас илүү ашигтай гарсаар байхад үндэсний валютын хани огцом суларсан нь санхүүгийн салбар хорт хавдартай, өвчтэй байгаагийн шинж. Гол шалтгааныг ч Олон улсын валютын сан илтгэлдээ дурдсан. Энэ бол нүүрсний оффтейк гэрээ. Хэдэн тэрбум ам.доллараар яригдах ийнхүү нууц гэрээнүүд ийм их хэмжээний валют, эдийн засаг, санхүүгийн салбарт оролгүй гадуур эргэлдэх нь үндэсний ААН-үүдийн үйл ажиллагаа болон иргэдийн амьдралд шууд сөргөөр нөлөөлж, хямралын гол шалтгаануудын нэг болсныг бас эрх баригчдад бас анхааруулан хэлье.

Олон улсын валютын сангийн Монгол дахь суурин төлөөлөгч ирэх жилүүдэд дэлхийн эдийн засагт олон сорилт тулгарна. Хамгийн гол нь бодлогын алдаануудаас болж хүндрэл гардаг. Энэ нь дэлхийд ч, Монголд ч

хамаатай. Тиймээс улс орнууд бодлогын алдаа гаргахгүй ажиллах нь чухал. Монголын хувьд 2024 оны гол бэрхшээл бол инфляц. Ирэх оны төсөвт цалин тэтгэвэр нэмнэ гэж тооцож байгаа ч инфляцад өндөр дарамт учруулна. Өндөр инфляц Монголчуудын цалин тэтгэврийг идэж байна. Монгол банк инфляцыг 1 оронтой тоонд барих бодлого барьж байгаа ч урт хугацаанд өндөр инфляцын дарамт үргэлжлэхээр байна. Монголын Засгийн газрын өр инфляц өндөр байгаа нь ирэх жилүүдийн гол бэрхшээл болно гэж Олон улсын валютын сан анхааруулан дүгнэжээ.

Өнгөрсөн жилүүдэд Монголбанкны бие даасан байдал бүрэн алдагдаж, Засгийн газрын дохио зангаагаар ажилладаг, бэлэн мөнгөний касс мэт болж хувирсан. Засгийн газар болон төв банкны хоорондох төсөв, мөнгөний бодлогын уялдаа алдагдаж, тэнцвэртэй нэгдсэн зохицуулалт дутагдаж байгаа нь үнэ өсөх, Монгол төгрөгийн хани сулрах, нийгэмд ядуурал нэмэгдэх, аж ахуйн нэгжүүд олноор хаалгаа барих гол шалтгаан болсоор ирлээ. Иймээс Монголбанк үйл ажиллагааныхаа арга барилыг бас эрс өөрчилж төрийн хариуцлагын механизмыг нэн даруй сэргээж, Засгийн газраас хараат бусаар ажиллах шаардлага нэн хурцаар тавигдаж байгааг бас дахин сануулъя. Анхаарал тавьсанд баярлалаа.

**Г.Занданшатар:** Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу. Пүрэвдорж гишүүнээр тасалъя. Цэвэгдоржийн Туваан гишүүн асуулт асууна.

**Ц.Туваан:** Улсын Их Хурал дээр жил болгон мөнгөний бодлого батлагдаад явдаг. Тэгэхээр 2024 оны мөнгөний бодлого бас орж ирж байна. Тэгээд мөнгөний бодлого чинь Монгол Улсын нийт ард иргэдэд яг ямар эерэг өөрчлөлт, үр дүн авчрах вэ гэдэг

асуултыг Монгол банкны ерөнхийлөгчөөс асууя. Монголбанк дээр одоо ипотекийн зээлийн хөтөлбөрийг хэрэгжүүлээд явж байгаа. Энэ нь бол зөв гэж харж байгаа. Яагаад гэхээр аль нэг яам руу яваад тэнд шинэ мэдэхгүй хүмүүс яваад, энд юу болох вэ. Тэгэхээр ипотек дээр нэмэлт эх үүсвэр байгаа юм уу. Эсвэл зээлийн эргэн төлөлтөөсөө ингээд энэ асуудал чинь явах юм уу. Ер нь бол эх үүсвэр дутагдаад байгаа гэдэг нь бол тодорхой байгаа. Тэгэхээр энэ дээр мөнгөний бодлогод энэ чинь ордог юм уу, ордоггүй юм уу. Ипотекийн зээл авах гэдэг бол ер нь хуучнаар бол ер нь арын хаалга болчихлоо шүү дээ. Олдохгүй. Орьё гээд, авъя гээд ипотекийн зээлд хамрагдъя гээд маш хүнд болчихлоо. Энэ бодлого яагаад энэ дээр гацаад байгаа тал дээр нэг хариулт авъя.

Монголбанкны онилж явах ёстой 1 гол зүйл бол инфляц. Инфляц чинь та хэд мэдэхгүй статистикийн хүмүүс яаж гаргаад байдаг юм мэдэхгүй. Юмны үнэ нь даблдаад өсөөд байдаг. Инфляц чинь нэг оронтой тоо руу бараг хариугүй орчих гээд байгаа юм л яриад байх юм. Яагаад ийм зөрүүтэй байгаа юм. Инфляцыг боддог юм чинь ерөөсөө тэр хэдэн хүнсний бүтээгдэхүүний чинь үнэ шүү дээ. Мах, гурил, сүү, ногоо тэгээд эд нар чинь үнэ нь 12 мянгаас доош үнэтэй мах байгаа юм уу. Гурилын үнэ яг даблдаад нэмэгдчихсэн байгаа. Тэгээд энэ дээр яаж инфляц чинь 1 хувь руу дөхчхөөд байгаа юм. Энийг нэг тодорхой хариулж өгөөч.

2 дугаарт тэр инфляцыг барихын тулд та хэд Монголбанк Монгол Улсын мөнгийг барьж байгаа газар байна. Ямар төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх гэж байна. Инфляцыг онилсон. Одоо энэ дээр хүнсний хангамж гээд л Улсын Их Хурал дээр 1 тогтоол батлагдаад л явсан. Тэгээд тэр үед би маш олон удаа хэлсэн. Энэ мөнгийг чинь яг энэ төсөл рүү гарах мөнгийг гаргаж өгөх гол банк, гол газар Монголбанк чинь тоглолтод орохгүй байна шүү дээ. Тэгээд орсон уу. Энэ дээр

яг ямар арилжааны банкнуудтайгаа яаж бодитой хамтарч ажиллаж байгаа вэ гээд.

Хөдөө орон нутгаас иргэд ярьж байна. Ер нь юм нэг л болохоо больчихлоо шүү. Юм хийгээд мөнгө нь ирэхээ байлаа. Юм худалдаж авдаг бараа бүтээгдэхүүн, мах нядлаад ч гэсэн авдаг хүнгүй боллоо гээд. Энэ чинь танай энэ явуулаад байгаа хатуу мөнгөний бодлоготой чинь хамааралтай л байгаа шүү дээ. 13 хувь дээр авааччихсан. Нэг хэсэг махаа идэж байж зээлийн хүүг, тэтгэврийн зээл, малчны зээл, бизнесийн зээлүүдийн хүүг овоо доошоо оруулж ирсэн. Одоо буцаагаад тавиад туучихсан. Маш өндөр зээлийн хүү рүү ороод ирчихсэн. Тэгээд энэ чинь ямар бодлого юм бэ. Ковидын үе гээд тэр нэг ийм ярьдаг үе чинь бол өнгөрчихсөн. Монгол Улсад одоогоор дайн байлдаан алга. Мөнгөнийхөө бодлогын хүүгээ жоохон багасгаад, зээлээ чөлөөлөөд ААН-үүд рүү мөнгөний урсгалаа урсгах бодлого чинь явахгүй юм уу. Одоо бүх банкнууд ч зээл гаргах ямар ч сонирхол алга. Бодлогын хүү ийм өндөр байхад. Тэгээд зээлгүй компаниуд чинь ямар ч үйл ажиллагаа явуулж чадахгүй байна. Тэгээд үйл ажиллагаа явуулж чадахгүй байгаа хувийн хэвшлийнхэн яаж нийгмийн даатгал, татвар, ашиг олж авах юм. Энэ дээр ямар бодлого байгаа юм гэсэн асуултаудад тодорхой хариулт авъя.

**Г.Занданшатар:** Ажлын хэсгийг эхлээд танилцуулчихъя. Бядрангийн Лхагвасүрэн Монголбанкны Ерөнхийлөгч, Дэмбэрэлдашийн Баярсайхан Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Монголбанкны Дэд ерөнхийлөгч Ганболдын Энхтайван, Монголбанкны ерөнхий эдийн засагч Доожавын Ган-Очир, Монголбанкны Мөнгөний бодлогын газрын захирал Баярсайханы Баярдаваа, Монголбанкны Бүтцийн өөрчлөлт бодлогын газрын Эрсдэлийн үнэлгээний хэлтсийн захирал Готовсүрэнгийн Борхүү, Монголбанкны Нөөцийн удирдлага санхүүгийн зах зээлийн газрын захирал Атарбаатарын

Энхжисн, Монголбанкны хэвлэлийн төлөөлөгч Дагвадоржийн Ариунаа. Бядрангийн Лхагвасүрэн 83 хариулъя.

**Б.Лхагвасүрэн:** Туваан гишүүний асуултад хариулъя. Тэгээд 2024 оны мөнгөний бодлогын үндсэн чиглэл 3 бүлэг ийм заалтуудтай байгаа. Эхлээд макро эдийн засгийг тогтворжуулах, дараа нь санхүүгийн салбарын тогтвортой байдлыг, 3 дахь бүлэг заалт нь бол санхүүгийн салбар дахь дэд бүтцийг илүү их төгөлдөржүүлж, хөгжүүлэх гээд. Тэгээд ямар өөдрөг үр дүн гарахаар заалтууд энэ 2024 оны мөнгөний бодлогод орсон бэ гэхээр 1 дүгээрт би инфляцынхаа зорилтыг хэлэх гэсэн юм. 2023 оны инфляцын зорилт бол инфляцыг 1 оронтой тоонд оруулах гэдэг ерөнхий заалттай мөнгөний бодлого байсан.

2024 онд бол бид эргээд нөгөө нарийвчилсан, яг зорилтот тоотой инфляцыг онилсон энэ бодлогоо эргээд үргэлжлүүлэх гэж байгаа. Тэр утгаараа 2024 онд инфляцыг 6 хувийн голчтой +2 гэсэн энэ зорилт руу мөнгөний бодлогоо чиглүүлж ажиллана. Тэгэхээр өнөөдөр дэлхийн бусад улсуудад байдаг яг л тэр мөнгөний бодлогын зорилтыг тавиад, тэрнийгээ зорьсон, аль болохоор тэр инфляцыг тэр 6 голчтой тоо руу богино хугацаанд аваачих ийм мөнгөний бодлого явуулна. Тэр утгаараа ерөнхийдөө зорилт руугаа ортлоо бол ерөнхийдөө мөнгөний хатуу бодлого бол үргэлжлээд явна гэсэн ийм зорилготой явж байгаа.

Мөн ялангуяа гадаад төлбөр тооцоог бол илүү их гадаад худалдааг хөнгөвчлөх үүднээсээ гадагшаа Монгол Улсын экспортыг дэмжих төлбөр тооцооны ийм шинэ механизмыг нэвтрүүлэх зорилтыг бас тавьсан байгаа.

Өөр нэг зүйл нь бол илүү их ногоон эдийн засагтай, ногоон бизнес рүү чиглэсэн ногоон зээлийг түлхүү гаргах ийм зорилтууд бас тусгагдсан. Мөн банкны секторт өнөөдөр 12 арилжааны

банк байгаа бол илүү гаднын банкны оролцоог өрсөлдөөнийг нэмэгдүүлэх үүднээс гадаадын банк санхүүгийн салбарыг 2024 онд багтааж оруулж ирэхээр бас ийм зорилго тавиад явж байгаа. Тэгэхээр эдийн засагт эерэг нөлөө үзүүлэхээр ийм томоохон зорилтууд бол 2024 оны мөнгөний бодлого дотор туссан явж байгаа.

2 дахь асуултын хувьд бол ипотекийн зээлийг уг нь энэ ондоо багтаад Засгийн газартаа шилжүүлэх байсан. Хэдийгээр Засгийн газар шилжүүлэх ийм зорилготой байсан боловч яг Засгийн газар дээр хүлээж авах тэр тодорхой агентлаг юм уу, байгууллага байхгүй байгаа учраас өнөөдөр Монголбанк бол энийг үргэлжлүүлээд явж байна. Тэгэхдээ бол шинээр мөнгө гаргахгүй байгаа. Одоо энэ онд төлөгдөж байгаа эх үүсвэрийг нь л эргээд гаргаад явж байгаа. Тэгэхээр ерөнхийдөө дунджаар бол зээлийн эргэн төлөлтөөрөө сардаа 35-45 тэрбум төгрөг төгрөгийн эх үүсвэр эргэж орж ирдэг. Энэ эх үүсвэрийг нь буцаад гаргаад явж байгаа энэ утгаараа бол жилдээ 500-аад тэрбум төгрөгийн л ийм эх үүсвэр зах зээл рүү санхүүжилт маягаар ороод явж байгаа.

Өмнөх жилүүдийн дундаж бол ерөнхийдөө 700-аад тэрбум төгрөг байсан бол одоо тэр дунджаасаа арай бага байгаа учраас бол нэлээн тийм очер гэдэг юм уу, дараалал үүсэж байгаа зүйл байгаа. Бидний өнөөдөр авсан судалгаагаар бол орон нутагт ипотекийн зээлд хамрагдах гэж байгаа хүний шийдвэр нь гарснаас хойш 1 сарын дараа зээл нь гарах маягаар явж байна. Улаанбаатар хотод бол зарим банкнууд дээр бараг 10 сар хүртэл очер дугаар үүссэн ийм зүйл байгаа. Тэгэхдээ нэгэнт инфляц ийм өндөр байгаа үед Монголбанкны зүгээс бол мөнгө нийлүүлж, шинэ эх үүсвэрийг зах зээл рүү гаргах ийм боломжгүй учраас бид нар эргэн төлөлтийнх нь хэмжээгээр л гаргаад явж байгаа.



Инфляцыг бол Монголбанк өөрөө онилчихоод өөрөө тооцох нь бол бас ийм сонирхлын зөрчил үүсэх гэдэг үүднээсээ олон улсад бол инфляцыг тооцдог аргачлалаар бол Монголбанкнаас тусдаа байхаар Үндэсний статистикийн хороо аргачлалынхаа дагуу тооцоод явдаг. Тэр утгаараа Монголбанк бол инфляцыг тэд байна, ийм байх ёстой гэдэг ийм тооцоололд нь ерөөсөө ордоггүй. Өнөөдөр Үндэсний статистикийн хороогоор инфляцыг тооцож байгаа аргачлал бол Монгол Улсын иргэд, ААН нийт бараа үйлчилгээний 410.../минут дуусав/

**Г.Занданшатар:** 83. Бядрангийн Лхагвасүрэн гүйцээж хариулъя.

**Б.Лхагвасүрэн:** 410 нэр төрлийн бараа бүтээгдэхүүний дундаж үнийг гэдгээ авч явж байгаа. Мэдээж хүнсний бүтээгдэхүүн дээр инфляц бол өндөр байгаа. Би бас түрүүн бас хэлсэн. Төсөл хөтөлбөрийн хувьд бол Монголбанк өөрөө инфляцыг онилоод, хатуу бодлого явуулж байгаа үед бол төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх маягаар мөнгө нийлүүлэхгүй байгаа. Өнөөдөр хүнсний хувьсгал буюу хүнсний аюулгүй байдлын хүрээнд хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрүүд бол арилжааны банк дээр байгаа өөрийн эх үүсвэрээр нь чөлөөтэй эх үүсвэрээр нь энэ хөтөлбөр өөрөө явж байгаа. Тодорхой хэмжээний хүүгийн хөнгөлөлт татаасыг бол үзүүлээд явж байгаа учраас бол зээл бол гараад явж байгаа.

Ерөнхийдөө зөвхөн орон нутаг ч гэлгүйгээр Монгол Улсын хэмжээгээр бол нэгэнт мөнгөний хатуу бодлого явж байгаа гэдэг утгаараа ер нь зээл санхүүжилтийн олдоц бол нэлээн мэдээж хомсдолтой байгаа гэж хэлж болно. Ер нь бол Монголбанк бол зээлээ өөрийнхөө зорилтот түвшиндээ орж иртэл нь бол хатуу бодлого үргэлжлүүлэхээс өөр сонголтгүй л байгаа гэж хэлнэ. Тэгээд энэ бол зөвхөн Монгол Улсад ч биш энэ цаг үед бол

дэлхий нийтээрээ инфляцтай тэмцэж байгаа гэдэг утгаараа дэлхийн бүх төв банкнууд нэлээн хүүгээ өсгөсөн мөнгөний хатуу бодлого явуулж байгаа юм. Тэрэндээ ер нь бол ойролцоо л ийм бодлого хэрэгжиж байгаа юм.

**Г.Занданшатар:** Туваан гишүүн тодруулъя.

**Ц.Туваан:** Мөнгөний бодлого чинь яг хэд байх юм бэ. 2024 он дээр энийг нэг тодорхой хариулаадхаач. Хэзээ сулруулж эхлэх юм бэ. Энэ төсвөө та хэд сая харсан уу. Төсвийн орлого бүрдүүлэлт дээр ААН-үүдээс тэр татвар, дээрээс нь нийгмийн даатгалын өр, татварын өр эд нарыг маш их хэмжээгээр дайчлах төсөв батлагдсан шүү дээ. Тэгээд энэ ААН-үүд чинь зээл хийж, бизнес явуулахгүйгээр яаж энэ төсвийн мөнгийг бүрдүүлэх юм бэ. Энэ дээр нэг тодорхой хариулт өгөөдхөөч.

Дээрээс нь инфляц гээд хүнсний бүтээгдэхүүний инфляц гэж байхгүй шүү дээ. Инфляц нэг л инфляц байгаа. Тэгээд 1, 2, 3-д орох зүйлүүдийг нь Их Хурлаас бид нар хууль хүртэл батлаад л 500 гаруй тэрбум төгрөг гаргаад л явуулсан. Тэгээд ямар нэгэн энэ чинь Монголбанк шүү дээ. Монголд мөнгөний бодлого явуулж байгаа. Бид нар тусгаар улс. Тэгээд энэ рүүгээ чиглэсэн бодлого явуулахгүй ингээд хуруугаа хумьчаад, гараа хумьчаад суугаад явах энэ бодлого чинь ер нь зөв юм уу. Тэрийгээ.../минут дуусав/

**Г.Занданшатар:** 83. Лхагвасүрэн Ерөнхийлөгч хариулъя.

**Б.Лхагвасүрэн:** Туваан гишүүний асуулт тодотгож хариулъя. 2024 оны төсөв бол ерөнхийдөө 20 хуваир тэлээд орж ирж байгаа. 5 их наядаар нэмэгдэж байгаа ийм том төсөв байгаа. Тэгэхээр нэгэнт эдийн засаг руу төсвөөр дамжиж орох мөнгө санхүүжилтийн хэмжээ нь ийм том байгаа учраас төв банкны зүгээс бодит сектор эдийн засаг руу өөр мөнгө нийлүүлэх боломж нь бол ерөөсөө

байхгүй. Яагаад гэвэл инфляц өөрөө зорилтот Монголбанкны зорьж байгаа тэр түвшин рүү орж ирэхгүй байгаа учраас. Тэр утгаараа бол Төв банк бол ямар нэг төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлнэ гэдгээрээ мөнгө гаргах бол ямар ч боломж бололцоо байхгүй.

Инфляц сая 10 сарын эцэст 9 хувьтай гарсан. 9 хувьтай гарсан энэ 9 хувийн бараг 50 хувь нь 20 гаруй нэр төрлийн бараа бүтээгдэхүүн байгаа юм. Тэр дотор нэлээн том жин эзэлж байгаа нь бол ерөнхийдөө 3 бараа байгаа. Мах, гурил, сүү гээд. Мах, гурилын хувьд бол Монгол Улс өөрийгөө бол 100 хувиар хангах ийм боломжтой бүтээгдэхүүн. Сүү бол яах вэ зуны улирлын шинжтэй ийм зүйл байгаа. Тэгээд.../минут дуусав/

**Г.Занданишатар:** Монгол банкны ерөнхийлөгч гүйцээгээд хариулъя. 83.

**Б.Лхагвасүрэн:** Өнөөдөр бодлогын хүү 13 хувьтай байгаа. Инфляц 9 хувьтай байна. Монголбанкны зорьж байгаа зорилт бол 6-8 хувь руу коридор луу л оруулах л ийм зорилго барьж байгаа учраас бодлогын хүү хэрвээ инфляц 6-8 хувийн хэмжээнд орж ирэх юм бол бодлогын хүүг бол зөөлрүүлэх ийм боломж тэр үед л үүснэ.

**Г.Занданишатар:** Энхбаярын Батиугар гишүүн асуулт асууя.

**Э.Батиугар:** Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Ипотекийн зээл 8 хувиас 6 хувь руу болох энэ асуудал дээр бол Монголбанк нэлээн идэвхтэй, санаачилгатай ажилламаар байна. Би Монголбанкны дэд ерөнхийлөгч 2013 онд хийж байхдаа 21 мянган иргэдийг 24 хувийн хүүг нь 8 хувь руу буулгаж болгосон. Тэгээд эцсийн үр дүндээ ард түмэн л хожиж байгаа юм. Монголбанк яах вэ, Монголбанкны алдагдал бол бодлогын алдагдал шүү дээ. Ашигийн бус байгууллага гэдгийг бид нар бас ойлгох ёстой. Энэ утгаараа түрүүчийн удаа би хэлэлцэх эсэх дээр нь асууж байхад бол

400 тэрбум шаардлагатай гэж ярьж байсан. Тэгээд энийгээ нэг санаачилгатай, зоригтой хийгээд тэгээд ард түмнийхээ ачааг нь цуг үүрмээр байна.

2-т нь, нийт зээлийн багцын дийлэнх нь дандаа хэрэглээний зээлүүд байгаад байна. Бизнесийн зээл ерөөсөө гарахгүй байна. Бизнесийн зээл чинь уг нь эдийн засгийн эргэлтэд оруулна. Ажлын байр бий болгоно. Хөрөнгө оруулалт авчирна, эдийн засгаа тэлнэ. Энэ дээр ямар арга хэмжээ авах вэ. Ямар байдлаар хэрэглээний зээлээс шилжээд бизнесийн зээл рүү оруулах вэ гэсэн асуулт асууя.

3 дахь нь манай төлбөрийн тэнцэл 790 сая доллар ашигтай гарлаа. Худалдааны тэнцэл 4,9 тэрбум доллар ашигтай гарлаа. Гэхдээ энэ нь бодит эдийн засагтаа ирэхгүй байна. Яагаад гэвэл дийлэнх уул уурхайн компаниуд Монгол банканд шууд доллароо тушаагаад, оронд нь төгрөг аваад байгаа юм. Зах зээл дээр долларын хомсдол үүссэн байгаад байгаа юм. Тэгэхээр үе шаттайгаар эргээд, буцаад нөгөө банкнууд руугаа шилжүүлэхгүй юм уу энэ тогтолцоогоо. Мэдээж Монголбанк чинь Хяналт шалтгаан газар гэж байгаа. Үүн дээрээ тулгуурлаад хэрвээ ямар нэгэн банк нь зах зээлийн ханишийн манипуляц хийгээд ашиг олох гээд байгаа бол тэрийг нь зогсоочих бололцоотой шүү дээ. Тэгэхээр энэ дээр ажилламаар байна.

Дэлхийн бүх төв банкнууд форвард гайдэнс гэж ярьдаг. Тэгэхээр нөгөө өөрсдийнхөө бодлогоо ард түмэн сурталчилж, дээрээс нь нэмээд хүлээлт үүсгээд, үүний үр дүнд нь төв банкны нэр хүнд болон бодлогын шийдвэр нь илүү нөлөөтэй байдаг. Тэгэхээр энэ дээр ямар байдлаар, ямар арга хэмжээ авах вэ ирэх жил.

Хамгийн сүүлийн асуудал нь мэдээж бид нар бодлогын шинэ

хэрэгслүүд та бүхэн бодсон уу. 2012 онд хүйн коридор нээсэн. Үүнээс хойш ямар нэгэн шинэ бодлогын хэрэгсэл байхгүй л байна л даа. Тэгэхээр энэ дээр бусад төв банкуудыг судалж байгаад бас нэг өөр өөр бодлогын хэрэгслүүдээ нэвтрүүлбэл бас зүгээр ч юм уу гэж бодох юм. Ялангуяа Монгол шиг жижигхэн эдийн засагтай улс оронд бол. За баярлалаа.

**Г.Занданшатар:** Бядрангийн Лхагвасүрэн Монголбанкны ерөнхийлөгч хариулъя.

**Б.Лхагвасүрэн:** Батшугар гишүүний асуултад хариулъя. Тэгээд ипотекийн зээл 8 хувьтай байж байгаад 2020 оны 10 сарын 1-нээс 6 хувийн шинэ хөтөлбөр лүү шилжсэн. Энэ хооронд бол хүүгийн зөрүү гарсан байгаа. Ерөнхийдөө 8-6 хувь болгож, 8 хувийн зээл авчихсан иргэдийн зээлийг 6 хувь руу болж шилжүүлэхэд, тэр хүүгийн зөрүүг бол мэдээж хэн нэгэн даах ёстой. Та сая бол Монголбанк ашигийн төлөө биш гэлээ. Тэгэхээр угаасаа Монгол банк өөрөө нөгөө хуультай. Хуулийнхаа дагуу л ажиллана. Тэгэхлээр Монголбанк дээр үүссэн тэр алдагдлыг ямар нэгэн юмаар нөхөхөөр тэр хууль дотор нь бас заалт байгаа. Тэгэхлээр Засгийн газрын бонд хэлбэрээр нөхнө гээд бас заачихсан учраас энэ дээр бол тодорхой хэмжээний Улсын Их Хурал ч юм уу шийдвэр бол гарах ёстой юм байгаа юм. Тэгэхээр нэгэнт л хуультай учраас Монголбанк бол тэр хуулийнхаа дагуу тэрүүгээр явж энийг даах хуулийн зүйл байхгүй учраас Улсын Их Хурлаас юм уу тодорхой хэмжээний шийдвэр гарах юм бол 8-6 хувь болгох энэ хоорондын зөрүүг нөхөхөд бол ерөнхийдөө 450-аад тэрбум төгрөг 450-500-аад тэрбум төгрөгийн ийм алдагдал, зардал гарах л ийм тооцоог хийсэн байгаа.

Өнөөдөр ерөнхийдөө банкны нийт зээлийн хэмжээ 25 их наяд хүрсэн. Ерөнхийдөө зээл бол сүүлийн жилийн хугацаанд 10 хувиар өссөн. 11 хувиар. Тэр 11 хувиар өссөний 1 хувийн өсөлт нь бол

бизнесийн зээл. 10 хувийн өсөлт нь бол хэрэглээний зээл байгаа. Тэгээд яг таны хэлж байгаагаар бол өнөөдөр банкны салбараас гарч байгаа зээлийн дийлэнх хувь нь хэрэглээний зээл болчихоод байгаа. Тэгэхлээр Монголбанкны зүгээс бол ерөнхийдөө бизнесийн зээл гарах талаас нь анх л хандлага гарахаас нь эхлүүлээд бодлогын арга хэмжээнүүдээ аваад явж байгаа. Хамгийн том авч байгаа арга хэмжээ бол хэрэглээний зээлийн нийт урт хугацааг нь бол богиносгосон. Одоо 30 сараас дээш хугацаатай хэрэглээний зээл гаргаж болохгүй. Мөн өр орлогын харьцаа байгаа. Өр орлогын харьцаа гэдэг маань хэрэглээний зээл, цалин барьцаалсан ч юм уу зээл авах гэж байгаа хүний орлогын 70 хувиас нь бол хэтрүүлэхгүй байхаар зээлийн төлөлтөөр хийгээд, дэлхийд бол 70/30 гэдэг харьцаа байдаг бол Монголбанк энийг чангаруулаад 40/60 гэж харьцаа тогтоод чангаруулаад явж байгаа. Хэдий чангаруулаад явж байгаа ч гэсэн ерөнхийдөө хэрэглээний зээлийн гаралт бол өнөөдөр бол өндөр байгаад байгаа юм.

Бизнесийн хувьд бол ерөнхийдөө нөгөө бодлогын хүү өндөр болчихсон зээлийн дундаж хүү өндөр байгаа учраас бас яг о өндөр хүүтэй зээл авах сонирхохгүй бизнес нь бол банкнаасаа зээлээ авахгүй, сонирхож байгаа нь бол хэчнээн эрсдэлтэй ч гэсэн энэ зээлээ аваад явж байгаа учраас бол бизнесийн зээл дээр бол өсөлт бол байхгүй байгаа ийм л өнөөдөр статистик байгаа.

Төлбөрийн тэнцэл энэ онд бол ашигтай гарсан. Өнгөрсөн онд бол бас багахан хэмжээний ашигтай гарсан. Тэрнээс өмнө бол Монгол Улс зах зээлд орсноос хойш төлбөрийн тэнцэл бол ер нь ашигтай гарч байсан 30 жилд бол 3-4 жилд нь л ашигтай байгаа гэж байсан. Тэгэхээр одоо бол ерөнхийдөө нөгөө ковидын дараах хилийн хаалт байхгүй болоод дээр нь экспортын бараа бүтээгдэхүүний үнэ сайн байгаа учраас бол төлбөрийн тэнцэл ашигтай явж

байгаа. Бидний хувьд бол яах вэ, энэ ашигтай байгаа байдлыг бас яг л цөөхөн хэдэн бүтээгдэхүүнээс хамаараад байгаа учраас бол энийг бол байнгын ийм байна гэж харахгүй байгаа. Нэлээн эмзэг л гэдэг байдлаасаа харж байгаа. Тийм учраас 2024 онд бол бас экспортын бараа бүтээгдэхүүний үнэ ханиш яаж хөдлөх вэ гэдгээс бол бүх юм бас хамаарахаар байгаа.

Мэдээж төлбөрийн тэнцэл ашигтай гарсан учраас бол Монголбанкны валютын нөөц бол нэмэгдэж байгаа. Өнөөдрийн байдлаар 3,9 тэрбум доллартой тэнцэж байна. Түрүүчийн ерөөсөө 3, 4-хөн 7 хоногийн өмнө бол Монгол Улсын Засгийн газар Хөгжлийн банкны өрийг төлж дуусгасан. 350 сая доллар 1 доор гарсан. Нийтдээ 600 сая долларын өр бол төлөгдөж дууссан байгаа. Ингэхэд бол валютын нөөц бол 350 сая долларын 1 удаагийн төлөлт дээр бол ямар нэг өөрчлөлт савлагаа байхгүй байна гэдэг маань ерөнхийдөө төлбөрийн тэнцлийн ашигтай байгаа байдал нь ингэж сайнаар нөлөөлж байна л гэж байгаа юм.

Хүлээлтийг удирдах тал дээр бол.../минут дуусав/

**Г.Занданшатар:** 13 цаг болсон учраас чуулган түр завсарлалаа. 14 цагаас үргэлжилнэ.

ЗАВСАРЛАГА.

**Л.Мөнхбаатар:** Улсын Их Хурлын чуулганы өнөөдрийн үдээс хойших хуралдаан эхэлснийг мэдэгдье. Одоо байнгын хорооны дарга Баагаагийн Баттөмөр асуултаа асууя.

**Б.Баттөмөр:** Мөнгөний бодлого батлагдах нь ээ. Төсвийн төслөө бид нар батлаад хэрэгжүүлэхэд бэлэн болгоод явж байгаа. 2024 оны мөнгөний бодлого болон төсвийн бодлого хэд хэдэн эрсдэлүүд байгаа. Хамгийн том эрсдэл

бол юу гэхээр мөнгөний бодлого төсвийн бодлоготойгоо нийцэхгүй байгаа.

Миний ойлгож байгаагаар мөнгөний бодлого маань төсвийн хүрээний мэдэгдэлд тулгуурлаж боловсрогдсон. Гэтэл төсөв маань орж ирэхдээ 4,3 их наяд төгрөгөөр төсвийн хүрээний мэдэгдлээсээ давж орж ирсэн. Энэ бол том эрсдэл болно гэдгийг би хэлэхийг хүсэж байна. Энэ бол дотоод эрсдэл. Гадна талдаа бол мэдээж Монголын түүхий эд гардаг урд хөршийн эдийн засагтай холбоотой бас эрсдэлүүд үүсэж болзошгүй. Энд юу гэхээр эдийн засгийн өсөлт нь саарч байгаа гэж байгаа. Үл хөдлөх хөрөнгийн болон үйлдвэрийн салбарын өсөлт удааширч байгаа гэж байгаа. Тэгэхээр манай экспортын уул уурхайн бүтээгдэхүүний тоо хэмжээ буурах, үнэ буурах ийм эрсдэл үүсэж болзошгүй гэж тооцож байгаа.

Төсвийн зардлын тэлэлтээс үүдэлтэйгээр урсгал тэнцлийн алдагдал нэмэгдэж болзошгүй ийм нөхцөл байдал бас бий болж байгаа. Хөрөнгийн дотогшилох урсгал бас нэмэгдэж болзошгүй гэсэн ийм эрсдэл бол байна.

Дараагийн эрсдэл бол юу вэ гэхээр өнөөдөр ханиш бол тогтвортой байгаа. Ханиш тогтвортой байна гэсэн тэр бас асуудал байгаа. Тэгээд ханишны уналтыг мөнгөний бодлогоор л одоо зохицуулахгүй байх юм сан. Интервенц хийхгүй байх юм сан. Тэр үг байгаа шүү дээ. Нөгөө ханишийг интервенц хийх нь ялааг лантуугаар цохисонтой адил гэж. Ийм юм хийхгүй байх юм сан. Энэ дээр анхаармаар байна. Эхнээс нь сайн бодож, мөнгөний бодлогоо эндээ зохицуулж явах нь зүйтэй гэж бодож байгаа.

Манай нүүрсний салбарын тоо, үнийн өсөлт төлбөрийн тэнцэлд энэ онд ашигтай гарахад нөлөөлж байгаа. 2024 онд төсвийн давамгайл байдлууд үүснэ. Энэ дээр бол мөнгөний бодлогыг нь

зохицуулах шаардлагатай. Үүнийг эртнээс харах ийм шаардлага бол үүсээж байгаа гэж байгаа юм. Төв банкны төсвийн шинжтэй ажлыг бол бид нар салгаж чадаагүй. Энийг бол салгах ёстой гэж ингэж бодож байгаа. 2024 онд 1,3 орчим тэрбум долларын гадаад өр төлөх ёстой. Тэр Хуралдай бондоо төлөх бол төрийн үүрэг байж байгаа. Тэр МИК гээд компанийн 250 сая доллар байгаа. Энийг Худалдаа хөгжлийн банк төлчих биз. Тэр Энержи ресурсийн 440 сая долларын эргэн төлөлт төлөгдөх ёстой. Үүнийг бас төлбөрийн тэнцэл, валютын нөөцөд нөлөөлөх вий гэсэн ийм юу байгаа. Ийм бас болгоомжлол бол байна. Энэ оны төсвийн тодотголоор 1,9 их наяд төгрөгийг бид нар голдуу цалинд нэмчихсэн дээ. Энэ 2024 онд хадгалагдана. 2024 онд мөн төсвийн зарлага 5 их наядаар нэмэгдэж байгаа. Энэ юу гэхээр бас инфляцыг өдөөнө. Тэгэхээр 2023 оны эхний 10 сард инфляц 9 хувьтай гарсан үнэн боловч гол хүний хэрэгцээний анхны хэрэгцээ хоол, байр, боловсрол гээд бүгд 14 хувиас илүү өсөлттэй байгаа. Тэгээд энэ дээр анхаарч ажиллана биз дээ. Тэгээд ер нь эдийн засгийн 3 үзүүлэлт байгаа шүү дээ.

1 дүгээрт нь ханиш,

2 дугаарт нь инфляц,

3 дугаарт нь эдийн засгийн үр ашиг.

Энэ 3 үзүүлэлтээ л бид нар барьж ажиллах ёстой л юм байгаа юм л даа. Тэгээд ер нь бол инфляцын хохирлыг хассан тэр бодит өгөөж бидэнд хэрэгтэй. Ийм өгөөж байхгүй л байгаад байгаа юм л даа. Тэгэхээр мөнгөний бодлого дээр.../минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** Баттөмөр даргын асуултад хариулъя. Хэн хариулах вэ. Монголбанкны ерөнхийлөгч Лхагвасүрэн хариулъя. Ажлын хэсгийн 83 дугаар микрофоныг өгье.

**Б.Лхагвасүрэн:** Баттөмөр гишүүний асуултад хариулъя. Баттөмөр гишүүний ерөнхийдөө саяын ярьж байгаа тэр эрсдэлүүд бол 2024 онд байгаа гэдгийг бол Монголбанк мөнгөний бодлоготой тооцоод бас бодож байгаа. Зүгээр яг л таны хэлсэнтэй бол адилхан. 2024 оны төрийн мөнгөний бодлогынхоо үндсэн чиглэлийг бид боловсруулахдаа Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, тэгээд бусад яг л хууль тогтоомжид яаж байна вэ гэдгээрээ төсөөллөө хийсэн. 2024 оны төсөв бол ерөнхийдөө 2023 онд гарч байгаа бүх л эерэг үзүүлэлтүүдийг л бас ирэх 2024 ондоо үргэлжлээд явна гэдгээрээ нэлээн тийм том төсөв бол хийгдчихсэн байгаа. Тэр нь өөрөө Монголбанкны хувьд бол нэлээн сорилт болохоор болчихож байгаа юм. Яагаад гэвэл эдийн засгийн өнөөдөр байгаа 6,5-ын өсөлтийг ирэх жилд энэ хэмжээнд нь байлгахын тулд мөнгөний бодлогын зүгээс бол дэмжих ийм орон зай байхгүй болчихож байгаа юм. Ерөөсөө хувийн сектор бол обанкны салбараар дамжуулж Төв банк л өөрөө мөнгө хэвлэж гаргахгүй гээд хатуу мөнгөний бодлого явуулж байгаа учраас одоо яг л банкны сектор дээр байгаа эх үүсвэрээр л банк өөрөө хувийн секторыг нь санхүүжүүлэхээр ингэж явж байгаа. Тэгээд тэр утгаараа бол мөнгөний бодлого бол 2024 онд бол нэлээн тийм инфляцынхаа зорилтот түвшинд ортлоо бол ийм хатуугаар үргэлжлэхээр ингэж төлөвлөгдөөд явж байгаа.

Таны хэлсэн ирэх онд бас нэлээн томоохон төлбөрүүд байгаа. Тэгэхдээ зүгээр нааштай зүйлүүд гэвэл Энержи Ресурсийн 440 сая долларын бонд бол ерөнхийдөө дахин санхүүжигдсэн. Тэр мэдээлэл нь ирсэн байгаа. Яах вэ, дахин санхүүжиж боссон, өнөөдрийн нөгөө дэлхийн өндөр хүүтэй байгаа гэдэг утгаараа нэлээн өндөр хүүтэйгээр дахин санхүүжигдэж байгаа. Монголын ипотекийн корпорацын 250 сая долларын бас төлбөр ирэх жил байгаа. Тэгэхдээ бидний авч байгаа мэдээллээр энэ ондоо тэд нар дахин санхүүжүүлэхээр бол бас

явах гэж байгаа юм байна лээ олон улсын зах зээл рүү.

Ирэх онд бол Засгийн газрын өөрийнх нь төлөх ёстой Засгийн газрын бондын 370 сая долларын өр байгаа. Сая бол ерөөсөө 2, 3-хан 7 хоногийн өмнө 350 сая долларын өр төлөгдсөн. Тэр утгаараа бол ирэх жил төлөгдөх 370 сая бол тийм их бас төвөгтэй ачаалал авчрахгүй болов уу гэж Монголбанкны зүгээс бол харж байгаа юм.

**Л.Мөнхбаатар:** Тодруулж асуух уу та. Байнгын хорооны дарга Баагагийн Баттөмөр тодруулж асууя.

**Б.Баттөмөр:** Нийлүүлэлтээс үүдэлтэй инфляцыг мөнгөний бодлогоор шийдэхгүй. Төсвийн бодлогоор шийдэх ёстой шүү. Энийг бол хатуу анхаарах ёстой. 20-хон төрлийн бараа байгаа шүү дээ. Үүнийхээ асуудлыг шийдэх ёстой шүү дээ. 1 дүгээрт нь.

Дараагийн асуудал юу гэхээр манай энэ урсгал данс байнга алдагдалтай явж ирсэн. Энэ онд жоохон гайгүй ашигтай явж байх шиг байна. Тэгээд урсгал данс алдагдалтай байна гэдэг чинь гаднаас авах санхүүжилтийн хэрэгцээг л үүсгээд байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ урсгал данс маань цаашаага одоо танайхны хийсэн судалгаагаар өнгөрсөн жилүүдэд 2021 онд билүү 6 их наяд төгрөгийн алдагдалтай гарсан байдаг юм шүү дээ. Тэгээд энийг та нар юу гэж харж байна. 2024 онд юу гэж харж байна. Энэ урсгал дансны алдагдлыг л бий болгохгүй байх боломжууд юу байна гэсэн ийм юм байж байгаа юм.

Хамгийн сүүлчийн асуудал энэ мөнгөний бодлогын 1 асуудал бол санхүүгийн захыг хөгжүүлэх. Сэргэлт бол их сайн байгаа. Энэ дээр.../минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** Тодруулгад нэмж хариулъя. Монголбанкны Ерөнхийлөгч

Лхагвасүрэн хариулъя. Ажлын хэсгийн 83 дугаар микрофоныг өгье.

**Б.Лхагвасүрэн:** Баттөмөр гишүүний асуултад тодруулж хариулъя. 2008 оноос хойш анх удаагаа 2023 онд урсгал данс ашигтай гарсан. Тэгээд энэ маань өөрөө ер нь урсгал данс бол өөрөө манай гадагшаа хийж байгаа хөрөнгө оруулалт, гаднаас манай руу хийж байгаа хөрөнгө оруулалт 2-ын л зөрүү байгаад байгаа юм үйлчилгээний. Тэгэхээр тэр утгаараа ерөнхийдөө худалдааны тэнцэл ашигтай гараад, наашаа орох урсгал нь сайжраад ирж байгаа учраас бол ерөнхийдөө урсгал тэнцэлд сайн нөлөө үзүүлж байгаа юм. Өөр нэг зүйл нь гэвэл яах вэ ирэх жилүүд, ирээдүйд урсгал данс бол бас гайгүй байх магадлал нь юу вэ гэхээр Оюутолгойн том төсөл энэ оны 3 сард нөгөө гүний уурхайн бүтээн байгуулалт дуусаад, гүний уурхайн бүтээн байгуулалтад зориулж томоохон хөрөнгө оруулалт буюу дотогшилох зээлийн өр хэлбэрээр бичигдэх өр бол ерөнхийдөө буурах байх гэсэн хандлагатай. Гэхдээ мэдээж нөгөө талдаа гадаадын хөрөнгө оруулалт бол өөр.

**Л.Мөнхбаатар:** Тодруулгад гүйцээгээд хариулчихъя. Лхагвасүрэн Ерөнхийлөгч хариулъя.

**Б.Лхагвасүрэн:** Тэгэхлээр ерөнхийдөө ийм томоохон хөрөнгө оруулалтууд л их орж ирээд ийшээ орох зээл хэлбэрээр бүртгэгдэх урсгал их нэмэгдвэл урсгал данс алдагдалтай гарахаар байгаа юм. Тэгэхээр бидний хувьд бол мэдээж нэг талдаа энийг тэнцвэрийг нь балансжуулахыг нь барих нь л чухал гэдгээс харж байгаа.

**Л.Мөнхбаатар:** Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дэд дарга Мөнхөөгийн Оюунчимэг асуултаа асууя.

**М.Оюунчимэг:** Төсөв , мөнгөний бодлогыг уялдуулаад ипотекийн зээлийг

аль болохоор хүртээмжтэй байх тал дээр бид нар асуудлыг тусгана гэсэн. Сая төсөв батлах үед орон нутагт болоод гэр хорооллыг орон сууцжуулахад оролцож байгаа компаниудыг гааль, НӨАт-ын татвараас чөлөөлөх, бас ипотекийн зээлд хамруулах зэрэг асуудлууд тодорхой тогтоол болгож бас нөгөө дагалдах юугаар гарчихсан байгаа. Гэхдээ эх үүсвэр нь төсөв дээр жишээ нь тусаагүй, батлагдаагүй. Төрөөс баримтлах мөнгөний бодлого дээр ипотекийн зээл 6 хувьтай байгаа. Тэгэхээр бид нар энийг Монголбанкийг дэмжиж, Монгол банк, Засгийн газар 2-т үүрэг өгөөд нэмэгдүүлнэ гэж хэлсэн. Түрүүн та бас хэлж байна л даа. Ипотекийн зээл 6 хувь 450 орчим тэрбум төгрөг бас шаардагдах тооцоо гарч байгаа гээд. Тэгэхээр энийг бүгдээрээ төрөөс баримтлах мөнгөний бодлого дээр чиглэл өгөөд, арилжааны банкнуудаас юм уу эсвэл одоо яаж Засгийн газар, Сангийн яамтайгаа уялдаад тусгах бололцоо байгаа юу.

Нөгөө эргэн төлөлтөөс ойролцоогоор 200 гаруй тэрбум төгрөг орж ирдэг гэж байгаа. Одоо яг эргэн төлөлтөөс үнэхээр ингэж орж ирж чадаж байна уу, үгүй юу. Ковидын дараа бол эргэн төлөлт нэлээд амаргүй байдалд орчихсон байгаад байгаа шүү дээ. Тэгэхээр эргэн төлөлтөөс хэрвээ ингэж орж ирвэл 200 тэрбумыг нь бид нар хуучин нэг арилжааны банкнуудын эх үүсвэрээс гээд та бүхэн минь зохицуулж байж бас 400 хүргэж байсан тохиолдол байгаа шүү дээ. Яагаад гэвэл одоо нийслэлийн шинэ удирдагч нар бас орж ирээд гэр хорооллыг орон сууцжуулах дээр яаж ийж байгаад ипотекийн зээл 6 хувьд хамруулна, ногоон зээлд олгоно гээд байгаа. Гэхдээ энэ өөрөө Төрөөс баримтлах мөнгөний бодлого дээр бас сууж байж, тусаж байж асуудал явагдана л даа. Тэгэхээр яг тодорхой асуулт маань одоо яг ипотекийн зээлийн эргэн төлөлтөөс хэд орж ирж байна. Энийг бид нар орж ирж байгааг нь дахиад 200 тэрбумаар нэмэгдүүлье гэвэл

эх үүсвэрийг хаанаас олох бололцоо байна гэсэн асуулт байна.

2 дахь асуулт нь түрүүн та ч бас хэлж байна л даа. Зээл 11 хувийн өсөлттэй байгаа. Гэхдээ 1-хэн хувь нь л бизнесийн зээл, 10 хувь нь хэрэглээний зээл гэдэг чинь ард иргэдийн орлого хэцүү л байна гэсэн үг шүү дээ. Цалингийн зээл, тэтгэврийн зээл, зээлээс зээлийн хооронд л яг амьдарч байна. Хэрэглээний зээлийг аль болохоор бууруулах бодлого барьж байгаа гэсэн хэр нь бууруулж бас бид нар чадахгүй байгаад байна шүү дээ. Тэгэхээр бодлогын хүү 13, арилжааны банкны зээлийн хүү 18-22 байгаа. Банк бус санхүүгийнх чинь бүүр 25 хувь байхад ААН-үүд яг энэ бизнесийн зээл аваад, үйл ажиллагаагаа явуулаад, ажлын байр бий болгоод, мөнгөний нийлүүлэлтээр зах зээл дээр мөнгө гаргах бололцоо үнэхээр хумигдмал харагдаад байна шүү дээ. Тэгэхээр одоо бүгдээрээ түрээс баримтлах мөнгөний бодлого төсөвтэй үед яаж ингэж зээлийн хүүг бууруулах вэ. ААН-үүд чинь зээл маш их хүсэж байна. Тэгэхдээ олдохгүй байна гээд байна шүү дээ. Маш томоохон ААН-үүд л ич эргээд ицбаталгаатай гэдэг утгаараа тэд нарт ич тодорхой хэмжээгээр олддог юм шиг байна. Тэгэхээр энэ чинь өөрөө бас нэлээд мөнгөний хатуу бодлого үргэлжлэх бодлого явагдаад байна л даа. Тэгээд яаж бүгдээрээ энэ бизнесийн зээлээ дэмжих вэ. Их Хурлаас жишээ нь ямар дэмжлэг хэрэгтэй байна. Энэ дээр хариулт авчихъя гэж бодож байна.

**Л.Мөнхбаатар:** Асуултад хариулъя. Монголбанкны ерөнхийлөгч Лхагвасүрэн хариулъя.

**Б.Лхагвасүрэн:** Оюунчимэг гишүүний асуултад хариулъя. Төсөв батлагдаад төсвийг дагаж гарсан тогтоол дээр ипотекийн зээлийг Монгол банк ямар ч байсан Засгийн газарт шилжүүлж үргэлжлүүлэхээр тогтсон байгаа. Дээр нь төрөөс баримтлах 2024 оны мөнгөний бодлогын үндсэн чиглэлийн төсөл дээр гарч байгаа ажлын хэсэг дээр

санал давхар гараад ерөнхийдөө төрийн мөнгөний бодлогын үндсэн чиглэл дотор тогтоолын 2 дугаар төсөл хэлбэрээр энэ ипотекой холбоотой заалт нь орж ирж байгаа юм. Энэ заалт нь өөрөө ямар ч байсан Засгийн газраас эрх зүйн орчныг бүрдүүлж шилжүүлж авах хүртэл хугацаанд хөтөлбөрийг тасралтгүй хангаж ажиллахыг бол Монгол банканд үүрэг болгоод, гэхдээ харин санхүүжүүлэх хэмжээг нь бол ерөнхийдөө тогтоогоод өгчихсөн. Зээлийн эргэн төлөлтөөс гэж байгаа юм. Тэгэхээр бол яг энэ оны хувьд бол бидний тооцооллоор бол 500-аад тэрбум төгрөг орж ирнэ. Ирэх онд ч гэсэн 500 орж ирнэ. Өнөөдрийн 6%-ийн хүүтэй хөтөлбөр маань өөрөө Монгол банк 80 хувийг нь хариуцаад, арилжааны банк 20 хувийн эх үүсвэрийг нь гаргаад явж байгаа юм. Тэгэхээр хэрвээ Монгол банкны эх үүсвэр өөрөө 500 тэрбум төгрөг орж ирээд, эргээд энэ бол эдийн засагт өөрөө эргэлдэж байгаа мөнгө л дөө. Тэгэхээр энэ мөнгө нь эргээд л эргэлт чиглэлийнхээ хөтөлбөрөөр эргээд 500 гарахад банкнууд бол 120-ийг ч юм уу нэмж яахаар. Тэгэхээр бид нарын хувьд бол ирэх онд ипотекийн хөтөлбөр бол 620 орчим тэрбум төгрөгөөр эргэлдэх боломжтой гэж харж байгаа юм. Тэгэхээр энэ хэмжээгээр явахад бол ерөнхийдөө эрэлт нийлүүлэлт талаасаа бол бас нийцтэй байж болно л гэж харж байгаа юм.

2 дахь асуултын хувьд бол ер нь бол яах вэ, Инфляц өөрөө өнөөдөр 10 сарын эцсийн байдлаар 9 хувьтай буюу Монголбанкны зорилтот түвшин яах вэ, энэ 2023 онд баримталж байгаа зорилтот түвшинд ороод ирж байгаа юм л даа. 1 оронтой тоо гэдгээрээ. Ирэх онд бид нар төв банкны зүгээс бол 6+-2 гээд 6-8 хувийн тэр орон зай руу аваачих гэж байгаа зорилго руу. Тэр утгаараа төсөв өөрөө 20 хувиар тэлчихсэн байгаа гэдэг утгаараа эрэлтийг эдийн засгийг идэвхжүүлнэ, эрэлтийг нэмэгдүүлнэ. Тэгээд инфляц бол нэлээн өдөөгдөх байх. Тэгээд 5 их наядаар нэмэгдэж байгаа

төсөв гэдгээрээ 1 их наядаар нэмэгдэхэд инфляц дээр 1 хувийн дарамт үүснэ гээд өмнө нь төсвийн тодотгол хийж байхдаа Сангийн яам өөрөө ийм тооцоолол хийсэн байдаг. Тэр утгаараа 2024 онд бол 5 их наядаар нэмэгдэхэд 5 нэгж хувийн инфляцын дарамт орж ирэх магадлалтай гэдэг утгаараа мөнгөний бодлого бол хатуу үргэлжилнэ. Энэ утгаараа Монголбанкны зүгээс бол мөнгөний нийлүүлэлтийг ялангуяа зээл хэлбэрээр гарах мөнгөний нийлүүлэлт байхгүй ээ гэдэг л ийм төсөөлөлтэй л явж байгаа юм.

**Л.Мөнхбаатар:** Тодруулах юм уу. Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн тодруулж асууя.

**М.Оюунчимэг:** Төсөв гэхэд 5 их наядаар гээд ярьж байна. Ер нь бол эдийн засаг сайжирч байна шүү дээ. Гадаад, дотоод нөхцөл байдлын хувьд ч гэсэн бид нар үнэхээр ашиглаж чадвал бас өвөрмөц боломж гарч ирж байна. Тэгэхээр Монголбанкныхан маань бас энэ дээр нэлээд санаачилгатай ажилладаг. Ядаж байхад л та бүхэн маань своп хэлэлцээрийн тухай асуудлууд байгаа. Тэгэхээр гадаад, дотоод нөхцөл байдлаа нэг сайн ашиглаад бас энэ дээр нэг бизнесийн зээлийг ААН-үүдэд олгож байж, ажлын байр нь нэмэгдэнэ. Тэгэхгүй бол ажлын байр олигтой нэмэгдэхгүй, иргэдийн орлогыг бид хамгаалж чадахгүй байгаад байгаа нь л хамгийн асуудал биш. Гэтэл юмны үнэ ханиш ямар өндөр байгаад байна. Тэгээд 1-д бид иргэдээ ажлын байраа хангах, тэгээд энэ үнэ хаништай уялдуулж мөнгөний бодлогоо зохицуулах хэрэгтэй байгаа.

2-т нь та сая хэлж байна. 620 орчим тэрбум төгрөг ипотекийн зээл рүү гарах өндөр байгаа гээд. Энэ дээр шинэ гэр бүлүүд, дээрээс нь гэр хорооллыг орон сууцжуулах ажил шинээр эхлэх гэж байна. 16 мянга орчим айл өрх гэж байна. Тэгэхээр та бүхэн маань бас энэ дээр аль болохоор гэр хорооллын



өрхүүдийг хашаандаа сайхан амьдрах эсвэл тэр хаус бариад амьдрах тэд нар ипотекийн.../минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** Санал хэллээ. Нэмж хариулах юм уу. Ажлын хэсгийн ахлагч Чинбатын Ундрам асуултад нэмж хариулъя.

**Ч.Ундрам:** Оюунчимэг гишүүн маш чухал асуудлуудыг хөндлөө. Тэгээд 1 дүгээрт ипотекийн зээлтэй холбоотойгоор бид нар ажлын хэсэг дээр энийг нэлээн ярилцаад, тэгээд нөгөө гэр хорооллын дахин төлөвлөлт болон амины орон сууцыг эко байдалтай барих юм бол ипотекийн зээлийн 20 хүртэлх хувийг яг тэр гэр хороолол руу чиглүүл гэдэг ийм заалтыг зарчмын зөрүүтэй саналаар оруулж ирж байгаа шүү. Тэрийг бас та хэд маань дэмжээд өгөөрэй гэж хүсэх байна.

2 дугаарт яг энэ бизнесийн зээл багасаад, одоо энэ оны үзүүлэлтийг харах юм бол хэрэглээний жилийн зээлийн жилийн өсөлт 35 хувьтай байхад бизнесийн зээлийн өсөлт дөнгөж 10 хувьтай. Тэгээд ихэнх нь нөгөө хүнсний хувьсгалын хүрээнд бид нарын 2023 онд тавьсан хүүгийн татаастай холбоотойгоор өнөөдрийн байдлаар 650 тэрбум төгрөгийн зээл батлагдаад гарчихсан энэ хүнсний салбар луу. 340 тэрбум төгрөг бол.../минут дуусаю/

**Л.Мөнхбаатар:** Цэндийн Сандаг-Очир гишүүн асуултаа асууя.

**Ц.Сандаг-Очир:** Баярлалаа. Төрөөс мөнгөний талаар баримтлах 2024 оны бодлогын баримт бичгийн асуудлыг хэлэлцэж байна. Тэгээд гадаад талаа ер нь юу гэж дүгнэж байгаа вэ. Манай мөнгөний бодлогод хэрхэн яаж нөлөөлж байгаа вэ. Үнэ ханшийн асуудал ер нь ирэх жил гол нэр төрлийн экспортын бараа бүтээгдэхүүний чинь үнэ хани ер нь Засгийн газрын сая төсөв батлахад оруулж ирдэг үнэ хани тэр хэмжээнд

яаж хэрхэн яаж тооцож байгаа вэ. Хэр бодитой байгаа вэ гэдгийг нэгд асууя.

Нөгөө талаар ирэх жил бид нар сая төсөв батлахдаа 4 сарын 1-ээс цалин, тэтгэвэр, тэтгэмжийг 10 хувиар нэмэгдүүлэхээр баталлаа. 1 сарын 1-ээс хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэмэгдүүлж байна. Тэгээд энэ зүйлүүд чинь цалин хөлсийг нэмэгдүүлэхээр инфляцын өсөлтөд хэрхэн яаж нөлөөлөх вэ. Бараа бүтээгдэхүүний үнэ хани өсөхгүй гэх баталгаа юу байна вэ. Бараа бүтээгдэхүүний үнэ өсөөд эхэлчихвэл тэгээд цалин нэмсний хэрэг гэж байна уу, үгүй юү гэдэг асуудал яригдаад байна. Өнгөрсөн жилийн баталсан гол нэр төрлийн бараа бүтээгдэхүүний үнийн өсөлтөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр баталсан хууль, тогтоомжуудын хэрэгжилт ямар байгаа вэ. Бензин шатахуун, мах, гурил өнгөрсөн жилийн инфляцын өсөлтөд хамгийн их нөлөөлсөн хүчин зүйл бол мах байсан. Одоо энэ жил гурил орж ирж байна. Ингэхээр чинь цалин, тэтгэврийн нэмэгдэл нэмэгдэл болж харагдахгүй байна. Энийг Монголбанк юу гэж үзэж байгаа вэ.

3 дахь асуулт нөгөө нэр төрлийн 4-5 арилжааны банкнуудыг олон нийтийн оролцоог хяналтад байлгана гэсэн, нээлттэй болгоно гэсэн энэ ажил ямар шатдаа яваа вэ. Аль аль банкнууд ийм болж байна вэ.

4-д гаднын банк оруулж ирэх асуудлыг өмнө нь бас ноднин өдийд ярьж байсан. Бодлогын хүү өндөр байна. Зээлийн хүү өндөр байна. Өрсөлдөөнийг бий болгоё. Эх үүсвэр сайтай гаднын банкыг оруулж ирэх асуудлыг судалж байгаа энэ тэр гэж ярьж байсан. Энэ асуудал чинь жилийн дараа юу болж байна вэ. Ахиад судалгааны шатдаа явж байна уу, үгүй юу. Ийм 4 асуултад та бүхэн хариулт өгөөч.

**Л.Мөнхбаатар:** Монголбанкны ерөнхийлөгч Бядрангийн Лхагвасүрэн хариулъя.

**Б.Лхагвасүрэн:** Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя. Ерөнхийдөө гадаад орчин бол тийм таатай биш байгаа. Сая хамгийн сүүлд ОУВС-ийн жилийн уулзалтын үеэр бүс нутгуудын, томоохон улс орнуудын зах зээл ялангуяа эдийн засгийнх нь цаашидын төлөвийг бол тодорхойлсон. Тэгээд 2023 оны эхэнд 2022 онд байж байсан тэр төсөөллүүдээ дандаа бууруулсан байгаа. Дэлхийн эдийн засгийн нийт өсөлтийг 3 хувьтай байсан бол 2,9 болгоод буулгах жишээтэй. Тэгэхээр бол гадаад орчин бол бас тийм сайнгүй байгаа гэдэг нь бол тэндээс харагдаж байгаа юм. Зүгээр Монгол Улсын хувь бол манай гадаад худалдааны бараг нийт экспортын 93 хувь нь уул уурхай. Тэр дотроо манай хамгийн том гаргадаг зах зээл нь БНХАУ байгаа. Тэгээд БНХАУ-ын эдийн засгийн өсөлтийг бол бас л олон улсын байгууллагууд бууруулж байсан хэдий ч гэсэн сая 3 дугаар улирлын байдлаар төсөөлж байснаас арай өндөр гарсан учраас бол бас нэлээн нааштай талаас нь үнэлж байгаа. Тэр утгаараа Монгол Улсын хувьд бол манай гол экспортын бараа бүтээгдэхүүн хэвийн хэмжээндээ гарах юм бол нэг л зах зээл рүү гарч байгаа гэдэг утгаараа гарах юм бол ерөнхийдөө манай эдийн засагт бол бас яг тийм ч бас төвөгтэй биш л гэж харж байгаа юм. Тэгэхдээ хамгийн гол нь манай уул уурхайн бүтээгдэхүүн өөрөө 3-4 нэр төрөл байгаа. Нүүрс, зэс, төмрийн хүдэр, алт гэдэг юм уу. Тэгэхээр ийм 3, 4 бүтээгдэхүүний үнийн савлагаа нь өөрөө бидний эдийн засагт бол томоохон цочроо үүсэх нь ойлгомжтой. Ялангуяа Монгол Улсын эдийн засаг энэ жил их өндөр өсөлттэй, төсвийн орлого их сайн бүрдэж байгаа нь бол ганцхан бараанаас л болж байгаа. Нүүрс. Тэр утгаараа хэрвээ нүүрсний экспорт нь сайн байгаад, үнэ тогтвортой байх юм бол эдийн засаг хэвийн байж болно гэж Монголбанкны зүгээс бол зүгээр харж байгаа.

Инфляц бол сая 9 хувьтай гарсан. 9 хувийн инфляцтай гарахыг харахад бол

энд ерөөсөө 9 хувийн инфляцын бараг 4,5 буюу 50 хувийг нь 20 бараа бүтээгдэхүүний л үнийн өсөлт л эзэлж байгаа. Тэр дотор нь 13 дотоодын хүнс байгаа. Тэр 20 бараа бүтээгдэхүүн 13 нь. Энэ 13 дотроо 3 бүтээгдэхүүн, мах, гурил, сүү гэсэн энэ 3 бүтээгдэхүүн бол өөрөө бараг 10 гаруй хувийг нь эзлээд явчхаж байгаа. Тэгэхээр зөвхөн ер нь цөөхөн хэдэн бараа бүтээгдэхүүний үнийн өсөлт л инфляцыг л өндөр түвшинд байгаа учраас эдгээр бараа бүтээгдэхүүний нийлүүлэлт, ханган нийлүүлэлт, үнэ дээр нь хэрвээ тодорхой бодлого хэрэгжүүлээд явах юм бол ерөнхийдөө инфляц бол өөрөө хэвийн хэмжээнд орох боломжтой гэж харж байгаа. Бензин шатахууны хувьд бол Засгийн газрын нэг тийм хөтөлбөр явж байгаа. Тэгээд 30 хоногийн аюулгүй нөөц бүрдүүлэх гэдэг утгаараа тэгээд манайд өгч байгаа мэдээллээр бол яах вэ банкны сектор бол бензиний тодорхой хэмжээний нөөц бүрдүүлэхэд нь бол бас хөнгөлөлттэй банкны салбараас зээл олгоод явж байгаа. Энэ зээл нь өөрөө одоо бол үргэлжилсэн хэвээр явж байгаа. Тэгээд үүний хүрээнд нөөц бол гайгүй хэмжээнд бол бүрдээд яваад байгаа гэж.

Банкнудтай холбоотой асуултын хувьд бол Банкны тухай хуульд орсон өөрчлөлтийн дагуу энэ оны 6 сарын 30-ны дотор системийн нөлөө бүхий 5 том банк Хаан банк, ХХБ Голомт банк, Хас банк, Төрийн банк гээд энэ 5 банк бол олон нийтийн ХК-ийн хэлбэрт шилжсэн. Нийт 5-11 хувиа олон нийтэд зарж, борлуулж, хувьцаагаа эзэмшүүлсэн байгаа. Энэ хүрээнд 473 тэрбум төгрөг бол цугларсан. Хэрвээ банкны дүрмийн сангийн доод хэмжээ гээд 100 тэрбум гээд Монгол банкнаас тогтоосон хэмжээ байдаг. Энэтэй зүйрлэх юм бол ийм хэмжээний мөнгөөр бол 5 том банк шинээр үүсэх боломжтой ийм хөрөнгийг бол цуглуулж чадсан. Тэгээд энэ Ай Пи Өү олон нийтэд хувьцаагаа арилжаалсан үйл ажиллагаа бол амжилттай болсон байгаа.

Гаднын банкыг Монгол Улсад оруулах талаар бол Монголбанк өөрийнхөө хууль дүрэм дотоод журмуудаа нэлээн хөнгөлөлт чөлөөлөлтийг үзүүлээд явж байгаа. Тэгээд энэ хүрээндээ бол гаднын арилжааны банкны салбар бол Монгол Улсад бол нээх тэр зохицуулалтыг бол маш их хөнгөлж өгсөн байгаа. Тэгээд яг өнөөдрийн хувьд бол яг манайд Монголбанканд салбараа нэе, бие даасан банкны... /минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** Гүйцээгээд хариулчихъя. Лхагвасүрэн Ерөнхийлөгч.

**Б.Лхагвасүрэн:** Сандаг-Очир гишүүний асууд гүйцээгээд хариулахад тэгээд гаднын ийм банкны яг хүсэлт бол өнөөдөртөө Монголбанканд ирээгүй байна. Тэгэхдээ бидний хувьд бол сая энэ зун зохион байгуулсан Монголын эдийн хэсгийн форумын үеэр одоо энэ олон улсын хөрөнгө оруулагч нарт дүрэм журам бол ингэж хөнгөлж чөлөөлөгдсөн байгаа шүү. Гаднын банкны салбар орж ирэхэд Монголбанк бол дэмжин ажиллахад бэлэн байна гэдгээрээ бас тодорхой мессеж буюу урилгыг бол хүргэсэн. Дараа нь бол Бүгд Найрамдах Солонгос Ард Улсад бас тодорхой хэмжээний банкнуудтай уулзаж Солонгосын банкнуудыг Монголд салбар төлөөлөгчийн байгууллагаа байгуулахад нь бол дэмжлэг үзүүлж ажиллах болно гэдгээ бас хэлсэн байгаа.

**Л.Мөнхбаатар:** Хариулт хангалттай байх 4 асуулт асууж, хариулт тавилаа. Жигжидийн Батжаргал. Одоо Дашидондогийн Ганбат гишүүн асуултаа асууя.

**Д.Ганбат:** Монгол Улсын 2024 оны мөнгөний бодлогын талаар бид нар ярилцаж байна. Ямар ч байсан хуулийн хугацаандаа багтаад 2024 оны Монгол Улсын төсвийг баталсан. Засгийн газраас өргөн барьсан Монгол Улсын 2024 оны төсөв бол яг өнөөдрийн баталсан төсөвтэй харьцуулаад үзэхэд бол арай өөр байгаа. Тухайлбал, цалин

хөлсийг 4 сарын 1-ээр нэмэхээр ингэж оруулж ирсэн. Төсвийн бодлого, мөнгөний бодлого маань хоорондоо хэр уялдаж байгаа вэ. Яг одоо харж болохоор байна. Цаашидаа ямар байх вэ гэдэг дүр зургийг бол. Анх оруулж ирсэн та бүхний мөнгөний бодлого энэ өөрчлөгдөж байгаа нөхцөл байдалтайгаа уялдаад өөрчлөгдөх үү, Ямар байх вэ. Ер нь Монгол Улсад гадаад валютын албан нөөц хэд байвал болдог юм. Хэд байх зорилт тавьж байна та бүхэн. 2024 онд. Нөгөө талаар бол бид бүхэн 24 сар инфляцтай явлаа. Инфляц инфляцдаа 2 оронтой тоотой. 2 удаа л 9 гэсэн тоо руу орж ирлээ энэ хугацаанд. Сая 10 дугаар сард 9 тоо руу орж ирж байна. Энэ одоо урьд өмнө байгаагүй ийм их төсвийг бид бүхэн баталж байна. Үндсэндээ бол одоо бараг Венесуэл өөр юу байдаг юм өмнө нь дампуурч байсан улс орны араас л явчихлаа л даа. Тэгээд энэ төсөв 2024 онд хэрэгжинэ гэдэг бол сонгуулийн төсөв учраас бараг л хэрэгжихгүй байх даа. Тэгээд бид нарын эдийн засаг бол маш хүнд байгаа. Хүнд ч юу байх вэ эмзэг байгаа гэж би ойлгож байна. Энэ бол ганцхан нүүрстэй л уясан эдийн засаг байгаа. Урд хил, гаальтай холбогдоод Хятад улсын манай уул уурхайн бүтээгдэхүүнийг авах авахгүйгээс шалтгаалаад ямар ч нөхцөл байдалд орж болно. Та бүхний жилийн жилд нөгөө тавьдаг 6+-2 билүү ийм юмаар явъя л гэдэг. Тэгээд лав л 2 3 жилийн нэг явахыг нь би харсангүй. Энэ 2024 онд одоо яах юм бол. Энэ улсын 2024 оны төсвийг баталсантай холбогдуулаад харах юм бол төсөөлөл бол тийм өөдрөг биш байна. Энэтэй уялдаад ямар ямар эрсдэлтэй хүчин зүйлүүд байна гэж тооцож байна вэ гэсэн зүйл байна.

Тэгээд инфляц чинь өөрөө хамгийн хүнд хэцүү байгаа 3-ны 1 нь шүү дээ бид нарын. Би бол 2 хүний нэг нь болчихлоо гэж ойлгож байна. Дундаж давхарга гэж байхгүй болчихсон. Энэ хүмүүс дээр бол маш хүнд тусаж байгаа. Энэ бүхнийг маань та нар яаж төсөөлж байна вэ. Мөнгө маш их хэвлэж байна гэж ярих

юм. Хэдий хэмжээний мөнгө хэвлэж байна. Тэгээд банкуудыг олон нийтийн хяналтад оруулчихлаа гэж, би тэгж бодохгүй байна. 5-11 хувийг ххувьцаа болгоод ингэчихсэний дараа бол олон нийтийн хяналтад орж чадахгүй. Илүү энийг ихэсгэх ийм бодол санаа байна уу, байхгүй юу.

**Л.Мөнхбаатар:** Асуултад хариулъя. Монголбанкны ерөнхийлөгч Бядрангийн Лхагвасүрэн асуултад хариулъя.

**Б.Лхагвасүрэн:** Ганбат гишүүний асуултад хариулъя. Ерөнхийдөө яах вэ, Засгийн газрын төсвийн бодлого Монголбанкны хэрэгжүүлж байгаа мөнгөний бодлогын хоорондын уялдаа гээд ер нь бол уялдаа гэдэг нь бол Засгийн газар нэгэнт төсөвөө тийм хэмжээний орлого орно, тэгж тийм хэмжээний зардал гаргана гээд төсөвлөөд орж ирээд явж байгаа. Энэ нь өөрөө эдийн засагт хэр хэмжээний ачаалал үүсэх вэ гэдэг талаас нь Монголбанкны мөнгөний бодлого талаасаа л бид нар хараад явж байгаа. Хэрвээ төсөв алдагдалгүй буюу ямар нэг нэмэлт зүйл байхгүй гэдгээр явах юм бол мэдээж Монголбанканд бол орон зай бол гарч ирэх боломжтой. Монголбанкны мөнгөний бодлого бол өөрөө санхүүгийн салбараар дамжиж арилжааны банкны зээл хэлбэрээрээ л эдийн засаг руу очиж байгаа гэдэг утгаараа. Тэгэхээр тэр утгаараа хэрвээ инфляц өөрөө яг Монголбанкны зорьж байгаа түвшинд ирж чадахгүй хүртэл хугацаанд өнөөдөр Монголбанкны баримталж байгаа мөнгөний хатуу бодлогоо үргэлжлүүлэхээс өөр орон зай байхгүй байна л даа. Тэр утгаараа хэрвээ инфляц яг бидний зорьсон тэр 6-8 хувийн түвшинд орж ирэх л юм бол Монгол банкны зүгээс бол мөнгөний бодлогоо зөөлрүүлээд, эдийн засаг руу тодорхой хэмжээний мөнгөний нийлүүлэлт хийгээд явах боломж нь бол тэнд үүсэх юм байгаа юм.

Эвэцийн хувьд бол өнөөдөр Монголбанкны Монгол улсын гадаад валютын нийт нөөц 3,9 тэрбум доллартай тэнцэж байна. Энэ нь өөрөө нийт импортын 5-6 сарын импортыг хангах хэмжээний ийм нөөц байгаа. Ерөнхийдөө бол үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал дотор бол валютын нөөцийг хэр хэмжээнд очвол хамгийн яг боломжит хэмжээ вэ гэж үздэг вэ гэвэл 1 жилийн буюу 12 сарын импортыг хангах хэмжээний нөөцтэй болоход. Тэгэхээр бидний хувьд бол нөөцөө цааши нь нэмэгдүүлэх л ийм зорилтыг тавиад ажиллаж байгаа.

Инфляц сая 10 сард 9, 7 сард бас 9,2 хувь гээд бараг 20 гаруй сарын дараа 2 оронтой тоотой инфляцтай байж байгаад одоо 1 оронтой тоо руу буюу энэ 2023 оны мөнгөний бодлогын үндсэн чиглэлд заасан 1 оронтой тоонд хүргэнэ гэдэг тэр бидний зорилго руу бол орж ирж байгаа юм. Гэхдээ энэ бол өөрөө хэр тогтвортой байх вэ цаашаагаа буугаад яваад 2024 онд баримтлах 6-8 руу очих уу гэдэг нь бол өнөөдөр бас л мөнгөний бодлогоос хамаарах бас зүйл. Гэхдээ зөвхөн Мөнгөний бодлого гэлгүйгээр төсвөөс бас ихээхэн хамаарч байгаа. 1 их наядоор төсөв тэлэхэд бол 1 нэгж хувиар инфляц өсөх ийм дарамт байдаг гэдэг тооцоо судалгаа байгаа учраас ирэх онд бол мэдээж инфляц дээр бол томоохон дарамт байх учраас тэр дарамтыг бууруулах нь Монголбанкны мөнгөний бодлогын зорилго л болчхоод байгаа юм. Тэгэхээр Монголбанкны хувьд бол аль болохоор тэр дарамтыг зөөлрүүлж эдийн засаг руу шингээж зөөлрүүлэх л ийм л даалгавартай л 2024 оны мөнгөний бодлогообол төсөр болсон байгаа юм.

Ирэх жилийн эрсдэлийн хувьд бол ерөнхийдөө манай экспортын 90 хувь нь БНХАУ руу гарч байгаа. Тэгээд тэр утгаараа БНХАУ-ын эдийн засаг өөрөө ямар байхаас бол манай бараа бүтээгдэхүүний нийлүүлэлт бол үнэ хани нь хүртэл хамаарахаар байгаа юм.

Тэгэхээр БНХАУ-ын эдийн засаг өөрөө эдийн засгийн өсөлт сайтай байх юм бол мэдээж манайхаас худалдаж авч байгаа түүхий эд бараа бүтээгдэхүүний үнэ өндөр, хэмжээ бол өндөр байх боломжтой. Нөгөө талдаа манай импортын бас 30 гаруй хувь нь хойд хөршөөс хамаарч байгаа. ОХУ-аас. Тэгэхээр манай 2 хөршөөрөө геополитикийн хувьд бол бусад улстай худалдааны дайн бусад геополитикийн сөргөлдөөнд орохгүй байх юм бол ерөнхийдөө бас хэвийн байх боломжтой. Хэрвээ тийм сөргөлдөөн үүсэх юм бол эргээд бидэнд энэ нь бол давхар дарамт болж ирэх юм байгаа юм. Мөнгөний нийлүүлэлт өнөөдрийн байдлаар 33 их наяд төгрөгт хүрсэн. Өнгөрсөн онтой харьцуулах юм бол 5,7 их наядаар дээр өссөн. Яах вэ энийг бол эдийн засаг судлаачид бол янз бүрээр тайлбарладаг. Ийм хэмжээний мөнгөний нийлүүлэлт нэмэгдсэн байна гэдэг. Энэ бол өөрөө яг ийм хэмжээгээр Монголбанк бол мөнгө хэвлэсэн маягаар тайлбарладаг энэ бол тийм биш. Монгол банк.../минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** Асуултад гүйцээгээд хариулчихъя. Монголбанкны ерөнхийлөгч Лхагвасүрэнгийн микрофоныг өгье.

**Б.Лхагвасүрэн:** Тэгээд 5,7 их наядаар манай гадаад валютын Монгол Улсын санхүүгийн тайлан өөрөө гадаад валютын нөөцөөрөө 5,7 их наядаар өссөн нь мөнгөний нийлүүлэлтийг өсөхөд ингэж нөлөөлж байгаа. Ерөнхийдөө мөнгөний нийлүүлэлт өөрөө дотоод актив, гадаад актив гэсэн 2 том бүрэлдэхүүнтэй. Дотоод актив нь бол зээл, гадаад актив нь нөөц байгаа. Тэгэхээр нөөц өсөхөөр мөнгөний нийлүүлэлт бас өсөж ингэж статистик харагддаг юм.

**Л.Мөнхбаатар:** Дашдондогийн Ганбат гишүүн тодруулж асууя.

**Д.Ганбат:** Та тэр гадаад валютын албан нөөц яг зохистой байх нь

хэчнээн хэмжээний юм бэ гэдгийг нь нэг хэлээд өгчхөөрэй. Нөгөө талаар бол Монгол банкны хийх ёсгүй ажил ямар ямар ажлуудыг хийж байна. Тухайлбал тэр ипотекийн зээлд та нар бол оролцох ёсгүй шүү дээ. Тэрэнд оролцоод явж байгаа юу. Ямар байгаа юм. Энийг бас нэг сонирхчихмоор байх юм. Нэг яг ингээд хэвийн явж байгаа зөв болох гэж байгаа тухайлбал тэр МИК, үнэт цаасжуулдаг энэ бүх юм чинь тэгээд яг тэгж явж байна уу, үгүй юу. Яг зөв яваа юмыг янз бүрийн шүүмжлэл энээ тэрээ юмаар хийж нөгөө попроод ингээд ард түмэнд гайтай ийм ийм зүйлийг эргүүлээд өөрчилдөг ийм юмнууд байна. Энэ чинь цаашидаа яг яаж явах ёстой юм. Та бүхэн тэр мэргэжлийнхээ үүднээс хэлээд өгчих боломж байгаа юу. Нөгөө талаар ОТ мөнгө төгрөг Монголбанкны.../минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** Ганбат гишүүний асуултад нэм хариулъя. Оюутолгойтой холбоотой мөнгөний урсгалыг асуугаад байгаа юм байна. Монголбанкны ерөнхийлөгч Лхагвасүрэн хариулъя.

**Б.Лхагвасүрэн:** Ганбат гишүүний асуултад тодруулаад хариулъя. Ер нь бол олон улсын жишигээрээ бол гадаад валютын албан нөөц 3 сарын импортын хэрэгцээнээс илүү байх ёстой гэдэг. Тэгэхээр бол 3 сарын импортын хэрэгцээнээс бол илүү. Би түрүүн нөгөө 5-6 хувь. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зорилт бол 1 жилийн гэж байгаа. Тэрэндээ бол арай хүрэхгүй байгаа. Тэгэхээр ерөнхийдээ өнөөдөр байгаа 3,9 буюу 4 тэрбум долларын валютын нөөц бол өнөөдөр бол хангалттай нөөц гэж бас хэлж болно. Тэгэхдээ зорилго бол илүү байхаар л ийм зорилго тавиад ажиллаж байгаа.

ОТ-н ерөнхийдөө гэрээгээрээ бол ОТ-н орлогын мөнгө бол Монголын нутаг дэвсгэр буюу Монголын банкнуудаар бол дамжихгүй байгаа. Тэгэхдээ бол 2022 оны зүгээр хамгийн сүүлийн статистик бол 2022 оны ОТ-н борлуулалт нь бол

өөрөө 1,4 тэрбум доллар, гүрний уурхайн бүтээн байгуулалт хэлбэрээр оруулж ирж Монголд хөрөнгө оруулсан мөнгө нь бол 1,6 тэрбум доллар гэдгээрээ ерөнхийдөө нэмэх зөрүүтэй байгаа. Зүгээр.../минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** Тодруулгад нь нэмж хариулъя. 1 минутад багтаагаарай.

**Б.Лхагвасүрэн:** 2022 оны би статистикийг танд хэлсэн. 1,4 нь борлуулалт 1,6 нь бол хөрөнгө оруулалт гэдгээрээ Монгол руу орж ирсэн мөнгө нь илүү байгаа. Энэ оноос эхлээд гүний уурхайн олборлолт эхлээд явж байгаа учраас борлуулалтын хэмжээ нэмэгдэнэ. Ирээдүйд, ирэх ирээдүйд 5 тэрбум долларт хүрэхээр байгаа. Тэр утгаараа бол ерөнхийдөө одоо буцаж манай Валютын зохицуулалтын тухай хуулиар бол 60 хоногийн дотор Монголын банк санхүүгийн салбар эргэж орж ирэх гэдэг утга утгаараа борлуулалт нь хөрөнгө оруулалтаасаа илүү гарсан хэмжээгээр бол зайлшгүй наашаа орж ирэх ийм шаардлага гарч ирнэ.

Ипотек МИК-ийн хувьд бол энэ өөрөө яг үл хөдлөх хөрөнгийг барьцаалж үнэт цаас гаргадаг яг л энэ тогтолцооны зөв схем. Тэгэхээр энэ схемээрээ одоо хүртэл үргэлжлээд явж байгаа. Тэгээд мэдээж Монголбанк өөрөө энэ хөтөлбөрийг авч явж байгаа гэдэг утгаар бол үүнээс арай өөр тийм зүйл гарахгүй байх гэж бодож байгаа юм.

**Л.Мөнхбаатар:** Асуулт асууж хариулт авлаа. Одоо Цагаанхүүгийн Идэрбат гишүүн асуултаа асууя.

**Ц.Идэрбат:** 3 асуулт байна. 1 дүгээрт юмны үнийн инфляцын түвшнийг барихад Монголбанкны зүгээс бодлогын хүүгээ гадаад хүчин зүйлийг бол бас нэлээн тийм сайнгүй байна гээд 13 хувиар батлаад. Энэ ч бас бизнест нэлээн сөрөг үр дагавартай байгаа. Дараагийн шалтгаан инфляцтай холбоотой асуудлуудыг судлаад үзэхээр

манайхны өөрсдийн дотооддоо үйлдвэрлэдэг гурил махны үнийн инфляцад нөлөөлж байгаа үзүүлэлт нь 2 оронтой тоо заримдаа 1 оронтой тоо руу ороод, хальт ороод гараад байгаа энэ инфляцад маш их нөлөөлж байгаа юм байна лээ шүү дээ. Тэгэхээр Монголбанкны зүгээс дотооддоо нөлөөлөөд байгаа инфляцын түвшнийг барихад дотооддоо үйлдвэрлэдэг гурилын махны нийлүүлэлт юмнууд дээр зохицуулалт хийхэд эсвэл зохиомол үнийн хөөрөгдөл үүсгээд байна уу, үгүй юу гэдэг дээр ШӨХТГ, энэ Засгийн газартай хамтарч ажиллах ер нь арга зам байгаа юу. Гурилын үнэ нь даблдаад өсчихөөр чинь инфляц нь дагаад өсчихөж байгаа. Тэр чинь тэгээд л боов боорцог юу байдаг юм. Бүх юм нь өсчхөөд байгаа шүү дээ. Тэгээд инфляц нь нэмэгдээд байна гээд ганц Монголбанк руу тэр нь бас хаяглагдаад байгаа юм шиг юм анзаарагдаад байгаа байхгүй юу. Тэгэхээр би бол ирэх онд энэ 2024 онд инфляцыг барихын тулд Монголбанк үндсэн үйл ажиллагаанаасаа гадна Засгийн газартай хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах байдаг юм уу, ШӨХТГ-тай ажиллах ийм төлөвлөгөө юмнууд бас байгаа юу гэж 1 дүгээрт асуумаар байна.

2 дугаарт одоо энэ ипотекийн зээлийн асуудал. Одоо хэдхэн хоногийн өмнө төсөв батлахдаа ялангуяа нөгөө орон нутагт ипотекийн зээлийн хүртээмжийг нэмэгдүүлнэ гээд заачихсан. Би орон нутгаас өөрийнхөө сонгогдсон аймгаа судлахад аймгийн төв дээр арилжааны 4 банкнаас сардаа 10-аад ипотекийн зээл гарч байна гэж байгаа байхгүй юу. Тэгвэл одоо нөгөө ипотекийн зээлийн хүртээмжийг нэмэгдүүлнэ гээд заагаад өгөхөөр энэ ипотекийн зээл маань орон нутагтаа илүү гарч чадах уу. Өнөөдөр улсын хэмжээнд хэдийг өгөөд байгаа юм. Ирэх жил хэдийг өгнө гэж төлөвлөж байгаа юм. Тэндээс хэдийг нь орон нутаг руу өгнө гэж ингэж төлөвлөж байгаа юм бэ

гэдэг дээр би тодорхой тоо бас сонсъё гэж ингэж бодож байгаа юм.

Нөгөө талдаа ипотекийн зээлийн эргэн тойронд нь маш их олон хүмүүс худал үнэн нь мэдэгдэхгүй, болох болохгүй нь мэдэгдэхгүй маш олон зүйлийг бас ингэж мэдэгдлүүд хийх юм. Энэ нь орон нутагт очихоор олон хүнд бас хүлээлт үүсгэх юм. Тэдэн хувь болох юм гэнэ, ингэх юм гэнэ, тэгэх юм гэнэ гээд. Тэгэхээр Монголбанк энийг хариуцаж байгаа гол төрийн байгууллагын хувьд бас нэг тодорхой хэрвээ өөрчлөх бол хугацаатай, өөрчлөхгүй бол өөрчлөхгүйтэй нь хэлэхгүй бол олон хүний сэтгэл санааг үймүүлсэн ийм юм яваад байна.

3 дугаарт би бол бас Монголбанкны дотоод үйл ажиллагаатай холбоотой байж магадгүй. Ер нь 1 хувийн зээлийн хураамжийн шимтгэлийг авахыг зөв үү, буруу юу гэж би өнгөрсөн жил бас асууж байсан. Яг бас тодорхой хариулт авч чадаагүй. Гэхдээ өнөөдөр шүүхийн процессоор харахаар 1 хувийн хураамжийг авах нь буруу юм гэсэн ийм шийдвэр гарсан гээд энэ сошиалаар дүүрэн явж байна шүү дээ. Яг үүнтэй адилхан Банкны тухай хууль дээр бас урт хугацаанд авч байгаа зээлийн хүүг нь түрүүлж аваад байна гэдэг гомдол иргэдийн дунд маш их байгаад байна. Энийг бүр асууж өгөөрэй гэсэн. Хүүг нь түрүүлж аваад 2 жил төлчхөөд байхад яг үндсэн зээлээсээ хэдхэнийг төлчихсөн байна. Гэтэл банкны хууль дээрээ энэ нь бол хориотой гэсэн ийм зүйлийг бас ард иргэд маш их яриад байдаг юм. Тэгэхээр би энэ 3 асуултад бас та бүхнээс тодорхой хариулт авъя гэж бас бодож байна.

**Л.Мөнхбаатар:** Идэрбат гишүүний асуултад хариулъя. Хэн хариулах вэ. Монголбанкны Ерөнхийлөгч Лхагвасүрэн хариулъя.

**Б.Лхагвасүрэн:** Идэрбат гишүүний асуултад хариулъя. Ер нь яах вэ, өнөөдөр бид нар бодлогын хүү өндөр байгаа. Тэгээд энэ нь өөрөө нийлүүлэлтийн шинжтэй инфляцад нөлөөлж чадаж байгаа юм уу гээд байна. Яах вэ, бид хэд ер нь бол Монголбанк өөрөө яаж энэ зургийг харж байгаа вэ гэхээр төсөв ингээд тэлчхэж байгаа. Төсөв энэ оны 6 сард тодотгол хийж 1,8 их наядаар өссөн. Тодорхой хэмжээний цалин, тэтгэвэр тэтгэмж нэмэгдээд явсан. Тэгээд 7 сард 9,2 хувьтай байсан инфляц 8 сард 10 хувь руу ороод өсөөд явж байгаа. Тэгээд ерөнхийдөө ингээд өөрөө өдөөгдөж байгаа инфляц өөрөө бий болоод явна. Монголбанкны зүгээс бол яаж энийгээ харж явдаг вэ гэхээр эрэлтийн шинжтэй 2 дахь давлагааг бий болгохыг л хамгаалах гэж байгаа юм. 2 дахь давлагаа гэдэг маань цалин тэтгэврээр дамжаад дахиад инфляц бий болох вий. Тэгэхэд тэр үүднээсээ бодлогын хүүгээ өнөөдрөөс хатуу явж байгаа нь өөрөө л тэрэнд л зориулсан. Тэрнээс биш яг гурилын нийлүүлэлт тухайн нэг бүтээгдэхүүний нийлүүлэлттэй холбоотой ямар нэг зохицуулалт бол хийж чадахгүй байгаа. Зүгээр яг энэ оны хувьд Монголбанкны хувьд бол Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан Хүнсний хувьсгал, хүнсний аюулгүй байдлын хүрээнд Хүнс, хөдөө аж ахуйн яамны энэ оны төсөв дээр 125 тэрбум төгрөгийн хүүгийн хөнгөлөлт суучихсан байсан. Энэ хөнгөлөлтийн хүрээнд энэ жил бол газар тариалан эрхлэгч хүнсний ногоо тариалдаг бас хүнсний бүтээгдэхүүн үйлчилгээ үйлдвэрлэлүүдэд зориулж хүүгийн татаастай ийм зээлийг гаргасан. Одоо нийт гаргасан зээлийн хэмжээ 650 тэрбум төгрөгт хүрээд байж байгаа. Ерөнхийдөө 125 тэрбум төгрөгөөр бол бараг 1 их наядын зээл гаргах ийм боломжтой. Ийм хүүгийн хөнгөлөлтөөр. Тэгэхээр бол хөтөлбөрийн үр дүн гарсан гэж ерөнхийдөө харж байгаа. Өчигдрийн Засгийн газрын хуралдаан дээр үр тариагаараа Монгол улс төмсөөрөө Монгол Улс өөрийгөө 100 хувь хангахаар

хүнсний ногоогоор 85 хувь хангахаар ийм хэмжээний ургац хурааж авлаа гэдэг маань энэ бодлогын Хүнс, хөдөө аж ахуйн яамны төсөв дотор ийм хүүний хөнгөлөлтүүд бол суугаад явж байгаа гэж мэдээ тайлан манайд ирсэн байгаа. Энэ утгаараа бол яг энэ хөтөлбөр өөрөө цаашаа энэ байдлаараа үргэлжлэх боломжтой гэж харж байгаа юм.

Ипотекийн зээлийн хувьд ипотекийн зээл өөрөө ийм онцгой бусад зээлээс өөр бүтээгдэхүүн 30 жилийн хугацаатай авдаг. Тэгээд 30 жилийн хугацаатай авсан зээлээ 30 жилийнх нь хүүг нь бодоод нийлбэр дүнг нь гаргаад, тэгээд сар болгон тэнцүү төлөхөөр хуваачихдаг. Тэр утгаараа хүү нь өнөөдөр авч байна уу, хүүг нь дараа нь авч байна уу, үндсэн өрийг нь одоо авч байна уу, дараа нь авч байна уу гэдэг нь бараг ялгаа байхгүй болчхож байгаа юм. Яагаад гэвэл 30 жилийн хугацаанд тооцоод бүгдийг нь тэнцүү хуваачхаж байгаа учраас. Тэгэхлээр яах вэ, банк бол авч байгаа. Сар болгон авч байгаа тэр нөгөө тэнцүү төлбөрөө хүүдээ суутгаж байна уу, үндсэн өрөөсөө суутгаж байна уу гэдэг нь бол бараг 30 жил үргэлжлэхэд бол ялгаагүй шахуу л болчхож байгаа юм. Энэ өөрөө нөгөө тэр санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээнийх нь онцлог болчхож байгаа юм.

Шимтгэлийн 1 хувийн хувьд бол яах вэ, хуулиараа банк бол зээл олгохдоо судалсан, тодорхой тооцоо, үндэслэлээр бол шимтгэл авах эрхтэй. Ипотекийн зээлийн хувьд бол Монголбанк болон Санхүүгийн зохицуулах хорооны хамтарсан юугаар бол 1 хувиас илүүгүйгээр авахаар ийм дээд хязгаар нь л тавьж өгсөн. Дээд хязгаар тавьсан гэдгээрээ 1 хувийн шимтгэл гээд дээд талынхаа л хязгаарааравч байгаа юм. Тэгээд энэ дээр нь Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газраас бол улсын байцаагч бол шимтгэл авсан нь буруу байна гэдгээр торгууль тавиад, торгуультай холбоотой маргаан нь шүүх дээр шийдэгдсэн юм байна лээ. Тэрнээс

биш хууль, эрх зүйн хувьд бол банк өөрөө хуулиараа ийм шимтгэл авах эрхтэй л гэсэн ийм зохицуулалт байдаг юм.

**Л.Мөнхбаатар:** Тодруулж асууя. Идэрбат гишүүн.

**Ц.Идэрбат:** Лхагваа ерөнхийлөгч өө, та миний хэдэн асуултыг хооронд нь бүр хольж солиод бантан болгоод хаячихлаа.

1 дүгээрт бол би тэр юмны үнийн өсөлтөд нөлөөлөөд байгаа дотоодын хүчин зүйлийг багасгахад Монголбанк бусад төрийн байгууллагатай хамтарч ажиллах бололцоо байгаа юу л гэсэн шүү дээ. Тэрнээс би тэр Ерөнхийлөгчийн дэвшүүлсэн хүнсний хувьсгал үр дүнгээ өгч байгаа гэдгийг мэдэж байгаа. 1 дүгээр асуулт.

2 дугаарт 2023 онд ипотекийн зээл хэдийг олгожхов. Ирэх онд төсөв дээр нэмнэ гээд заачихсан байгаа. Орон нутаг руу арай ахиу өгнө гэсэн. Тэгэхээр өнөөдөр аймагт сардаа 10 хэдийг олгож байгаа юм билээ. Энэ нь нэмэгдэх үү л гэж асуусан юм шүү дээ.

3 дугаарт энэ банкнууд урт хугацааны бизнесийн зээлийг эргэн төлөлт дээрээ хүүг нь урьдчилж аваад байна гэдэг гомдлыг иргэд их ярьж байна. Энэ нь банкны хуулиараа хориотой юм биш үү. Ийм 3 асуулт л үндсэндээ асуусан шүү дээ би танаас.

**Л.Мөнхбаатар:** Асуултад тодорхой хариулъя. Лхагвасүрэн Ерөнхийлөгч хариулъя.

**Б.Лхагвасүрэн:** Идэрбат гишүүний асуултад тодорхой, товчхон хариулъя. Ерөнхийдөө Монголбанк өөрөө нөгөө Төв банкны хуультай. Тэр хуультай учраас бол хуулийн хүрээнд бол оролцож болно, оролцож болохгүй бүх зүйлийг зохицуулаад байдаг учраас бол бид хэд шууд нийлүүлэлтийн юман дээр оролцоод явахад бол хориотой болчхож байгаа



юм. Хувь иргэн, ААН тухайн салбарт бол тухайлсан бодлого явуулж болохгүй гээд заачихсан учраас ипотекийн зээлийн хувьд бол яах вэ, одоо энэ онд бол тодорхой хэмжээнд өгөөд надад тоо байна л даа. Хэнтий аймагт бол нийтдээ энэ оны хэмжээнд 2 тэрбум 400 сая төгрөгийн ипотекийн зээл олгосон байна. 34 иргэн хамгийн сүүлийн 7 хоног гэхэд 3 иргэн орон сууцын зээл авсан байна гэдгээр явж байгаа юм. Тэгээд ер нь бол ипотекийн зээл бол энэ ондоо бол хэвийн чигээрээ үргэлжлээд явна. Ирэх онд бол төрийн мөнгөний бодлогын үндсэн чиглэл дотор ажлын хэсгээс ийм зарчмын зөрүүтэй саналын томъёолол оруулсан. Орон сууцын ипотекийн.../минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** Идэрбат гишүүний асуултад нэмж хариулъя. Ажлын хэсгийн ахлагч Чинбатын Ундрам хариулъя. Гишүүд танхимдаа орж ирээрэй. Санал хураалт явагдана.

**Ч.Ундрам:** Бид нар ажлын хэсэг дээр ярьж байгаад ипотекийн зээлтэй холбоотой олгох зээлийн нийт эх үүсвэрийг нийслэл, орон нутагт тэнцүү хуваарилах гэж зааж байгаа юм. Тэгэхээр өнөөдөр ерөнхийдөө 10 хэдэн хувь нь орон нутагт, тэгээд 80 гаруй хувь нь нийслэл Улаанбаатарт олгогдож байгаа зээл нь одоо 2024 онд 50 хувь нь орон нутагт олгогдоно гэсэн үг. Тэгээд энэ нь санхүүжих эх үүсвэр нь зээлийн эргэн төлөлтөөс учраас ойролцоогоор Монголбанк дээр 500 тэрбум төгрөг эргэн төлөлт орж ирж байгаа. Арилжааны банк дээр 120 тэрбум төгрөг. Тэгэхээр 620 тэрбум төгрөгийн 50 хувь нь орон нутагт олгогдоно гэсэн үг болж байгаа юм. Тэгэхээр ипотекийн зээлтэй холбоотой байна. Инфляцад нөлөөлж байгаа гурил, мах, сүүний үнэтэй холбоотой бид нар бас ажлын хэсэг дээр яригдаж байгаа юм. Энэ нь Хүнс, хөдөө аж ахуйн яам дээр одоо сүүлийн 30-аад жил маш олон төсөл хөтөлбөрүүд хэрэгжсэн. Тэгэхээр бид нар мах, гурил, сүү.../минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** Улсын Их Хурлын гишүүн Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ асуултаа асууя.

**Б.Бат-Эрдэнэ:** Баярлалаа. Би Монголбанкнаас 3 тодорхой асуудал тавья гэж. Яах вэ, Миний хувьд Их Хуралд сонгогдож ажилласан 2004 оноос хойш Монгол Улсын үйлдвэржилтийн түвшнийг дээшлүүлэхтэй холбоотой санал санаачилгуудыг гаргасаар ирсэн ийм хүн л дээ. Тухайлах юм бол 2006 онд Өвөрмонголын өөртөө засах орон Ордос нутагт явж байгаад нүүрсийг бүрэн боловсруулах, нүүрс химийн үйлдвэрүүдтэй танилцаад энэ талын асуудал дэвшиүүлсэн. Тэгээд энийг ажил хэрэг болгоогүй. Дараагаар нь 2014 онд Латин Америкийн хэд хэдэн орнуудаар тухайлах юм бол ХАА тэр дундаа МАА өндөр хөгжсөн ийм улс орнуудаар яваад тэгээд үзсэн харсан Монгол Улсын төрийн бодлогод Монголын минь ард түмэнд аж ахуй, бизнес эрхлэгчид хэрэгтэй, тустай байж болох ийм саналуудыг аян замын тэмдэглэл бичээд, төвийн хэвлэл мэдээллээр хүргээд, төрийн бодлогод тусгуулахаар санал санаачилга гаргаад ингээд ажилласан. Тэгээд өнөөдрийг хүртэл Монгол Улсын үйлдвэржилтийн бодлого нэг иймэрхүү түвшинд яваад байгааг зүгээр Монголбанкны зүгээс юу гэж дүгнэдэг юм бэ. Ямар үнэлэлт өгдөг юм. Энэ дээр нэг хариулт өгөх бололцоо байх уу, үгүй юү. Та бол бас өмнөх жил төрийн мөнгөний бодлогыг оруулж ирж Их хурлаар хэлэлцүүлэх үеэр бид бас тодорхой ярилцаж байсан. Тухайлах юм бол нэг ийм загвар бизнесийн моделийг бол нэг бүрэн хэмжээнд хөгжүүлэхээр ийм төсөл хэрэгжүүлж байгаа. Тухайлах юм бол Монгол ноолуурыг яг малчны хотноос нь ямааны үүлдэр угсааг сайжруулахаас өгсүүлээд, тэгээд боловсруулалтын бүх шат дамжлагуудыг дамжуулаад ингээд өөрөө эцсийн хэрэглэгч тэр гадаадын томоохон компаниудад хүргэх цогц загварыг нутагшуулна, яг ажил болгоно. Монгол банк гардана гэж байсан. Тэгээд энэ бас

тодорхой үр дүнд хүрээд явж байгаа болов уу гэж бодож байна. Гэх мэтчилнээр нэг үйлдвэржилтийн үйлдвэр бий болгох, үйлдвэржилтийг хөгжүүлэхтэй бодлого дээр ямар санаачилга байна. Энэ чинь аж ахуй бизнес эрхлэх гэж байгаа хүмүүст бол бага хүүтэй, урт хугацаатай ийм санхүүгийн дэмжлэг бол асар их дутагдаж байна шүү дээ. Нэг ийм юм хэлэх гээд байгаа юм.

Дараагийнх нь нэг юм юу ярих гээд байна вэ гэхээр зэрэг мөнгө хэвлэж зах зээлд нийлүүлдэг бодлоготой холбоотой юмыг та бүр тоо байдлаар хэлж болох уу, үгүй юү. Одоо чинь энэ нэг сонгууль дөхчихсөн учраас энэ хүмүүс чинь улс төрийн өнгө аясаар ард түмнийг ерөөсөө их богино хугацаанд юм мартчихдаг гэж ойлгоод байх шиг байгаа юм. Энэ чинь ард түмэн мартаггүй шүү дээ. Хэзээ ч мартаггүй. 2012-2016 онд улс орны эдийн засагт бий болсон жоохон нааштай өөрчлөлтийг яаж тухайн үед эрх барьж байсан нөхдүүд талаар болголоо. Ард түмэн мартаагүй. Асар их хэмжээний мөнгө хэвлээд тухайн үед валютын ханиш 1300, 1400 төгрөг дээр байсан. Ингээд одоо мөнгөний буруу бодлого авч хэрэгжүүлсний үр дүнд юу болсон билээ. Валютын ханиш шууд одоо 2700, 2800 төгрөгт л хүрсэн шүү дээ. Гэтэл энийг ерөөсөө олон түмнийг мартчихсан юм шиг ийм юм яриад байх юм. Тэгээд эдийн засгийн жаахан боломжтой энэ үнэлгээ гайгүй байгаа ийм нөхцөлд бол Монголын одоо төр ард түмнийг улсаа тэр чигээр нь барьцаалж байгаад, богино хугацаатай арилжааны хөгжлийн биш арилжааны Чингис сайхан нэртэй бондууд авчраад зүгээр бүлэг фракцаараа хуваагаад авцаагчихсан шүү дээ.../минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя. Ажлын хэсгийн 83 дугаар микрофоныг өгье.

**Б.Лхагвасүрэн:** Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя. Ноднин бас

өнгөрсөн оны төрийн мөнгөний бодлогын энэ онд хэрэгжих мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх явцад бид эхнэ танилцуулгыг хийж байсан. Монголбанк анх удаагаа Олон Улсын санхүүгийн корпораци хамтраад үйлдвэрлэлийн нийлүүлэлтийн сүлжээ гэдгээрээ ийм бүр тайлбар толь бичиг гаргасан. Дээр нь нийлүүлэлтийн сүлжээ гэж ямар ойлголт байдаг юм. Олон улсад хэрэглэдэг байдлаар нь гаргаж ирээд ноолуур гээд бүтээгдэхүүн дээр ноолуурыг цагаан алт гэж нэрлээд сүлжээгээ үүсгэсэн. Тэгээд 10 мянган тонн түүхий ноолуур боловсрогдоод, угаагдаж 7 мянга, самнагдаж 5 мянган тонн гээд энэ бүх шат дамжлагын дараа өртөг нь яаж өсөж байна. Яаж нэмүү өртөг бий болж байна гэдгээрээ тооцоо хийчихсэн биз. 1,4 тэрбум доллар болохоор ийм тооцоо хийсэн. Монгол банкны зүгээс бол шууд тухайн үйлдвэр, аж ахуйн нэгжид зээл гаргаж болохгүй гэдэг утгаараа арилжааны банкаар дамжуулаад repo санхүүжилтийнхээ хүрээнд бол энийг хэрэгжүүлээд явсан. Тэгээд үр дүн бол гарсан. Тодорхой үр дүн гарахаас гадна ноолуурын салбар бол өөрөө бараг бие дааж санхүүжилтээ босгох ийм боломжтой хэмжээнд ирчхээд байгаа. Европын сэргээн босголт хөгжлийн банк, Олон улсын санхүүгийн корпораци өөрөө сүлжээ рүү бас орж эхэлсэн. Ялангуяа Хас, Хаан банкаар дамжуулаад энэ 2 банкны нэр дээр бараг 300-аад сая доллар орж ирээд ноолуурыг санхүүжүүлээд явж байгаа юм. Бидний хувьд бол бас дараагийн бүтээгдэхүүн ч байдаг юм уу, тодорхой хэмжээнд ялангуяа энэ хүнсний хувьсгал гэж яригдаж байгаа үед хүнсний бүтээгдэхүүний ногоог ургуулаад, зооринд хадгалах дараа нь тэгээд эцсийн бүтээгдэхүүн болж эцсийн хэрэглэгч дээр очих хүртэлх басн ийлүүлэлтийн сүлжээг бас зураад явж байгаа. Тэгэхээр ирэх 2024 оны мөнгөний бодлогынхоо үндсэн чиглэл дотор нийлүүлэлтийн сүлжээгээ илүү олон бүтээгдэхүүн гаргахаар л яаж байгаа юм. Тэрнээс биш яг Төв банкны тухай хуулиар манай

Монгол банкны тухай хуулиар бол тухайлан бүтээгдэхүүн тухайлан иргэнтэй Монголбанк шууд харьцаж явах гэдэг утгаараа нийлүүлэлтийн сүлжээгээр нь дамжуулж нөгөө санхүүжилтийн арга хэлбэрийг орох энэ ажлаа хэрэгжүүлээд явж байгаа. Одоо харин энэ дээрээ бид нар цаашаагаа Монголбанкны статистик судалгааны газар дээр их өгөгдлийн сан буюу энд бүтээгдэхүүн, үйлчилгээ дээр хэн оролцдог юм, ямар хэмжээнд оролцох юм, ямар мөнгө хөрөнгө шаарддаг юм гэдгээрээ бас ийм том өгөгдлийн сан үүсгээд явж байгаа. Дараа нь энэ дээрээ үндэслээд дараагийн бодлого шийдвэр гаргах ийм санаачилгыг гаргана гэж бодож байгаа.

**Г.Занданшатар:** Содномын Чинзориг гишүүн алга байна. Хасъя. Цогтгэрэл гишүүн алга байна. Хасъя. Пүрэвдорж гишүүн алга байна. Хасъя. Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн. Дараа нь санал хураалттай. Гишүүд чуулганы танхимд цуглаарай.

**Б.Бат-Эрдэнэ:** Тэгээд би түрүүн цаг багатай байгаа учраас үргэлжлүүлээд асууя л даа. Тэгэхээр Монгол Улсынхаа эдийн засгийн жаахан боломжтой энэ цаг үеийг ашиглаад л үрэн таран хийчихдэг. Энэ бол 1990 оноос хойш 30 жилийн хугацаанд 2 удаа давтагдсан. 1992-1996 онд Жасрай гуай Засгийн газар тэргүүлж байхдаа эдийн засагт жаахан гэрэл гэгээ, хонгилын үзүүрт гэрэл гээд гарлаа, онгоцны хошуу дээшээ боллоо гэж байсан. Тэгээд юу боллоо бид нар мэдэж байгаа. 2000-2012 он хүртэл Монголын төр, ард түмэн зүтгэж байгаад нэг жоохон бололцоо гаргаад ирсэн 2012-2016 онд энийг зүгээр шороотой хутгаад орхисон шүү дээ. Би түрүүн хэллээ. Том зээл бондуудыг бүлэг фракцаар хуваагаад авчихсан. Энэ чинь нууц биш шүү дээ. Харамсалтай нь энэ хүмүүст хариуцлага тооцож чадахгүй өнөөдрийг хүрч байгаа. Үүний зэрэгцээгээр манай Ардын намаас хүмүүс зээл бондод орчихсон.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн гүйцээж асууя.

**Б.Бат-Эрдэнэ:** Тэгээд зээл бондоос нь очоод авчихсан. Өөрсдөө хэлэх тайлбаргүй байгаа юм. Тэгээд олон түмнийг бас амжлаад байгаа юм уу, одоо ингээд ийм нөгөө ярьдаг загасны ой санамжтай гэдэг шиг тэгж ойлгоод байгаа юм уу. Одоо хот хөдөөгүй өргүй Монгол гээд ийм юм зарлаад яваад байна гэж байна. Энэ чинь нөгөө төрийн ой санамж гэдэг шиг бид нар 5 удаа сонгогдож ажилласан 4, 5 сонгогдсон хүмүүс чинь бид нар энийг сайн мэдэж байна шүү дээ. 2012-2016 онд чинь юу болоод өнгөрлөө гэдэг шиг. Би түрүүн валютын ханшийг яаж нэг нугалаад алдсан тухай хэлсэн.Өнөөдөр энэ өр зээлийг тавиад ийм арилжааны бондуудыг аваад хуваагаад авчихсан өнөөдрийг хүртэл өр зээлийг нь дарж чадаагүй иймэрхүү л байдалтай явж байгаа шүү дээ. Тэгээд түрүүн миний асуулт дээр дахиад хэлж өгөхөд энэ улс орноо өөрөө дотооддоо юмаа үйлдвэрлэдэг болгоход үйлдвэржилтийн бодлогыг Монголбанк төрийн мөнгөний бодлогоор яаж дэмжих юм. Бага хугацаатай, бага хүүтэй, урт хугацаатай зээл олгохоос өгсүүлээд энэ бодлого дээр нэг тодорхой ямар юуг Засгийн газартай хамтарч хэрэгжүүлэх юм. Хувийн аж ахуйн нэгж энэ баялаг бүтээгчдээ хэрэгжүүлж ямар бодлого хэрэгжих юм бэ. Ингэхгүй бол энэ чинь ерөөсөө явж өгөхгүй байна шүү дээ.

**Г.Занданшатар:** Хэн хариулах вэ. Бядрангийн Лхагвасүрэн. 83. Одоо санал хураалттай гишүүд чуулганы танхимд цуглаарай.

**Б.Лхагвасүрэн:** Бат-Эрдэнэ гишүүний асуултад тодруулаад нэмж хариулъя. Яах вэ, Төрийн мөнгөний бодлогын үндсэн чиглэл дотор бол бид нар яг тухайлан иргэн, аж ахуйн нэгж салбарыг дэмжих ийм бодлого явуулах нь бол хуулиараа хориотой байдаг учраас

бол яг тэгж зааж чадахгүй байгаа юм. Бидний хувьд бол одоо арилжааны банк дээр байгаа чөлөөтэй эх үүсвэр бүрээр буюу яг Монголбанкны үнэт цаасан дээр 6 их наяд төгрөг байна. Энэ 6 их наяд төгрөгийг нэгэнт эдийн засагт гарчихсан мөнгө гэдэг утгаар нь эргээд эргэлтэд оруулах л тэр хөшүүргийг хэрэглэх гэж байгаа юм. Тэр утгаараа түүрүүн би Идэрбат гишүүний бас асуултад хариулж байхдаа хүнсний хувьсгалын хүрээнд бол 650 тэрбум төгрөгийн зээл олгогдсон байна. 19 хувийн хүүтэй зээл авч байгаа аж ахуйн нэгжид 13 хувийн хүүгийн хөнгөлөлт үзүүлээд 5-6 хувийн хүү төлөөд аж ахуйн нэгж хүнсний хувьсгалын хүрээнд аваад явж байгаа. Энэ хүрээндээ бас Хүнс, хөдөө аж ахуйн яамтай бас 2024 онд энэ хөтөлбөрөө яаж ямар хэмжээнд үргэлжлүүлэх вэ гэдгээрээ ялангуяа малын гаралтай түүхий эдийг боловсруулах хэсэг дээр нь бас тодорхой хэмжээний .../минут дуусав/

### **Г.Занданшатар:**

Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн. Санал хураалт явуулъя. Санал хураалт. Гишүүд чуулганы танхимд цуглъя.

**Б.Бат-Эрдэнэ:** Баярлалаа. Би танаас асуугаад байгаа вэ гэхээр, тэр хуульд заачихсан хаалттай байгааг ойлгож байгаа. Гэхдээ энэ чинь Монголбанкнаас баримталж байгаа бодлого чинь хэр нийцэж байгаа юм бэ. Төрийн мөнгөний бодлогын хүү Монголбанкнаас баримталж байгаа бодлогын хүү гэхэд чинь 13 хувьтай байж байгаа. Арилжааны банкнууд зээл олгоно гэхээр чинь бараг 20 шахаж олгох байлгүй. Энэ чинь зөрчилдөөд байна. Миний хэлээд байгаа бага хүүтэй, урт хугацаатай ийм хөгжлийн зээлийг олгох арилжааны банкнууд, хувийн аж ахуйн нэгж, бизнес эрхэлж байгаа байгууллагууд, түүнчлэн Засгийн газртай хамтраад энэ бодлогыг хэрэгжүүлж байж бид нар үйлдвэржилтийн энэ унасан түвшнийг яаж дээшлүүлэх вэ гэдэг юмыг л хэрэгжүүлэхгүй бол үүний

цаад талд чинь үйлдвэр байгуулна дотоодын хэрэгцээгээ хангана. Нөгөө гадаадад экспорт, импортод гадаадаас оруулж ирж байгаа импортын асар их валют чинь хэмнэгдэнэ, ажлын байр бий болно, орлоготой болно, нөгөө ипотекийнхоо авсан зээлийг.../минут дуусав/

### **Г.Занданшатар:** Үг байхгүй.

Санал хураалт. 6 санал хураалттай. Энэ чинь хэлэлцэх эсэх биш. Сая санал хэллээ. Бөхчулууны Пүрэвдорж гишүүн. Санал хураалт явуулна.

### **Б.Пүрэвдорж:** Өнөө өглөө би

news.mn-ээс Амаржаргал Ерөнхий сайд асны Монголбанканд илгээх ил захидал гээд энийг уншсан. Тэгэхээр ер нь бол гол агуулга бол төсөв бол за жоохон замбараагүй, нэлээн змбараагүй батлагдчихлаа. Тэгээд эдийн засагт бол маш их мөнгө үр, үр ашиггүй зарцуулах ийм нөхцөл байдал руу орчихлоо. Энэ дээрээ Монголбанк хариуцлагатай ажиллах, та нарт л найдах үлдлээ л гэж ингэж бичсэн байна лээ. Тэгээд энэ дээрээ аль болох тийм улс төржихгүйгээр асуудал шийдэхийг л та бүхэнд сануулсан байна лээ. Тэгэхээр улс төржсөний нэг жишээг би бол та нарт хэлье л дээ. Улс төрч нөхөр Монголбанканд очихээр яадгийг би хэлж өгье. Баяртсайхан гэдэг нөхөр Монголбанкны Ерөнхийлөгч болонгуутаа 2016 онд тэгээд яасан бэ гэхээр нөгөө своп хэлэлцээрийн тэр долларыг хасаад, ер нь бол Монголбанкны валют хасах руугаа орчихлоо гэж мэдэгдэл хийгээд, тэр нь яах вэ дээ 2016 оны 2010-2016 оны Монгол банкны үйл ажиллагаа, эдийн засгийн үйл ажиллагааг шүүмжлэх маягтай намдаа хэрэгтэй л тийм мэдэгдэл хийсэн юм шиг байгаа юм. Тэгээд тэрний үр дүнд яасан бэ гэхээр гэнэтхэн огцом 500 төгрөгөөр ханиш унаад, маш тийм асуудалтай нөхцөл байдал руу яг 2016 онд орж байсан байхгүй юу. Тэгээд ер нь бол энэ маш их тийм ханиш уналтын гол нөлөөлөл бол улс төрчийн мэдэгдэл байдаг. Тийм учраас

Монголбанкны Ерөнхийлөгч болон түүний багийнхан бол тийм улс төрчдийн баг байх юм асуудалд ордог юм байна гэдэг нь эндээс харагдаж байсан. Тэгэхлээр одоо бол Монголбанкны бүрэлдэхүүн бол нэлээн мэргэжлийн ийм баг байгаа. Тэгэхээр гол асуудал ямар асуудал байна вэ гэхээр ирэх жилийн төсөв дээр 6,2 их наяд төгрөгийн хөрөнгийн зардал байгаа. Тэрний 3,2 нь бол төсвийн хөрөнгө оруулалт байж байгаа. Дээрээс нь 3 их наяд болохоор яам, Тамгын газар дээрээс нь орон нутаг руу өгч байгаа хөрөнгийн зардлууд өөрөөр хэлбэл энэ чинь хөрөнгө оруулалт гэсэн үг. Ингээд 6,2 их наядын чинь нийтдээ 80 хувь буюу 5 их наяд нь урагшаа одоо бараа бүтээгдэхүүн авахаар урагшаа хамаг хөрөнгө нь урсана. Дээрээс нь 21 их наяд төгрөгийн урсгал зардал гарч байгаа. Тэрний 11 их наяд нь дахиад бид нар нөгөө үйлдвэрлэгч орон биш учраас импортлогч орон учраас бас дахиад баахан урсгал урагшаа гарах юм байна. Нийтдээ 4,5 их наяд, 4,5 тэрбум долларын валют урагшаа урсах нь л дээ. Энэ чинь тэгээд бараг танай тэр байгаа бүх валюттай чинь тэнцэж байгаа. Тэгээд ийм нөхцөлд бол ханиш уналт асар өндөр явагдана. Төсөв их тэлсний үр дүнд ямар нөхцөл байдал гарсан бэ гэхээр, бараа бүтээгдэхүүний үнэ маш их өндөр өсөж байгаа. Жишээ нь, өнгөрсөн жилийн 2 сарын 1-нд 50 мянган төгрөг байсан гурил өнөөдөр 120 мянган төгрөг болоод, 140 хувиар өсчихсөн байж байна шүү дээ. Тэгээд гурил бол танай гол нэрийн сагсанд байдаг бүтээгдэхүүний нэг. Гэтэл баруун аймгийн хүмүүс цаад талын Горний Алтайнутгаас 1 шуудай гурилыг 57 мянган төгрөгөөр авч хэрэглэх ийм боломж нь тэнд байж байна. Тэгээд ийм ийм зүйлүүд чинь ерөөсөө энэ бараа бүтээгдэхүүний үнэ өсгөхөд, ханиш уналтад нөлөөлөхөд дээрээс нь инфляцыг хөөрөгдөхөд хамгийн гол нөлөөлөл үзүүлээд байгаа.

**Г.Занданшатар:** Хэн хариулах юм. Бядрангийн Лхагвасүрэн Монголбанкны ерөнхийлөгч.

**Б.Лхагвасүрэн:** Пүрэвдорж гишүүний асуултад хариулъя. Ирэх 2024 оны төсөв бол 20 хувиар тэлэлттэй том төсөв явж байгаа. 2023 онд бол хөрөнгө оруулалт байгаагүй бол 2024 онд бол бас хөрөнгө оруулалт байгаа. Тэгээд ер нь бол төсвийн хөрөнгө оруулалттай хэсэг дээр бол импорт бол нэлээн идэвхждэг. Энийг бол Монголбанк бол сайн ойлгож байгаа. Өнөөдөр Монгол Улсын валютын нөөц 3,9 тэрбум долларт хүрчихсэн байгаа. Энэ оны экспорт яг 3 дугаар улирлын байдлаар, экспорт нь импортоосоо ер нь 3 тэрбум доллароор даваад явж байгаа энэ үед бол төлбөрийн тэнцэл өөрөө 700 сая долларын ашигтай байгаа гэдэг утгаараа энэ төсөөллөөрөө бодох юм бол ерөнхийдөө бас ер нь Монголбанкны зүгээс бол мөнгөний бодлогоор бол энэ дээр нөөц дээрээ ч тэр, ханиш дээрээ ч тэр ямар нэг тогтворгүй байдал үүсэхгүй байх л гэж харж байгаа юм.

**Г.Занданшатар:** Бөхчулууны Пүрэвдорж тодруулъя.

**Б.Пүрэвдорж:** Своп хэлэлцээрээр нэлээн их хэмжээний юань урдаас авч байгаа. Тэгээд энэ чинь түр зуурын худалдааг санхүүжүүлэх түр зуурын л зохицуулалттай ийм л хөрөнгө. Хурдан төлбөр гүйцэтгэгчдэд зориулагдсан. Гэтэл энэ чинь 10 хэдэн жил үргэлжлээд явж байна. Энэ одоо своп хэлэлцээр дээрээ энийгээ барагдуулах талаар ямар ямар арга хэмжээг ойрын үед авах юм бэ. Своп хэлэлцээрээр авсан тэр валютыг яаж хэдэн хувь хүртэл багасгах юм. Хэр хэмжээнд хүргэх юм. Энэ чинь бас манай цааши цаашидын худалдаанд бас тодорхой үр нөлөө үзүүлэх ийм зүйл болчихоод байгаа. Энэ дээр хариулт авъя.

**Г.Занданшатар:** Бядрангийн Лхагвасүрэн. 83.

**Б.Лхагвасүрэн:** Пүрэвдорж гишүүний асуултад хариулъя. Хятадын Ардын банкттай своп хэлцлийг 2011 оноос хойш байгуулаад үргэлжлээд явж байгаа.

Нийт нийлбэр дүн нь 15 тэрбум юань. Тэрнээс хойш 2016 он хүртэл бол 12 тэрбумыг нь хэрэглэсэн, тэгээд 2016 оноос хойш бол ерөөсөө хэрэглээгүй байгаа. Т эгээд 12 тэрбумын өрийг бол сая энэ жил бол сунгасан. Тэгээд 2026 онд бол төлөхөөр яригдаж байгаа. Төв банкны зүгээс бол хэрвээ манай Монгол Улсын валютын нөөц 4 тэрбум доллароосоо илүү гараад тогтвортой байх тохиолдолд тодорхой хэмжээгээр төлөөд явъя гэдэг бас ийм бодлогыг баримтлахаар зорьж байна. Тэр утгаараа Үндэсний аюулгүй байдлын зөвлөл дээр ч зөвлөлийн үзэл баримтлал дотор ч гэсэн байж байгаа. Тодорхой хэмжээнд бас төлөх ёстой гэдгээрээ. Тэрнийхээ дагуу бол хэрвээ ирэх 2024 онд Монгол Улсын валютын нөөц 4 тэрбумаас илүү ийм өндөр хэмжээнд тогтвортой хэмжээнд байх юм бол энийг бага багаар төлөхөөр зорьж байгаа.

**Г.Занданшатар:** Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Одоо санал хураалт явуулна. За санал хураалтад бэлтгэе. Санал хураалтад бэлтгэх хооронд би нэг зүйл сануулах асуухад Монголбанкны хэвлэлийн төлөөлөгч Дагвадоржийн Ариунаа. Улсын Их Хурал мөнгөний бодлого баталдаг. Баталсан хууль тогтоомжийнхоо хэрэгжилтийг хянаж шалгадаг, шаарддаг, шахдаг үүрэгтэй. Тэгээд яагаад Улсын Их Хурлын гишүүдийг Монголбанкны хараат бус байдалд халдлаа гээд жиргээд яриад байнгын тийм юм явуулаад байдаг юм бэ. Үүнийхээ албан ёсны тайлбарыг ирүүлээрэй. Энэ бол хууль тогтоогчдын бүрэн эрхийн асуудалд хамаардаг бөгөөд Үндсэн хуулиар болон Улсын Их Хурлын тухай хууль, холбогдох бүх хуулиудаар төсөв мөнгөний бодлогын үндсийг хэлэлцэж батлах, түүний хэрэгжилтийг хянан шалгах шаардах ийм үүрэгтэй байдаг юм шүү дээ. Энэ талаар та тайлбараа ирүүлээрэй. Таны талаар гишүүдээс маш олон материал ирсэн. Санал хураалт явуулъя.

“Төрөөс мөнгөний бодлогын талаар 2024 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна.

1.Тогтоолын төсөлд 2 дугаар заалт нэмэх:

“2.Доор дурдсан арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/, Монголбанк /Б.Лхагвасүрэн/, Санхүүгийн зохицуулах хороо /Д.Баярсайхан/-нд тус тус даалгасугай:

1/Засгийн газраас эрх зүйн орчныг бүрдүүлж, орон сууцны ипотекийн хөтөлбөрийг шилжүүлэн авах хүртэлх хугацаанд хөтөлбөрийн тасралтгүй байдлыг хангаж, зээлийн эргэн төлөлтөөс санхүүжүүлэх;

2/Орон сууцны ипотекийн хөтөлбөрийн хүрээнд олгох зээлийн нийт эх үүсвэрийг нийслэл, орон нутагт тэнцүү хуваарилах;” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Чинбатын Ундрэм, Ганибалын Амартүвшин, Баагаагийн Баттөмөр, Хассуурийн Ганхуяг, Тогмидын Доржханд, Содномын Чинзориг. Пүрэвдорж гишүүн үг хэлнэ.

**Б.Пүрэвдорж:** Тэгэхээр 2012-2016 онд 98 мянган айл орон сууцтай болсон. Үндсэн гол хөрөнгө оруулалт бол ипотекийн зээл байсан. Энийг 2016 онд МАН гарч ирээд багасгасан. Хэт бага түвшинд аваачсан. Тэгээд энэ хооронд яасан бэ гэхээр жилдээ 3000-4000 айлын ипотекийн зээл гаргадаг. Тэр нь дандаа дарга нарын хамаатанд очдог. Аль эсвэл авлигал чинь ерөөсөө төрийн байгууллагаасаа гараад хувийн хэвшил рүү орчихсон. Тэрний нэг жишээ бол ипотекийн зээлийг арилжааны банкнууд олгож байгаа. Тэндхийн зээлийн эдийн засагч, тэндхийн дарга нарын бас тодорхой хувийг нь өгч байж 10 хувь, 20 хувийг нь өгч байж ипотекийн зээл

гардаг ийм зүйл рүү явчихсан байгаа. Тийм учраас энэ дээр ялангуяа тэр 620 тэрбум төгрөг гарна гэдэг чинь ойролцоогоор 16 мянган айлын ипотекийн зээл гарна гэсэн үг байхгүй юу даа. Энэ бол маш зөв. Эдийн засагт сайн дохио авчрах, ялангуяа барилгын салбар борлуулалт зогсчихсон энэ үед бол барилгын салбарыг дэмжсэн маш олон ажилтантай тэр салбарыг дэмжиж байгаа сайн зүйл. Тэгэхээр энийг хэрэгжилт дээр нь арилжааны банк дээр очоод авлига авдаг барьдаг энэ зүйлийг нь зогсоох талаар маш тийм хатуу хяналттай ажиллаарай гэж Монголбанканд хэлж зөвлөмөөр байна. 620 тэрбум төгсгөл. Үүний чинь бараг 300 тэрбум нь бол урд талынхаа нөгөө ипотекийн зээлээсээ төлөлтөөрөө орж ирж байгаа тэр төлөлтөөрөө бас төлөгдөөд явж байгаа. Ер нь бол 2012-2016 онд гарсан ипотекийн зээл чинь бүгдээрээ буцаад төлөгдөөд ороод ирчихсэн гэсэн үг. Тэгэхээр зарим хүмүүс ипотекийн зээл дээр бас хэтэрхий өрөөсгөл хандлагатай байдаг. Өөрөөр хэлбэл 2012 онд Улаанбаатар хотын төвд 2 сая төгрөгөөр авсан байр өнөөдрийн байдлаар 6 сая төгрөг болчихсон байж байгаа. 6 сая төгрөг болж байгаа. Тэр хэрээр хани уналт бий болсон гэсэн үг. Гэтэл энэ ипотекийн зээлээс болоод л бүгдээрээ ядуурч байгаа юм шиг болдог. Яг авах болохоороо ипотекийн зээл шиг хэрэгтэй зүйл байхгүй. Өөрөөр хэлбэл ганц байгаа тэр зээлийн эх үүсвэрийг нь ашиглаад байртай болцоодог, авсныхаа дараа тэрийгээ үзэн яддаг ийм зүйл байж болохгүй. Хэрвээ тэр тухайн үеийн банкны дундаж зээлийн хүүгээр 14, 15 хувиар ипотекийн зээлийг авсан бол тэр айлууд бүгдээрээ дампуурчихсан байж байгаа. Тэгэхээр мэдээж энэ дээр тодорхой хэмжээний эргэн төлөлтийн харьцаа, зээлийн хүүгийн төлөлтийн харьцаа энэ тэр дээр бас тодорхой арай илүү тэр зээл төлж байгаа тэр хүмүүстэй боломжтой хэлбэрээр гаргаж өгөх тэр.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Энэ саналтай шууд холбоотой гэхээсээ илүү ерөнхий ипотекийн зээлийн асуудал байна. Тэгэхдээ энэ дээр хуулийн зөрчилтэй асуудал байна. Энэ санал хураалтыг яах ёстой юм. Засгийн газраас эрх зүйн орчныг бүрдүүлж, ипотекийн хөтөлбөрийг шилжүүлж авна гэж байхгүй шүү дээ. Эрх зүйн орчныг чинь хууль тогтоох Улсын Их Хурал л эрх зүйн орчин бүрдүүлдэг болохоос биш Засгийн газар эрх зүйн орчныг бүрдүүлж гээд хэлчихээр чинь энэ чинь. Дэмжиж үг хэлж болно. Содномын Чинзориг Эрүүл мэндийн сайд, Улсын Их Хурлын гишүүн үг хэлнэ.

**С.Чинзориг:** Тэгэхээр зарчмын зөрүүтэй саналыг гаргасан юм. Ажлын хэсгийн гишүүний хувьд. Тэгээд энэ дээр гишүүдэд бас нэг зөв ойлголт өгөхгүй бол сая даргын хэлээд байгаа найруулгын асуудал байж магадгүй гэж бодоод байгаа юм. Яагаад ийм зайлигүй санал оруулах болсон бэ гэхээр өнгөрсөн жил 2023 оны төрөөс мөнгөний талаар баримтлах бодлогын бичиг баримт батлахдаа тогтоолд 2023 оны эхний хагас жилд багтааж Засгийн газар энэ ипотекийн хөтөлбөрийг шилжүүлэн авах гээд тогтоолд орчихсон юм. Тэгээд одоогоор энийг чинь Засгийн газар аваагүй байгаа юм. Бэлтгэл ажил шаардлагатай эд нар гээд байгаа юм.

2 дугаарт Засгийн газар шилжүүлж аваагүй Монголбанк цаашаа үргэлжлүүлэх эсэх нь тодорхойгүй байгаа учраас Мөнгөний бодлогынхоо баталсан тогтоол дотор нь эрх зүйн орчин нь бүрдэж орон сууцны ипотекийн хөтөлбөрийг Засгийн газар шилжүүлэн авах хүртэл хугацаанд гээд найруулаад авчихмаар юм байна. Дарга аа, Засгийн газар шилжүүлэн авах хүртэл хөтөлбөрийг тасралтгүй байдлыг хангаж хэрэгжүүлж байж тэгээд эх үүсвэрийг шийдэх гээд оруулчихаар бас гишүүд болгоомжлоод байгаа юм. Мөнгө хэвлэх эрх зүйн орчин бүрдүүлж өгнө гээд. Тийм учраас тэр саналыг нь

өөрчлөөд эргэн төлөлтөөсөө санхүүжүүлж бай гэсэн ийм заалт оруулсан юм. Ингэж явахгүй бол өнгөрсөн жилийн тэр тогтоолд Засгийн газар шилжүүлж авч хэрэгжүүл гээчихсэн, тэгээд одоогоороо шилжүүлж аваагүй. Тэгээд Засгийн газар хэрэгжүүлэх үү, Монголбанк хэрэгжүүлэх үү эсэх нь тодорхойгүй энэ хөтөлбөр чинь өөрөө ийм зогсонги байдалд орчих гээд байгаа юм. Тийм учраас эрх зүйн орчныг бүрдүүлж, орон сууцын ипотекийн хөтөлбөрийг Засгийн газар шилжүүлэн авах хүртэлх гээд найруулгаар аваад явчихвал болох болов уу гэж л бодож байна дарга аа. Тэгэхгүй бол тодорхойгүй үлдчих гээд байх юм.

**Г.Занданшатар:** Үгүй ээ, тогтоол хуульд нийцэх ёстой л доо. Хуульд нь Монголбанк төсвийн шинж чанартай үйл ажиллагааг санхүүжүүлэхгүй гээд хууль баталчихсан шүү дээ. Банкны хууль Баттөмбөр гишүүн санаачлаад. Тэгэхээр чинь эрх зүйн орчныг бүрдүүлж байж тэгнэ гэж юм батлаад байх юм бол тэгээд Засгийн газраас гэх юм бол энэ чинь бүр хуулийн зөрчилтэй болчихоод байна л даа. Яах вэ, эргэн төлөлтөөс гэх юм бол бараг эрх зүйн орчин ч бүрдүүлэх шаардлагагүй. Үгүй ээ, би одоо ийм Үндсэн хуулийн зөрчилтэй юм хураалгаж чадахгүй ээ. Гүйцээн боловсруулах чиглэл өглөө.

Энэ дээр чинь эрх зүйн орчныг Засгийн газар бүрдүүлээд шилжүүлж авна гэх юм бол энэ чинь хэзээ ч хэрэгжихгүй шүү дээ.

2 тогтоолын төслийн 2 дугаар заалтад доор дурдсан агуулгатай 3 дугаар дэд заалт Тх. Цолмон Чинзориг сайд Улсын Их Хуралд хүндэтгэлтэй хандана шүү. Тх хууль дээдэлж ажиллана гэж тангараг өргөсөн хүн шүү та үзэмжээр биш, үгүй ээ би ёс зүйн хувьд тийм төсөв батлахгүй гэж хэлсэн. Та нөгөө миний эрхэнд бас халдах эрх байхгүйбайх юм бол өөрөөр ярина шүү зүгээр үгүй ээ ЗГ эрх зүйн орчныг

бүрдүүлье гэж та хуй төсөл санаачилчаад юу яриад байгаа юм бэ? Үгүй ээ тийм буруу юм санаачилчаад тэгээд тэрнийгээ засдаг байсан юм бол байнгын хороон дээр засаж орж ирэхгүй бол их хурал дээр энийг чинь өөрчлөх эрх байдаггүй юм гаргаад гарсан саналыг чинь тэгээд гүйцээн боловсруул гэж хэллээ. Тэгвэл энийгээ татаж ав тэгвэл гүйцээн боловсруулах шаардлагагүй юм байна үндсэн хуулийн зөрчилтэй саналыг хураалгахгүй байх хэрэгтэй. Би тэгвэл гүйцээн боловсруулахаа больё бүр тэгж ЗГ-аас эрх зүйн орчин бүрдүүлнэ гэж юу байх юм бэ? ЗГ хууль батлахгүй шүү дээ та та өөрөө тэгж биччихээд тэгээд томьёоллоо хянаж үзэж байж наадхаа оруулж ирэх хэрэгтэй шүү дээ ЗГ-ыг хууль батал гэж үүрэг өгч болохгүй шүү дээ энэчээ чинь ЗГ-т даалгах нь эрх зүйн орчныг бүрдүүл гэж хэлэх журмаар шийдэхгүй байна. Энэ чинь хуультай юм чинь.

Содномын Чинзориг сайд Улсын Их Хуралд хүндэтгэлтэй хандана шүү. Хууль дээдэлж ажиллана гэж тангараг өргөсөн хүн шүү та. Үзэмжээр биш. Би ёс зүйн хувьд тийм төсөв батлахгүй гэж хэлсэн. Та миний эрхэнд бас халдах эрх байхгүй. Ингээд байх юм бол өөрөөр ярина шүү. Засгийн газар эрх зүйн орчинг бүрдүүлж гэж та төсөл санаачилчихаад юу яриад байгаа юм бэ. Тийм буруу юм санаачилчихаад тэрийгээ засдаг байсан бол Байнгын хороо дээр засаж орж ирэхгүй бол Их Хурал дээр энийг чинь өөрчлөх эрх байдаггүй юм. Гүйцээн боловсруул гэж хэллээ. Тэгвэл энийгээ татаж ав тэгвэл. Гүйцээн боловсруулах шаардлагагүй юм байна. Үндсэн хуулийн зөрчилтэй саналыг хураалгахгүй байх эрхтэй би. Тэгвэл бүр гүйцээн боловсруулахаа больё. Засгийн газраас эрх зүйн орчинг бүрдүүлнэ гэж юу байх юм бэ. Засгийн газар хууль батлахгүй шүү дээ. Та өөрөө тэгж биччихээд. Тэгээд томьёоллоо хянаж үзчихээд оруулж ирэх хэрэгтэй шүү дээ. Засгийн газрыг хууль батал гэж үүрэг өгч болохгүй шүү дээ. Засгийн газарт



даалгах нь. Эрх зүйн орчныг бүрдүүл гэж. Журмаар шийдэхгүй, энэ чинь хуультай юм чинь.

2.Тогтоолын төслийн 2 дугаар заалтад доор дурдсан агуулгатай 3 дугаар дэд заалт нэмэх:

“3/Агаар, орчны бохирдлыг бууруулах, төвлөрлийг сааруулах бодлоготой уялдуулан эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууц, гэр хорооллын барилгажуулалтад олгох ипотекийн зээлийн хэмжээг хөтөлбөрийн нийт эх үүсвэрийн 20 хүртэл хувьд хүргэх арга хэмжээ авах.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал санал байхгүй. Дэмжсэн дэмжээгүй үг л хэлж болно. Сандагийн Бямбацогт гишүүн. Тэгээд сайд нар үг хэлээд байх тусмаа л юмнуудаа унагаана шүү.

**С.Бямбацогт:** Баярлалаа. Агаар орчны бохирдлыг бууруулах төвлөрлийг сааруулах бодлоготой уялдуулан эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууц гэж байгаа юм. Эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууц гэдэг дээр бас цаад талын агуулга нь уг нь бид нөгөө дэд бүтцийн шугам сүлжээнд холбогдсон Монгол Улсын Их Хурлын нөгөө 2024 оны төсвийн тухай хууль батлахдаа бид дагасан Их Хурлын тогтоол дээр бол дэд бүтцийн сүлжээнд холбогдсон гэж орсон. Өөрөөр хэлэх юм бол утаа гаргахгүй, гал түлэхгүй, агаар бохирдуулахгүй, жорлон ухааж хөрс бохирдуулахгүй ийм нөхцөлтэй. Тэгэхгүй зөвхөн эрчим хүчний хэмнэлттэй гэх юм бол энд чинь бас дахиад л нөгөө хөрс бохирдуулах асуудал чинь байж байгаа юм. Энэ агуулгаар нь та бүхэн бас ойлгоод бас эцсийн хэлэлцүүлэг дээр анхаараач ээ. Өөрөөр хэлэх юм Монгол Улсын төрийн бодлого байдаг. Яаж агаар орчны бохирдлыг бууруулах вэ гэж байгаа юм. Утаа гаргамааргүй байна, гал түлмээргүй байна, жорлон ухааж хөрс бохирдуулмааргүй байна. Тийм агуулгаар нь ингэж Төсвийн тухай хуулийг дагасан тогтоолд орсон, түүнтэй нийцүүлээд

энийг бас өөрчлөөч ээ. Энийг өөрчлөх талаас нь анхаараач ээ. Дэмжиж байгаа. Энийг бас гүйцээн боловсруулах чиглэлээр байдаг юм уу энийг анхаараад өгөөч ээ гэсэн саналтай байгаа.

Эхний асуудал дээр бас яах аргагүй бас зовлонтой байгаа юм аа. Ипотекийн зээл үнэхээр одоо Монголын орон сууцгүй иргэдэд хамгийн чухал эрэлттэй, хамгийн чухал асуудал болсон, болж байгаа. Тийм ч байсан. Цаашидаа ч байна. Идэх, өмсөх, амьдрах гэсэн 3 хэрэгцээ байдаг бол амьдрах хэрэгцээ орон сууц. Энийг хямд хүүтэй, бага хүүтэй, хамгийн найдвартай ипотекийн зээлээр л орон сууцтай болгох энэ бодлогоо бид нар, төр бас цааш нь авч явмаар байгаа. Энэ дээр Монголбанк хуучин бол ипотекийн зээлийн эх үүсвэр шийддэг байсан. Энийг бас манай Их Хурал дээр ярьж байгаад л тэгээд л гишүүд бас хууль зөрчиж байна гэж байгаад л өнгөрсөн жилийн тогтоолд нэг сонин юм оруулчихсан шүү дээ. Түүнээс бол Монголбанк өгөх хэцүү, өгөхгүй хэцүү. Засгийн газар авчих гэхээр Засгийн газар авдаггүй бас Сангийн яам бид авахгүй, бид хариуцахгүй гээд. Ингээд дунд нь үндсэндээ ипотекийн зээл эзэнгүй хаягдчих гээд байгаа юм.

**Г.Занданшатар:** Санал хураалт явуулъя. Тийм шүү дээ. Одоо эко энэ тэр гэж л нэрлэдэг байх л даа. Яах вэ, одоо тийм агуулгаар л биччихсэн юм байна. Санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураачихсан. Санал дэмжигдсэнгүй.

3.Тогтоолын төслийн хавсралтын 1 дүгээр заалтад доор дурдсан агуулгатай 1.3 дахь заалт нэмэх:

“1.3.Эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангаж, ажлын байрыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор бизнесийн зээлийг нэмэгдүүлэх, хэрэглээний зээлийн хэт өсөлтөөс сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх;” Санал гаргасан ажлын хэсэг.

*Бөхчулууны Пүрэвдорж гишүүн.*

**Б.Пүрэвдорж:** ЖДҮ-лэлийг хөгжүүлэх санд энэ жил 27,4 их наяд төгрөгийн төсөв баталчхаад, ЖДҮ-лэлийг хөгжүүлэх санд 20 тэрбум төгрөг хуваарилсан шүү дээ. Энэ бол дэндүү бага даа. Тэгээд үнэхээр төсвөөрөө дамжуулж ЖДҮ-лэлийг болон чөлөөт зах зээлийг сайн дэмжсэн орнууд л хөгжиж байгаа. Гэтэл я энэ төрлийн хөрөнгө оруулалт ерөөсөө бизнесийг дэмжсэн тийм дэмжлэг энэ 2024 оны төсөв дээр чинь огт байхгүй байсан. 20 тэрбум юу ч биш. Тэгэхээр 2024 онд сонгууль болно. Мэдээж өөрчлөгдөнө. 2025 оны төсөв батлахад Туркийн жишээг энэ төсөв дээр оруулж ирэх хэрэгтэй. Өөрөөр хэлбэл Турк төсвөөрөө дамжуулаад ЖДҮ-лэл эрхэлсэн, тэндээс гарсан бүтээгдэхүүн нь худалдааны сүлжээгээр ороод, татвараа татвартаа тайлагнасан бол тэр авсан тэр ЖДҮ-лэлийн авсан зээлийн хүүг нь төсвөөсөө төлж нэлээн олон жил явсны үр дүнд өнөөдөр Турк бол ЖДҮ-лэлээр маш их өндөр хэмжээнд очсон. Ер нь Европыг тэр чигээр нь ЖДҮ-лэлийн бүтээгдэхүүнээр хангаж байгаа юм. Хятадаас илүү гарчихсан байгаа. Тийм учраас яг энэ сантай холбоотой асуудал дээр нэлээн оайдастай байдаг учраас энэ ЖДҮ-лэлийн зээлийг 20 тэрбумаар тавьсан байх. 2025 оны төсөв дээр бол ер нь бол жалгаар 1 тавьж байгаа хөрөнгө оруулалтыг бүгдийг нь хааж байгаад, шинэ хөрөнгө оруулалт улсын төсөв.../минут дуусах/

**Г.Занданишатар:** Энэ заалтыг дэмжсэн, дэмжээгүйтэй холбоотой үг биш байна. Төсөвтэй холбоотой байна. Санал хураалт явуулья. 57,8 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

4.Тогтоолын төслийн хавсралтын 2 дугаар заалтад доор дурдсан агуулгатай 2.4 дэх заалт нэмэх:

“2.4.Банкнаас жижиг, дунд бизнест олгосон зээлийг ангилах, ангилал

дээшлүүлэх, түүний бүтцийг өөрчилж, дахин санхүүжүүлэх зохицуулалтыг эрсдэлд суурилсан хяналт шалгалтын зарчимд тулгуурлан уян хатан болгох ажлыг судлан шийдвэрлэх;” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт 55,6 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

5. Тогтоолын төслийн хавсралтын 3 дугаар заалтад доор дурдсан агуулгатай 3.3 дахь заалт нэмэх:

“3.3.Тогтвортой хөгжлийн зорилтын таксономид органик хүнсний тариалалт, үйлдвэрлэлийн үйл ажиллагааг тодорхой тусгаж, төрийн дэмжлэгтэй хэрэгжиж буй зээл, санхүүжилтийн хөтөлбөрүүдийн багцын тодорхой хэсгийг тухайн таксономитой уялдуулан ногоон, тогтвортой зээл гаргадаг болох чиглэлээр санхүүгийн байгууллагуудтай хамтран ажиллах;” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Содномын Чинзориг гишүүн өөрийнхөө гаргасан саналыг өөрөө ойлгохгүй байгаа юм уу даа. Таны нэр бичээд байна шүү дээ. Ажлын хэсэг гээд. 59,1%-ийн саналаар санал дэмжигдлээ. Ажлын хэсэг дээрээ сайн ярьж бай Чинзориг сайд аа.

6.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн бүтэц, нэр томьёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаар, эшлэлийг нийцүүлж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг санал хураалт. 59,1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Ажлын хэсгийн горимын санал гэж байхгүй байгаа. Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хурааж дууслаа.

“Төрөөс мөнгөний бодлогын талаар 2024 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын

тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлж байна.

15.36 цаг.

**Дараагийн асуудалд орно. Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэнэ. Анхны хэлэлцүүлэг явуулна.**

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүйн байнгын хорооны дарга Дамдины Цогтбаатар танилцуулна. Амьтны тухай хуулийн асуудлаар. Дамдины Цогтбаатар Хууль зүйн байнгын хорооны даргыг индэрт урьж байна.

**Д.Цогтбаатар:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр нарын 3 гишүүнээс 2022 оны 9 дүгээр сарын 26-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурал 2023 оны 4 дүгээр сарын 6, 7-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлсэн.

Тус байнгын хороо 2023 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн 5 дугаар тогтоолоор дээрх хуулийн төслүүдийг Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн Цогтбаатараар ахлуулан, Улсын Их Хурлын гишүүн Аубакир, Батиугар, Дамдиням, Туваан нарын бүрэлдэхүүнтэйгээр байгуулж ажилласан.

Хуулийн төсөлд иргэдийн оролцоог хангах, санал авах зорилгоор Улсын Их Хурлын D-Parliament.mn цахим системээр дамжуулан олон нийтээс тухайн төсөлтэй холбогдуулан санал авахад нэр бүхий иргэдээс 18 санал ирүүлснийг ажлын хэсэгт танилцуулсан болно.

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо 2023 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн хуралдаанаараа хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10 дахь хэсэгт заасны дагуу явуулж дараах санал, дүгнэлтийг та бүхэнд танилцуулж байна.

Гэрийн тэжээвэр амьтантай холбоотой харилцаанд баримтлах зарчимд Монголын ард түмний үндэсний уугуул үүлдрийн нохойг гэршүүлэн тэжээж ирсэн өвөрмөц аж төрөх ёс, түүхэн уламжлалыг хадгалах, нандигнан өвлүүлэхээр баг, хорооны Засаг дарга, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллага, Мал эмнэлгийн үйлчилгээний нэгж нь бичил чин унших төхөөрөмжтэй байхаар, нохой муур үржүүлэх үйл ажиллагааг зөвшөөрөл авсан ашгийн төлөө хуулийн этгээд эрхлэхээр, хүүхдийн цэцэрлэг, бүх шатны сургууль, сургуулийн дотуур байр, эмнэлэг, сувиллаас 200 метрийн дотор нохой, муур үржүүлэх үйл ажиллагаа явуулахгүй байх. Хөдөө орон нутагт амьдарч байгаа нохой, муурын асран хамгаалагч нь хот суурин газрын нохой, муурын асран хамгаалагчийн нэгэн адил сургалтад хамрагдах шаардлагагүй зэрэг зарчмын зөрүүтэй болон найруулгын нийт 53 санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн Наранбаатар, Батжаргал, Энхтүвшин нар хуулийн төсөл болон зарчмын зөрүүтэй саналын

томьёололтой холбогдуулан асуулт асууж, хариулт авсан болно.

Байнгын хороо зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг нэг бүрчлэн хэлэлцэн санал хураалт явуулсан бөгөөд зарчмын зөрүүтэй саналын томьёолол болон анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

**Л.Мөнхбаатар:** Цогтбаатар даргад баярлалаа. Хэлэлцээж байгаа асуудалтай холбогдуулан чуулганы нэгдсэн хуралдаанд оролцож байгаа ажлын хэсгийг танилцуулъя.

Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтсийн дарга Идэрийн Батчулуун, Мал эмнэлгийн ерөнхий газрын Мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах газрын дарга Бямбын Болдбаатар, УБЗАА-ны Орчны бохирдол хог хаягдлын удирдлагын хэлтсийн дарга Батбаярын Мөнх-Эрдэнэ, Нийслэлийн Мал эмнэлгийн газрын Мал, амьтны эрүүл мэндийн хэлтсийн дарга Цэдээгийн Гантөмөр, УБЗАА-ны Орчны бохирдол хог хаягдлын удирдлагын хэлтсийн мэргэжилтэн Бандийн Мөнхжаргал, Азтай савар ТББ-ын тэргүүн Цогийн Зориглон, Азтай савар ТББ-ын зохицуулагч Эрдэнэбатын Бүжинлхам, Азтай савар ТББ-ын удирдах зөвлөлийн гишүүн Цэвэлмаагийн Болормаа, Азтай савар ТББ-ын Эрх зүйч Энхбаярын Анударь, Эм Ди Эс энд Хаан Лекс хуулийн фирмийн Хуульч Мөнгөний Ариунзул,

Өмгөөллийн Легалгайд хуулийн фирмийн Хуульч Нямдоржийн Баясгалан, Монгол нохой судлалын төвийн үүсгэн байгуулагч Дэлгэрийн Цэрэнханд, Монголын нохой судлалын холбооны тэргүүн Амгаланбаатарын Наранбаяр нар оролцож байна.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу. Алга байна. Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураана. Гишүүд танхимдаа орж ирье. Асуулт асуух нэрсээ аваад дууссан.

Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалтыг маргааши өглөөний 10 цагт явуулна. 10 цагаас санал хураалтыг явуулъя.

Өнөөдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул чуулганы нэгдсэн хуралдаан өндөрлөснийг мэдэгдье. Ажлын хэсэгт баярлалаа.

15.44 цаг.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС  
ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ  
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН:  
ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ